



НИЙГЭМ БА ҮНЭТ ЗҮЙЛС

АНУ-ЫН
КОЛЛЕЖ, ИХ СУРГУУЛИЙН
БОЛОВСРОЛ



2005 ОНЫ 11 САР

АНУ-ЫН ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТ/ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧОО

НИЙГЭМ БА ҮНЭТ ЗҮЙЛС



Ерөнхий эрхлэгч Майкл Сиденстрайкер
Ерөнхий редактор Робин Л. Ийгер
Орлогч эрхлэгч Майкл Жей Фридман
Розали Таргонски
Лавлагааны мэргэжилтэн Мэри Анн Гэмбл
Кэти Шпигель
Хавтасны чимэглэлийг Диан Вулвертон
Гэрэл зургийн редактор Анн Монро Якобс

Нийтлэгч Юдит Сигель
Ахлах редактор Жорж Клак
Хариуцлагатай нарийн бичгийн дарга Ричард В. Хакаби
Үйлдвэрлэлийн менежер Кло Эллис
Үйлдвэрлэлийн менежерийн орлогч Кристен Ларсон
Редакцийн зөвлөл Александр С. Фельдман
Жереми Е. Куртин
Кэтлин Р. Дэвис
Кара Галлес

Хавтасны гэрэл зураг: Брайан Маквэй/Такси/Геттийн дүрслэл

АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын Мэдээллийн хөтөлбөрийн Товчоо АНУ цахим сэтгүүл нэртэй Эдийн засгийн хэтийн төлөв, Дэлхий дахины асуудлууд, Ардчиллын асуудлууд, Гадаад бодлогын тулгамдсан асуудлууд, Нийгэм ба үнэт зүйлс гэсэн таван төрлийн цахим сэтгүүл гаргаж байна. Эдгээр нь АНУ-д болон олон улсын хамтын нийгэмлэгт болон АНУ-ын нийгэм, үнэт зүйлс, санаа бодол, байгууллагуудад тулгарч буй чухал асуудлуудыг. Дээрх таван сэдэв нэг бүрийг боть (нийтлэгдсэн оны дугаар) болон дугаар (нэг жилд гарсан дугаарын тоо)-аар нь зүйлчлэн ангилдаг.

Сэтгүүлийн шинэ дугаар сар бүр англи хэл дээр нийтлэгддэг бөгөөд 2-4 долоо хоногийн дараа франц, португал, орос, испани хэл дээрхи хувилбар нь гардаг. Шаардлагатай бол зарим тусгай дугааруудыг араб, хятад болон бусад хэлээр мөн нийтлэдэг.

Сэтгүүлд илэрхийлэгдсэн санал дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно. АНУ-ын Төрийн Департамент сэтгүүлийн агуулга болон түүнтэй холбогдолтой интернэт сайтуудын талаар хариуцлага хүлээхгүй. Эдгээр сайтын хариуцлагыг зөвхөн нийтлэгчид нь хүлээнэ. Сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл, гэрэл зураг болон зураглалуудад зохиогчийн эрхтэй холбогдолтой хориг тавиагүй бол АНУ-аас гадагш бусад оронд орчуулж буюу хуулбарлан хэвлэж болох бөгөөд хориг тавиагүй тохиолдолд тус сэтгүүлд заасан зохиогчийн эрхийг эзэмшигчдээс нь зөвшөөрөл авах ёстой.

Олон улсын Мэдээллийн хөтөлбөрийн Товчоо сэтгүүлийн тухайн болон хуучин дугааруудын эхийг, мөн хэвлэгдэж гарах сэтгүүлүүдийн жагсаалтыг <http://usinfo.state.gov/journals/journals.htm> сайтад хэд хэдэн янзын электрон хэлбэрээр хадгалдаг болно. Санал, дүгнэлтээ өөрийн оронд байгаа АНУ-ын ЭСЯ буюу сэтгүүлийн редакцид доорхи хаягаар ирүүлнэ үү.

АНУ: Нийгэм ба үнэт зүйлс цахим сэтгүүлийн эрхлэгч
IP/T/SV
АНУ-ын Төрийн Департамент
301 4th St. S. W
Washington D.C. 20547
United States of America
E-mail: ejvalues@state.gov

ТААЛАН БОЛГООНО УУ



АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Карен Хюгес

АНУ цахим сэтгүүл-ийн энэ дугаарыг таалан болгоно уу. АНУ-ын дээд боловсролын талаар сонирхон судалж байгаад тань талархал илэрхийлье. АНУ бол суралцах, сурч мэдэх агуу их боломжтой газар юм. Хүү маань өнгөрсөн намар коллежид орсон болохоор энэ нь оюутнууд, тэдний гэр бүлийнхний хувьд ямар сэтгэл хөдлөм мөч байдгийг би мэднэ. Та том, жижиг, эсвэл дунд зэргийн ямар ч сургуульд суралцах хүсэлтэй байлаа гэсэн таны хувьд сонголт хийх үнэхээрийн хязгааргүй их боломж АНУ-д бий. Энэ талаарх судалгаагаа эхлэхэд тань энэ сэтгүүл тус болно гэж бид найдаж байна.

Эрдэм ном сурах бололцоо нь АНУ-д суралцах асуудлыг авч үзэх учир шалтгааны зөвхөн нэг нь юм. Оюутнууд энд оюуныхаа эрэлт хэрэгцээг хангах, улс төрийн маргаан мэтгэлцээн өрнүүлэх, шашны болон урлаг соёлын үзэл бодлоо ил, чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө эдэлдэг. Мөн энд суралцсанаар өөр өөр соёл, уламжлалтай янз бүрийн орны оюутнууд өөр хоорондоо нөхөрлөж, харилцан ойлголцох боломжоор хангагддаг.

АНУ-ын бараг бүх коллеж, их дээд сургуульд гадаадын оюутнуудын хандив тус нэмэр болдог. 2004-2005 оны хичээлийн жилд АНУ-ын оюутны хотхондуудад дэлхийн 190 орны 565 мянга гаруй оюутан суралцсан байна. Түүнчлэн Америкийн олон их сургууль гадаад хөтөлбөрийнхөө дагуу оюутнуудаа гадагш нь явуулж сурган, мэдлэгийн хүрээг нь тэлэх, бусад соёлын баялаг өвөөс суралцуулах явдлыг тэтгэн дэмжиж байна.

Цахим сэтгүүлийн энэ дугаар АНУ-д суралцах гадаадын оюутнуудын дараачийн үеийн нэгэн төлөөлөгч болох шийдвэр гаргахад тань танд туслана гэдэгт бид найдаж байна. Бид таныг тавтай морилно уу хэмээн урьж байна!

Гүнээ хүндэтгэсэн,

Карен Хюгес
Төрийн нарийн бичгийн даргын ардын дипломат,
олон нийтийн асуудал эрхэлсэн орлогч

ТАНИЛЦУУЛГА

Маргарет Спеллингс
Боловсролын сайд



Боловсролын сайд Маргарет Спеллингс

Америкийн дээд боловсролын тогтолцоог сонирхож байгаад тань би талархлаа илэрхийлж байна. Бид их дээд сургууль, коллежуудаараа бахархдаг. Ирээдүйн дэлхийн удирдагчдыг тэд сурган хүмүүжүүлж байгаа юм.

Жил бүр дэлхийн өнцөг булан бүрээс хэдэн зуун мянган оюутан АНУ-д суралцахаар ирж байна. Гадаадын оюутнууд бүх оюутны хувьд коллежийнх нь амьдралыг баяжуулах, онцлог шинж төрх, өөрсдийн гэсэн хувь нэмрээ авчирдаг билээ.

АНУ-ын дээд боловсролын тогтолцоо бусад орныхоос өөр юм. АНУ дээд боловсрол нь төвлөрсөн бус тогтолцоотой бөгөөд тэр нь оюутнуудад томоохон их сургууль, орон нутгийн коллежуудаас эхлээд техник-мэргэжлийн сургуулиуд хүртэл сонголт хийх өргөн боломж олгодог. АНУ-ын Боловсролын Департамент дээд боловсролыг дэмжин санхүүгийн туслалцаа үзүүлдэг боловч эрх мэдлийг өөртөө төвлөрүүлдэггүй. Их сургууль, коллежууд ихэвчлэн өөрийн гэсэн засаглалтай бөгөөд үйл ажиллагаагаа хараат бус байдлаар, ихээхэн эрх чөлөөтэй хэлбэрээр явуулдаг.

Энэ оны эхээр ууган охин маань коллежийн нэгдүгээр ангид орж суралцсан. Охин минь гэр орноо

орхин одохыг харахад надад гунигтай байсан хэдий ч энэ бол амьдралын маань хамгийн бахархалтай мөчийн нэг байсан юм. Бүх эцэг эхчүүд ийм бахархах сэтгэлээр бялхах боломжтой байгаасай гэж би хүсч байна. АНУ-ын Боловсролын Департаментын нэн тэргүүний нэг зорилго бол ийм боломжийг өргөтгөх явдал юм. Санхүүгийн туслалцаа авах замаар илүү олон тооны оюутан дээд боловсрол эзэмших мөрөөдлөө биелүүлэхэд нь бид туслах үүрэгтэй.

Саяхан би дээд боловсрол эзэмших боломжийг өргөжүүлэх үндэсний стратеги боловсруулах шинэ комисс байгуулсан. Өнөөгийн дэлхийн эдийн засагт хамгийн сайн мэргэшилтэй ажилчид хамгийн сайн ажил олж байна. Хамгийн хурдан өсч дэвжих боломжтой ажлын 80 орчим хувь нь дунд сургуулийн дараах тусгай боловсролтой байхыг шаардаж байна.

Тиймээс, коллежийн боловсрол эзэмших нь урьд хожид байгаагүйгээр нэн чухал болж байна. Америкийн Нэгдсэн Улсад дээд боловсрол эзэмших олон боломжийн талаарх ерөнхий төсөөллийг энэ сэтгүүл танд өгөх болно. Энэ сэтгүүл танд тус хүргэнэ гэж би найдаж байгаа бөгөөд хэрвээ танд асууж лавлах зүйл байвал <http://www.educationusa.state.gov> сайтад хандаарай.

ЭНЭ ДУГААРЫН ТУХАЙ

Олон янзын сургалтын байгууллагаас эхлээд үнэхээр хязгааргүй олон хөтөлбөр, мэргэжлийн гол хичээлүүд хүртэлх хүрээнд АНУ-ын их сургууль болон коллежуудын олон янз байдал, хүлээцтэй арга барил, гойд сайн болгохыг эрэлхийлэх эрмэлзэл нь улс орныг тодорхойлдог хамаг сайн сайхан шинжийн тусгал болж байгаа юм. Алсдаа ирж суралцах гадаадын оюутнууд, тэдний эцэг эх болон зөвлөх нар нь энэхүү сэтгүүлээс Америкийн дээд боловсролын тогтолцоо хийгээд АНУ-ын коллеж, их сургуулиудын оюутны хичээл сургууль, аж төрлийн талаар мэдлэг олж авах болно.

Химийн шинжлэх ухааны эрчимтэй хөтөлбөрөөр ч юм уу, дагалдангаар ажлын дадлага туршлага эзэмших ч юм уу, зайны сургалтаар, мөн Дэлхий дахины Вэб (www)-ийн өргөтгөсөн курс болон мэдээллийн эх сурвалжаар боловсролоо ахиулах, эсвэл мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх аль алинд нь АНУ-д суралцаж байгаа оюутнууд өөрийн боломж, чадвараа бүрэн ашиглаж чадахуйц сургалтын хөтөлбөр буюу сургуулийг олж чадна.

АНУ-ын дээд боловсролын тогтолцоо нь үндэсний хэмжээний тогтолцоо байдаггүйгээрээ бусад орныхоос ялгаатай. АНУ-ын Үндсэн хуулиар холбооны гэж онцлон тодорхойлоогүй засгийн газрын бүх чиг үүргийг муж улсууддаа олгосон байдаг. Тиймээс их сургууль болон дээд боловсролын сургалттай бусад байгууллагыг байгуулах, удирдах, үйл ажиллагааг нь зохицуулах үүргийг зарчмын хувьд муж улсууд хүлээдэг.

Муж улс сургуулиудад зөвшөөрөл олгодог боловч тэдгээрийг магадлан итгэмжилдэггүй буюу сургалтын чанарыг нь баталгаажуулдаггүй. Харин магадлан итгэмжлэх тогтолцоог хувийн, ашгийн төлөө бус байгууллагууд хэрэгжүүлдэг. Энэ сэтгүүлийн нэгэн тодруулга өгүүлэл энэ асуудалд чиглэгдсэн болно.

Сэтгүүлд АНУ-ын дээд боловсрол олгодог төрөл бүрийн сургуулийн талаарх тодорхойлолт, түүний араас зарим нэг их сургуулиудын тусгай хөтөлбөрүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үндсэн мэргэжлийн тухай ойлголт, коллежийн амьдрал, мөн Америкийн сургалтын хэв маягийн тухай өгүүлүүдийг оруулав. Бичмэл тайлбаруудыг илүү ойлгомжтой болгох үүднээс олон тооны гэрэл зураг, дүрс бичлэгүүдийг мөн оруулсан болно. Түүнчлэн бид сонгон шалгаруулах, өргөдөл хүлээн авахад баримтлах журам болон АНУ-ын


боловсролын тогтолцооны санхүүгийн асуудлыг сонирхож байгаа оюутнуудад зориулсан сурвалж мэдээллийг толилуулж байна. Education USA-ын Боловсролын зөвлөгөө өгөх Төвүүд болон тэдгээрийн [<http://educationusa.gov>] вэб-сайт эдгээр сурвалжийн дотроос хамгийн хэрэгцээтэй, хамгийн чухал нь юм. Шаардлагатай бүхий л бүртгэлийн маягтыг авч, бөглөж ирүүлэх болон шаардлагатай шалгалт, шүүлгийг өгөх боломжтой байхын тулд өргөдөл хүлээн авах эцсийн хугацаанаас наанадаж нэг жилийн өмнө хүсэлтээ гаргавал зохилтойг гадаадаас ирж суралцах боломжтой хүмүүст зөвлөж байна.

АНУ: Нийгэм ба үнэт зүйлс цахим сэтгүүлийн энэ дугаарыг эмхтгэхдээ бид оюутан хүнд коллежийн туршлага ямар чухал болохыг бодолцсон. Бидний хандаж байсан хүн бүр ялгаагүй өөрийн, эсвэл гэр бүлийнхнээс нь суралцаж байгаа буюу байсан коллежийнхаа тухай дурсаж бичнэ үү хэмээн бид санал болгож байв. Хүмүүсийн ийм ухаарал мэдрэмж зарим тохиолдолд олон жилийн дараа ч гэсэн өөрийгөө цааш хөгжүүлэх, оюуны сорилттой тулгарах болон хамт олноо эрэлхийлэх үед тань коллежид байхдаа туулж өнгөрүүлсэн амьдрал, туршлага бүхэн нэн чухал сануулга болсоор байдаг билээ.

АНУ дахь дээд боловсролын дүр зургийг аль болох бүрэн гаргаж толилуулахад маань бидэнд туслаж мэдээлэл, гэрэл зураг, өгүүлэл ирүүлж, энэхүү төслийг бахархалтайгаар дэмжсэн олон арван коллеж, их сургууль, боловсролын байгууллагуудад бид гүнээ талархаж байна. Гэхдээ тэдний ирүүлсэн мэдээлэл буюу гэрэл зургийг ашигласан явдал аливаа сургууль буюу байгууллагыг илүүтэйд үзэж дэмжиж байгаа гэсэн үг биш юм.

Америкчуудыг даяаршлын орчинд бэлтгэх, хилийн чанадаас ирээдүйн удирдагчдын сонирхлыг татаж, АНУ-д суралцуулах, туршлага солилцуулах хөтөлбөрийг дэмжих зорилгоор АНУ-ын Төрийн Департамент болон Боловсролын Департаментын хамтран санаачилсан Боловсролын долоо хоногийг тохиолдуулан бид энэхүү сэтгүүлийг бэлтгэн гаргалаа. Олон улсын Боловсролын Долоо хоног-2005 нь энэ оны арван нэгдүгээр сарын 14-19-нд болж байгаа юм.

Эрхлэгчид



НИЙГЭМ БА ҮНЭТ ЗҮЙЛС

АНУ-ЫН ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТ/2005 ОНЫ АРВАН НЭГДҮГЭЭР САР/БОТЬ 10/ДУГААР 2

www.usinfo.state.gov/journals/journals.htm

АНУ-ын коллеж, их сургуулийн боловсрол

i Таалан болгооно уу

КАРЕН П. ХЬЮЗ, Төрийн нарийн бичгийн даргын Ардын дипломат, олон нийтийн ажил эрхэлсэн орлогч

ii Танилцуулга

МАРГАРЕТ СПЕЛЛИНГС, Боловсролын сайд

iii Энэ дугаарын тухай

Сургуулийн төрлүүд

9 АНУ-ын муж улсын их сургууль

РОБЕРТ Х. БРУИНИКС, Миннесотагийн Их сургуулийн захирал

Муж улсын ердийн нэгэн их сургуульд хэдэн арван мянган оюутан хэдэн зуун төрлийн хичээл үздэг.

11 Эрдэм шинжилгээний томоохон, хувийн их сургууль гэж юу вэ?

ЖЕЙМС В. ВАГНЕР, Эморийн Их сургуулийн захирал

Хувь хүмүүсийн санхүүжилт судалгааны шинэ чиглэлд зоримог алхам хийх боломжийг хувийн сургуулиудад олгож байна.

13 АНУ-ын орон нутгийн коллеж: Олон хүний дээд боловсролд дэвших үүд

ЖОРЖ Р. БОГГС, Америкийн орон нутгийн коллежуудын Холбооны ерөнхийлөгч

Хоёр жилийн коллеж нь төрөлх хотынхоо нөхцөлд бага зардлаар суралцах хүсэлтэй оюутнуудын сонирхлыг татах хувилбар юм.

15 Олон талт байдлын давуу тал: АНУ-ын дээд боловсролын бие даасан салбар

РИЧАРД ЭКМАН, Бие даасан коллежуудын Зөвлөлийн ерөнхийлөгч

Хувийн жижиг коллежууд сургалт болон оюутан, эрдэмтэн багш нарын хоорондох харилцаанд анхаарлаа төвлөрүүлж байна.

17 Үндэсний цөөнхөд үйлчилдэг сургуулиуд

Байгууллагууд Африк, Латин Америк гаралтай америкчууд, Америкийн

индианчууд зэрэг үндэсний цөөнхөд онцгой анхаарал хандуулж байна.

19 Браунаас хойшхи 50 жил: Хар арьстнуудын түүхэн коллеж, их сургуулиуд (ХАТКИС) яагаад хэрэгтэй хэвээр байна вэ?

БИВЕРЛИ ДАНИЕЛ ТАТУМ, Спелманы Коллежийн захирал

Африк гаралтай америк оюутнуудын дунд бие хүн өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхэд ХАТКИС-ийн гүйцэтгэж байгаа онцлог үүрэг ролийн талаар нэгэн сурган хүмүүжүүлэгч ярьж байна.

21 Шашнаас хамааралтай коллежууд

ДЭЭДИЙН ГЭГЭЭН ДЭВИД М. О'КОННЕЛЛ, С. Т., Америкийн Католик шашны Их сургуулийн захирал

Сүсэг бишрэлээр дамжуулан сургах уламжлал бол дээд боловсролд “нэмэгдсэн өртөг” мөн гэдэгт шашны сургуулиуд итгэдэг

23 Тусгай мэргэжлийн сургуулиуд

МАЙКЛ ЖЕЙ ФРИДМАН, АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын Мэдээллийн Хөтөлбөрийн Товчооны орон тооны зохиогч Урлаг, бизнес, эсвэл цэргийн ухаан голлон судладаг коллежууд нь тусгай хөтөлбөртэй сургуулиудын цөөхөн жишээ юм.

Тодруулга: Коллежийн зэрэглэлүүд, Америкийн “топ” сургуулиуд, Бизнес болон техникийн чиглэлийн тэргүүлэх хөтөлбөрүүд, Айвийн Лигийн сургуулиуд, Education USA, Олон улсын боловсролыг тэмдэглэх долоо хоног

29 Гэрэл зургийн дэлгэц: Коллежийн амьдралаас

Ойроос ажиглахад...

34 Пенсильванийн Их сургуулийн олон улсын харилцаа

МАЙКЛ ЖЕЙ ФРИДМАН, АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын Мэдээллийн

ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧООНЫ ОРОН ТООНЫ ЗОХИОГЧ
САЛБАР ХООРОНДЫН ХӨТӨЛБӨРӨӨР ОЮУТНУУДЫГ
ДЭЛХИЙН ХААНА Ч АЖИЛЛАХААР БЭЛТГЭДЭГ
Тодруулга: АНУ-ын магадлан
итгэмжлэлийн талаарх тойм

36 Гадаадын оюутнууд өөрийн орны болон дэлхий дахины зорилгыг мэдэж авч байна

Ричард Холдин, Иельхэмийн Коллежийн Олон нийтийн мэдээлэл эрхэлсэн захирал асан

Афганистан, Кенийн оюутнууд өөрсдийн туршлага, хүсэл тэмүүллийн талаар ярьж байна.

39 Орон нутгийн үйлчилгээ

Робин Л. Ийгер, АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын Мэдээллийн Хөтөлбөрийн Товчооны орон тооны зохиогч
Сурагчдад практикаар хичээл заах, орон нутгийн хүй хамтлагт дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний ёс зүйг хөхиүлэн дэмжих зэрэг багшлах болон бусад сайн дурын үйлчилгээнд суралцах боломжийг олон коллеж оюутнууддаа олгодог.

43 Долоон түргэн зураг: Боловсролын боломжийн түүвэр жишгүүд

Энэ өгүүлэл нь Төрийн Департаментад ажилладаг гадаадын хүмүүсээс бүрдсэн бүлгийн АНУ-ын долоон коллежид гадаадын оюутан суралцах боломжийг судалсан тухай илтгэлийн хураангуй болно. Тогтолцоо хэрхэн үйлчилдэг вэ

48 Коллежид үзэх үндсэн мэргэжлийг сонгох нь

Линда Тобаш, Олон улсын Боловсролын Хүрээлэнгийн Их сургуульд хуваарилах асуудал эрхэлсэн захирал

Мэргэжлийн хүн үндсэн гол хичээлээ зөв сонгох талаар коллежийн оюутнуудад зөвлөгөө өгч байна.
Тодруулга: Гол хичээлийн сонголт ба ажил, мэргэжлийн замын сонголт хоёрын уялдаа, ялгаа, Хичээлийн жил, Бакалаврын зэрэг олоход тавигдах шаардлагууд, Интернетийн сонирхолтой вэб-сайтууд

57 Бакалаврын зэргийн буюу дээд сургуулийн хичээлийн танхим

Линда Тобаш, Олон улсын Боловсролын Хүрээлэнгийн Их сургуульд хуваарилах асуудал эрхэлсэн захирал

Зохиогч коллежийн оюутнаас юу

Онлайн видео

Харийн хүмүүс: Гадаадын оюутан байх нь

АНУ-д ирсэн оюутнуудын амьдралын эхний саруудын байдлыг харуулсан Дартмусын Коллежийн видео бичлэгээс хэсэгчлэн авав.

<http://www.usinfo.state.gov/journals/itsv/1105-ijse1105.htm>

шаардагдах болон тэд ямар төрлийн хичээлтэй тулгарах талаар өгүүлжээ.
Тодруулга: Үнэлгээний ангилал

60 АНУ-ын коллежийн өртөг, төлбөр

АНУ-д боловсрол эзэмших зардлыг санхүүжүүлэх аргыг эрэлхийлж байгаа гадаадын оюутнуудад зориулсан мэдээллийн эх сурвалж энд буй
Тодруулга: Коллежийн нийт зардал болон сургалтын төлбөр ба хураамж хоёрын уялдаа, ялгаа
Графикч: Коллежийн зардлын үлгэрчилсэн төсөв

64 Санхүүгийн тусламжийн боломжит эх сурвалжууд

Мартина Шульц, АНУ-ын Ерөнхий Консулын газрын соёлын асуудал эрхэлсэн мэргэжилтэн, Гамбург, Герман
Аспирантууд тусламж авах боломжоор оюутнуудаас илүү байдаг.

66 АНУ гадаадын оюутнуудыг орон нутгийн коллежид суралцахыг урьж байна

Женнифер Бэркхэм, Коммьюнити Коллеж Таймс, Америкийн орон нутгийн коллежуудын Холбоо
Коммьюнити Коллеж Таймс-д бичсэн өгүүллээс авсан энэхүү хэсэгт мэдээж орон нутгийн коллежуудын талаар дурдсан боловч “Тавтай морилно уу” гэсэн нь АНУ-ын их, дээд сургуулиудад суралцах гадаадын бүх оюутанд хандсан урилга болно.
Тодруулга: Гадаадын оюутны зөвлөх гэж хэн бэ?

68 Ашигласан ном хэвлэлийн жагсаалт

70 Интернэтийн эх сурвалжууд

АНУ-ЫН МУЖ УЛСЫН ИХ СУРГУУЛИУД

Роберт Х. Бруининкс



Эллиот Минор, AP/WWP

Аризона муж улсын Их сургуулийн инженерийн ангийн оюутнууд уралдаанд шагнал авсан робот нисэх онгоцоо бүтээж байгаа нь

Ер нь төрийн буюу муж улсын их сургуулиуд нь хэдэн арван мянган оюутантай байдаг бөгөөд хэдэн зуун мэргэжлийн сэдвээр боловсролын зэрэг олгож байна. Роберт Х. Бруининкс муж улсын томоохон их сургуулиудын бүтэц, санхүүжилт болон гадаадын оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийн суралцах боломж нөхцлийн талаар тоймлон өгүүлж байна. Тэрээр 2002 оноос Миннесотагийн Их сургуулийн захирлаар ажиллаж байгаа ба Уильям Фулбрайтын Гадаадын оюутны тэтгэлгийн удирдах зөвлөлийн гишүүн юм.


АНУ-ын олон нийтийн буюу муж улсын гэгдэх төрийн томоохон их сургуулиудыг тухайн муж улстай нь ихээхэн адилтгаж үздэг бөгөөд тэрхүү муж улс нь тэдгээрт дэмжлэг үзүүлдэг юм. Эдгээр их сургууль бол өвөрмөц уламжлалтай, орон нутагтайгаа нягт холбоотой, өндөр үнэлэгддэг, сонирхолтой бөгөөд хөгжингүй дээд боловсролын төвүүд юм. Түүнчлэн тэдгээр нь улс орны болоод дэлхийн өнцөг булан бүрээс авьяас билэгтэй хүмүүсийг өөртөө тагдаг соронзон мэт томоохон сургуулиуд юм.

Ер нь ийм маягийн их сургуулиудад хэдэн арван мянган оюутан суралцдаг байна. Эдгээр их сургууль улс орны эрдмийн болоод мэргэжлийн зэрэгтэй хүмүүсийн дийлэнхийг, эрдмийн цол зэрэг горилогчдын үлэмж хэсгийг бэлтгэн гаргаж байна. Мөн төрийн томоохон их сургуулиудад нийтлэг байдаг нэг зүйл бол сургалтын өргөн хүрээтэй хөтөлбөр юм. Өөрийн удирддаг Миннесотагийн Их сургуулиар жишээ болгоход Оюутны ихэр хотхон нь 50 мянган оюутантай, хэдэн зуун мэргэжлээр

зэрэг олгодог юм. Энэ их сургууль мэдрэл болон эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, эдийн засаг болон улстөрийн ухаан, материал судлал болон нанотехнологи, хөдөө аж ахуй болон байгалийн нөөц баялгийн зэрэг төрөл бүрийн салбарт тэргүүлж байна.

Муж улсын их сургуулиуд бүс нутгийн эдийн засаг, соёл, иргэний хөгжилд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Миннесотагийн Их сургууль шиг олон их сургууль судалгаа шинжилгээний ажил явуулах замаар мэдлэг болон технологийг дээд түвшинд гаргахад их үр нөлөөтэй оролцож байна. Эдгээр их сургууль АНУ-ын эрдэм шинжилгээний томоохон их сургуулиудын тоонд багтдаг бөгөөд дэлхий даяар хэрэгжүүлж байгаа олон улсын хөтөлбөрүүдэд тогтмол тэргүүлэн оролцож байна. Муж улсуудад их сургуулиуд үндэслэн байгуулахад нь туслах зорилгоор XIX зууны хоёрдугаар хагаст Холбооны хэмжээнд хэд хэдэн шаталсан арга хэмжээг хэрэгжүүлсэн юм. Холбооны зүгээс гаргасан энэхүү өгөөмөр сэтгэлийн үрээр бий болсон их сургуулиуд нь өөрийн оршин байгаа муж улсуудын орон нутгийн хүрээнд ажил, үйлчилгээ үзүүлэх (технологи шилжүүлэх, хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх, бага, дунд сургуулиудтай харилцан хамтарч ажиллах, мөн муж улсын болон орон нутгийн бодлого боловсруулагчдтай харилцан хамтарч ажиллах) үүрэг хүлээдэг.

Эрдэм шинжилгээний ажлын эрчим далайц муж улсын их сургуулиудад ихээхэн өөр өөр байдаг. Шинжилгээ судалгааны ажлыг сонгон шалгаруулахад зориулсан хэдэн зуун сая долларын хэмжээний мөнгөн тэтгэмж болон гэрээ хэлцлийг хамгийн



Жанет Хостеттер, AP/WWP

Мөсний хоккей бол Миннесотагийн Их сургуулийнхны хичээллэдэг олон спортын нэг юм

нэр хүндтэй муж улсын сургуулиудад жил бүр олгодог нь хэвшсэн заншил юм. Муж улсуудын зүгээс үзүүлж буй дэмжлэг туслалцааны хэмжээ ч мөн ихээхэн ялгаатай. Судалгаа шинжилгээний ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө төсөвлөдөг муж улсын их сургуулиуд төсвийнхөө 10-30%-ийг оршин байгаа муж улсынхаа төсвөөс голдуу авдаг. Их сургуулиуд төсвийнхөө үлдсэн хэсгийг сургалтын төлбөр, хураамж, мөнгөн тэтгэмж/гэрээ хэлцэл болон бэлгийн хандиваас бүрдүүлдэг.

Муж улсын томоохон их сургуулиудын санхүүжилтийн бүтцээс үндэслэн тэдгээрийн судалгаа шинжилгээний ажилд зориулсан мөнгөн тэтгэмж/гэрээ хэлцлийн хөрөнгөөс олон аспирант хагас цалинжин эрдэм шинжлэгээний туслах ажилтнаар ажиллаж санхүүгийн дэмжлэг авах боломж байдаг. Хэдийгээр муж улсын их сургуулиуд олон улсын солилцоо, судалгааг дэмжих зорилгоор аль болох их хэмжээний санхүүжилт хайдаг боловч гадаадын оюутнуудад зориулах санхүүгийн эх үүсвэр өмнө дурдсан судалгааны ажил/тусламжийн санхүүжилтээс гадуур олдох боломж маш хязгаарлагдмал байдаг. Ерөнхийдөө, бакалаврын зэрэг горилсон оюутнууд ассистентаар ажиллах боломжгүй тул дээд боловсролын анхан шатны зэрэг горилон суралцаж буй гадаадын оюутнуудыг тэтгэлгээр дэмжих боломж эдгээр муж улсын их сургуулиудад үнэхээр хязгаарлагдмал юм.

Муж улсын томоохон их сургуулиуд жижиг хэмжээний даруухан хотуудаас эхлээд томоохон хотууд хүртэлх янз бүрийн газар байршсан байдаг. Олон их сургууль муж улсаар нэг тархсан оюутны олон хотхонтой байдаг бол мөн олон муж улс нэгээс илүү тооны төрийн их сургуулийн системтэй байдаг. Муж улсын засаг захиргаанд янз бүрээр тайлагнадаг хариуцлага бүхий итгэмжлэгдсэн буюу сургуулийн захиргааны гишүүдийн зөвлөл улсын их сургуулиудыг удирддаг. Бусад олон орноос ялгаатай нэг зүйл бол АНУ-ын эдгээр их сургууль Холбооны түвшний Боловсролын сайдад

тайлагнадаггүй бөгөөд дээд боловсролын бодлого боловсруулах ихээхэн эрх мэдлийг муж улсуудад олгосон байдаг. Харин Холбооны хэмжээнд Үндэсний Шинжлэх ухааны Сан, Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгүүд болон Холбооны бусад олон агентлагаар дамжуулан оюутнуудад санхүүгийн тусламж үзүүлж, судалгаа шинжилгээний ажлыг санхүүжүүлэх өөр тогтолцоотой байдаг. АНУ-ын төрийн их сургуулиудын зарим уламжлал бусад орнуудынхаас маш ондоо. Муж улсын дэмжлэгтэй эдгээр их сургуульд ч гэсэн оюутнууд уламжлал ёсоор сургалтын төлбөр, хураамж төлөх замаар боловсролынхоо зардлын зарим хэсгийг төлсөөр ирсэн бөгөөд оюутнуудад ногдох эдгээр төлбөрийн хэмжээ улам нэмэгдсээр байна. Өнөөдөр дундаж оюутан боловсролынхоо зардлыг төлөхийн тулд зээл авч байна. Төслийн санхүүжилт, оюутны тэтгэлэг болон улсын их сургуулиудын орон тооны санхүүжилтэд ч хувийн хандив улам бүр чухал үүрэг гүйцэтгэх болж байна. Эцэст нь хэлэхэд, их сургууль хоорондын спортын тэмцээнүүдийг оюутнууд, хуучин төгсөгчид болон жирийн олон шимтэн сонирхдог бөгөөд тэдгээр тэмцээн нь нэмэгдэл орлогын эх үүсвэр болж байна.


АНУ-ын бүх их сургууль дотроос голдуу муж улсын томоохон их сургуулиуд хамгийн олон тооны гадаадын оюутан, суралцагсадтай байдаг. Миннесотагийн Их сургуульд гэхэд манай хамт олны дотор 130 шахам орны 4500 гаруй гадаадын оюутан суралцаж байгаа юм. Миннесотагийн Их сургууль хувь хүний болон хичээл сургуулийн асуудлаар, АНУ болон их сургуулийн соёл, уламжлалын чиглэлээр баримжаа олгох, мөн цагаачлал, визийн асуудлаар зөвлөгөө өгөх, англи хэлийг хоёрдахь хэл болгон заах, өөр өөр өв соёлын харилцан ойлголцол, холбоо харилцаа гэх мэтийн олон янзын сэдвээр хөтөлбөр, семинар явуулах зэргээр дэмжих үйлчилгээ үзүүлж байна. Муж улсын олон их сургууль зарим үед учрыг нь ойлгоход хэцүү байж болох захиргааны тогтолцоо, хичээлийн журам зэрэгт дасч заншихад нь оюутнуудад туслах хөтөлбөртэй ажиллаж байна. Гэхдээ эдгээр үйлчилгээний хүрээ сургууль бүр дээр өөр өөр байдаг.

Бусад орны зүгээс өрсөлдөөн ихсэж байгаа энэ үед АНУ-ын ямар ч том их сургууль гадаад оюутны сонирхлыг баталгаатай татна гэж хэлэх боломжгүй юм. Тиймээс төрийн их сургуулиуд нь дэлхийн өнцөг булан бүрээс хамгийн шилдэг, сайн оюутнуудыг татахад улам бүр голлон анхаарах болов. Хэрвээ та мэдлэг, бүтээлч хөдөлмөр хоёрын огтлолцох зааг дээр өөрийгөө хэн болохыг харуулах эрч хүч, эрмэлзлэлтэй байгаа бол, өөртөө тавьсан өндөр зорилготой оюутан мөн бол Америкийн Нэгдсэн Улсын төрийн томоохон их сургуулиудад байгаа баялаг боломжийг судлахад тань би урам нэмье.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУВИЙН ИХ СУРГУУЛЬ ГЭЖ ЮУ ВЭ?

Жеймс В. Вагнер



Линда А. Цицерон/Стэнфордын мэдээний алба

Калифорни муж улсын Стэнфордын Их сургуулийн Анагаах ухааны сургуулийн арьс судлалын лабораторид судалгаа явуулж байгаа оюутан

Эрдэм шинжилгээний хувийн их сургуулиуд нь ижил төрлийн төрийн их сургуулиудтай харьцуулахад санхүүгийн уян хаган байдлаараа давуутай хэмээн Атланта дахь Эморийн Их сургуулийн захирал Жеймс В. Вагнер ярьж байна. Тийм ч учраас хувийн сургуулиуд нь янз бүрийн хөтөлбөр боловсруулах илүү чадвартай байдаг байна.

Америкийн дээд боловсролын тогтолцооны нэг хүчтэй тал нь маш олон талын сургалт явуулдагт оршино. Хэдэн зуухан оюутантай жижиг коллежуудаас эхлээд хэдэн арван мянган оюутантай, муж улсын дэмжлэгтэй томоохон их сургуулиуд хүртэл, хоёр жилийн сургалттай, мэргэжлийн чиг баримжаат хөтөлбөртэй орон нутгийн анхан шатны коллежуудаас эхлээд хувийн санхүүжилттэй эрдэм шинжилгээний их сургуулиуд хүртэлх сургуулиудад олгож байгаа америк дээд боловсрол маш олон төрлийн хэрэгцээг хангаж байна. Оюутнуудын хувьд сонголтоо зөв хийх нь ажил мэргэжлийн замаа хөөх, албан тушаалд дэвших боломж, санхүүгийн дарамт бэрхшээл болон газар нутгийн байршлаас ихээхэн хамааралтай. Өөрөөр хэлбэл, тэд юу хийж, юу судлах тэмүүлэлтэй

байна, тэдний боломж ямар вэ, тэд гэр орноосоо холдохыг хүсч байна уу, үгүй юу гэдэг нь чухал учир холбогдолтой. Эцсийн эцэст уг сургууль оюутны хүсэл эрмэлзэлд хэр зэрэг нийцэж байгаа нь хамгаас чухал юм.

АНУ-д хамгийн том 100 их сургуулийн 92 нь олон нийтийн буюу “муж улсын дэмжлэгтэй” (өөрөөр хэлбэл, Холбооны засгийн газрын бус, бие даасан 50 муж улсын аль нэгний дэмжлэгийг авдаг) байдаг бөгөөд нийт үндэсний хэмжээнд коллежийн оюутнуудын 77% нь төрийн сургуулиудаар боловсрол олж байна. Одоог хүртэл хамгийн өндөр зэрэглэлийн 25 их сургууль дотроос гурав дөрвөөс бусад нь хувийн томоохон их сургуулиуд байна. Ийм ч учраас эрдэм шинжилгээний хувийн их сургуулийг АНУ болон дэлхий дахинд өндөрөөр үнэлдэг юм.

Тэгвэл “Эрдэм шинжилгээний хувийн их сургууль” гэж ярихдаа бид юуг илэрхийлж байна вэ? Ийм маягийн сургууль юугаараа тэгтлээ анхаарал татна вэ?

Эрдэм шинжилгээний хувийн их сургуулиуд мэргэжлийн сургалт (жишээ нь, хууль эрхзүй, анагаах ухаан болон инженерчлэлийн чиглэлээр) явуулж, Ph.D-ийн зэрэгт хүрэх боловсрол олгож



Адам Хангер, AP/Wide World

Массачусетсын Технологийн Их сургуульд сурдаг гадаадын оюутнууд робот зохион бүтээж, түүнийхээ хүч, авхаалжийг шалгаж байна.



Жон Базимор, AP/Wide World

Жоржиа мужийн Атланта дахь Эморийн Их сургуулийн энэ оюутан эрүүл агаарт хичээлээ хийж буй нь

байна. Факультетын эрдэмтэн багш нар сургалтаас гадна судалгаа шинжилгээний ажилд ихээхэн цаг зарцуулдаг. Үнэндээ эдгээр сургуульд нөхөн олговор болон дэмжлэгийг тодорхойлоход факультетын чанар, мэдлэг боловсрол, судалгаа шинжилгээний ажил сургалтын чанартай адил хэмжээнд чухлаар тавигддаг. Гэхдээ төрийн их сургуулиуд ч ялгаагүй мэргэжлийн сургалт явуулж, Ph.D зэрэг олгодог бөгөөд сургалт болон судалгааг чухалчлан анхаардаг. Тэгвэл хувийн их сургуулиуд юугаараа өөр юм бэ?

Нэг зүйл гэвэл, хувийн их сургуулиуд ерөнхийдөө санхүүгийн хувьд ихээхэн уян хатан байдаг. Тэд санхүүжилтийн талаарх муж улсын хууль тогтоомжоос хамааралгүй байдаг бөгөөд өөрсдийн хөрөнгийг хуучин төгсөгчид, буяны сангууд,

эрдэм шинжилгээний болон мэргэжлийн бусад байгууллагуудаас авч бүрдүүлдэг. Дээрх хүмүүс, байгууллагууд их сургуулиудын хөтөлбөр, оюутны тэтгэлэг, байр сав болон багш нарын зардлыг санхүүжүүлж байдаг. Санхүүжилтийн эдгээр эх үүсвэр төрийн их сургуулиудын хувьд бас нэмэгдэж буй боловч одоогоор хувийн их сургуулиудын хувьд судалгааны мэргэшсэн төвүүдийг байгуулж, янз бүрийн хөтөлбөр боловсруулах замаар судалгааны зоримог шинэ чиглэлд илүү шалмаг, илүү чадварлаг алхам хийх боломжоор хангаж байна. Оюутнуудын хувьд энэхүү уян хатан байдал нь нөгөөтэйгүүр тэднийг бага дэмжлэгтэй гэж бодож байж болох салбараа орхихгүй байх боломж гэж ойлгогдох нь олонтаа байдаг.

Үүнтэй нэгэн адил хувийн их сургуулиуд улсын мөнгөний авдраас хараат бус байдаг нь тэднийг бусад улс оронд “өөрийн цэг”-ийг байгуулах илүү боломжтой болгодог юм. Жишээ нь, Жеоржиа мужийн иргэд өөрсдийн төлсөн татварын доллараа Лондонд судалгааны төв байгуулахад зарцуулахыг зөвшөөрөх шинжгүй байна. Харин тэд хувийн санхүүжилттэй Эморийн Их сургуулийн тийм төв байгуулахад дургүйцэхгүй юм шиг байна.

Ерөнхийдөө хувийн их сургуулиуд судалгаа, сургалт болон үйлчилгээний олон улсын гол үүд хаалга болохдоо хялбархан юм. Жишээ нь, Эморийн Их сургууль Африк даяар, Кавказын бүс нутаг болон Азид дэлхий дахины эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Энэ сургууль бас Европ, Ази даяар хэрэгжүүлдэг бизнесийн хөтөлбөртэй. Ийм үйл ажиллагаа нь АНУ буюу хилийн чанадад ч ялгаагүй америк багш, оюутнуудад бусад улс орны хамгийн ухаантай, хамгийн авьяаслаг хүмүүстэй холбоо тогтоон хамтран ажиллах боломж олгож байгаа юм.


Эцэст нь, улсын их сургуулиудыг бодвол арай жижгэвтэр хувийн ихэнх судалгааны их сургуулиуд хүнийхээ цөөн тоо, хөрөнгө нөөцөөр баян байдлаа үүнтэйгээ таатайгаар хослуулж байна. Суралцах болон шинжилгээ судалгааны ажил хийх чадавхи улсын ч бай, хувийн ч бай үндэсний хэмжээний чанартай сайн аль ч их сургуульд өндөр байдаг бол хувийн оюутны хотхон жижгэвтэр байдаг, тэгээд ч сургууль, байр хоёр хоорондоо хэдхэн алхамын зайтай байдаг нь оюутан сурагчид хичээлийн явцдаа ойр хамтран ажиллах явдлыг хялбар болгож байгаа юм. Хамгийн чухал нээлтүүд хил дамнан хамтын ажиллагааны дүнд хийгдэж буй ертөнцөд оюутны хотхоны хүрээ хязгаар дотор буюу түүний чанадад, тэр ч бүү хэл дэлхийн бөмбөрцгийн хамгийн алслагдмал хэсэгт ч хүрч хамтын ажиллагааг тулж дэмжих, эрчимжүүлэх хувийн их сургуулиудын чадавхид тэдгээрийн агуу их татах хүчний нууц оршино.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

АНУ-ЫН ОРОН НУТГИЙН АНХАН ШАТНЫ КОЛЛЕЖИУД:

ОЛОН ХҮНИЙ ДЭЭД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ҮҮД ХААЛГА

Жорж Р. Боггс



Майкл Лемкуле, AP/WWP

Огайо дахь Оуэнсийн анхан шатны Коллежийн оюутан урлагийн ангийн байрны зураг төсөл дээр ажиллаж байгаа нь

Хоёр жилийн сургалттай коллеж нь жижиг, орон нутагт тулгуурласан орчинд, дөрвөн жилийн сургуулийг бодвол ямагт бага зардлаар дээд боловсрол эзэмшиж эхлэх боломжийг оюутнуудад олгож байна. Америкийн Орон нутгийн Анхан шатны коллежуудын Холбооны ерөнхийлөгч бөгөөд ахлах гүйцэтгэх ажилтан Жорж Р. Боггс анхан шатны коллежуудын сургалтын чанарт сэтгэл татах увдис нь байдаг тухай өгүүлж байна.

Орон нутгийн анхан шатны коллеж нь АНУ-д улам олон оюутан дээд боловсролд хүрэх үүд хаалга болж байна. Эдгээр коллеж нь дээд зэргийн чанартай, магадлан итгэмжлэгдсэн сургуулиудад суралцаж буй оюутнуудад дөрвөн жилийн бакалаврын зэргийн сургалтын эхний хоёр жилийн хугацаанд кредит бүрдүүлэх боломж олгодог. Сургалтын төлбөр багатай анхан шатны коллежууд нь оюутнуудад таагай орчинд суралцан мөнгөө хэмнэх арга замыг тавьж өгч байна. Тэрчлэн эдгээр коллеж оюутнуудад тусгай дунд сургууль төгссөн зэрэг олгох буюу үл олгох сургалтад

хамрагдах, насанд хүрэгчдэд олон чиглэлээр тасралтгүй боловсрол эзэмших, өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгож байна.

Анхан шатны коллеж нь АНУ дахь дээд боловсролын хамгийн том бөгөөд түргэн хөгжиж байгаа салбар болж байна. Өнөөдөр орон даяар бүс нутгийн түвшинд магадлан итгэмжлэгдсэн 1200 шахам орон нутгийн анхан шатны коллеж ажиллаж, эдгээрт 11 сая гаруй (ойролцоогоор Америкийн бүх оюутны 46 хувь) оюутан суралцаж байна.

АНУ-ын анхан шатны коллежууд гадаадын оюутнуудад англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх, АНУ-ын орон нутга, америк соёл, уламжлалын талаарх ойлголт өгөх зэргээр олон талт ашигтай туслалцаа үзүүлж байдаг.

Орон нутгийн анхан шатны коллежуудын ашиг тустай талууд гэвэл:

Зардал бага – Дөрвөн жилийн сургалттай коллеж болон их сургуулиудыг бодвол сургалтын төлбөр нь үлэмж хямд юм (дөрвөн жилийн сургалттай сургуулиудын жилийн төлбөр 12000\$-20000\$ ба түүнээс дээш байдаг бол энд 5000\$ орчим



Пьедмонтан анхан шатны Төв Коллежийн өгсөн зураг
Пьедмонтан анхан шатны Төв Коллежийн эдгээр оюутан Хойт
Каролина дахь анхан шатны коллежийнхоо талаар бахархах дуртай
байдаг.

байдаг).

Их сургуульд шилжин суралцахад дөхөмтэй - АНУ-д мөрддөг “2+2” тогтолцоо нь хоёр жилийн сургалттай коллеж болон дөрвөн жилийн сургалттай коллеж буюу их сургуулийн хооронд “шилжих” үр дүнтэй тогтолцоонд хамаарна. Анхан шатны ихэнх коллеж дөрвөн жилийн сургалттай коллеж болон их сургуультай шилжүүлэлтийн гэрээтэй ажиллаж, анхан шатны коллежид авсан кредитийг дөрвөн жилийн хөтөлбөрт шилжүүлэн тооцох боломжийг хангаж өгч байна.

Магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд – Америкийн анхан шатны коллеж, дөрвөн жилийн сургалттай коллеж болон томоохон их сургуулиудыг нэг л төрлийн байгууллагууд магадлан итгэмжилдэг. Их сургуулиуд анхан шатны коллежид авсан кредитийг хүлээн зөвшөөрдгийн учир үүнд байгаа юм.

Суралцах хөтөлбөр маш олон янз – Орон нутгийн анхан шатны коллежуудад бизнесийн удирдлага, компьютерийн шинжлэх ухаан, инженерчлэл, эрүүл мэндийн шинжлэх ухаан зэрэг түгээмэл салбаруудад сонгон суралцах боломжтой хэдэн зуун мэргэжлийн хичээл ордог.

Англи хэлийг хоёрдахь хэл болгон заадаг – Анхан шатны олонхи коллеж олон түвшинд англи хэлний төрөл бүрийн дамжаа хичээллүүлж, хэлний мэдлэгийн өөр өөр түвшинтэй оюутнууд амжилттай суралцах боломжийг хангаж өгөх зорилгоор маш олон төрлийн дэмжих үйлчилгээг санал болгож

байна.

Суралцах таагай орчин – Анхан шатны коллежуудад дунджаар 30 хүрэхгүй хүнтэй жижиг анги хичээллэдэг нь багш нарын зүгээс хүн бүрт анхаарал хандуулах, байнгын туслалцаа дэмжлэг үзүүлэх боломж олгодог. Оюутны сургалтын хэв загвар, хэрэгцээ шаардлагыг тэтгэн дэмжих орчинд оюутан хүн бие дааж амжилт гаргахад гол анхаарлаа хандуулдаг. Оюутнуудад зориулсан дэмжих үйлчилгээнд халамжлан туслах, зөвлөгөө өгөх, бичлэг зүйн лаборатори, олон улсын оюутны клуб, гадаадын оюутнуудад үйлчлэх төв ажиллуулах зэрэг үйлчилгээ ордог.

Олон янзын хүмүүс суралцдаг – АНУ-ын анхан шатны коллежуудад соёлын янз бүрийн өв, олон үндэстэн ястны төлөөлөл болсон оюутнууд суралцдаг. Коллежууд олон төрлийн клуб ажиллуулж, АНУ-ын нийгмийг тодорхойлдог олон талт байдлыг хөхиүлэн дэмжсэн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг.

АНУ-ын соёлоос хүртэх боломж – Анхан шатны коллежууд орон нутгийнхаа тусгал нь болж, хэрэгцээ шаардлагад нь мэдрэмжтэй хандаж байдгийн хувьд орон нутагтаа хүчирхэг холбоо сүлбээтэй байхыг эрмэлздэг. Ийм харилцаа нь гадаадын оюутнуудад америкчуудтай хамтарч ажиллах, Америкийн соёлоос суралцах өргөн дэлгэр боломж олгодог.

Байршил болон оюутны хотхоны хэмжээ өөр өөр байдаг – АНУ-ын боловсролын бусад байгууллагуудын нэгэн адил анхан шатны коллежууд нь өөр хоорондоо маш ялгаатай. Зарим нь том хотуудад байршилтай оюутны олон хотхонтой томоохон сургууль байдаг бол зарим нь хөдөө орон нутгийн хотуудад байршсан, цөөн тооны оюутанд үйлчилдэг цомхон сургууль байдаг. Анхан шатны коллеж нь АНУ-ын хүн амын 90 хувь нь унаагаар ирж, очиж болох ойрхон зайд, эвтэйхэн байршилд байрласан байдаг.

Хүндэт төгсөгчид – АНУ-ын анхан шатны коллежийг төгсөгчдийн дотор Калифорни муж улсын захирагч Арнольд Шварценеггер, Мэриленд муж улсын захирагч асан Парис Гленденинг, НАСА-гийн спейс-шатл хөлгийн дарга Эйлин Коллинз, Оддын дайн олон ангит кино бүтээгч, продюссер/захирал Жорж Лукас, кино жүжигчин Том Ханкс, Клинт Ийствуд, хувцасны загвар зохион бүтээгч Келвин Клейн, хүний ген судлаач Крег Вентер, АНУ-ын Ерөнхий эмч Ричард Кармона нар байна.

АНУ-ын Анхан шатны коллежид суралцах талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл <http://www.CC-USA.org> сайтад орж үзэх буюу орон нутгийн Education USA зөвлөгөө өгөх төвүүдэд байгаа Guide to Studying at US Community Colleges номыг уншаарай.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлтнь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

ОЛОН ТАЛТ БАЙДЛЫН ДАВУУ ТАЛ:

АНУ-ын дээд боловсролын бие даасан салбар

Ричард Экман



Нэнси Палмайери, AP/WIDEWORLD

Зимбабвегээс ирсэн оюутан Массачусетсийн Маунт Холиокийн Коллеж төгсөлтийн баяраа тэмдэглэж байгаа нь

Дөрвөн жилийн сургалттай хувийн коллежууд, ялангуяа бакалаврын зэрэг аваагүй оюутнуудад зориулан боловсролын олон талт арга хэмжээ зохион байгуулдаг. Бие даасан коллежуудын Зөвлөлийн захирал Ричард Экман хувийн буюу бие даасан коллежуудын юу нь улсын хэмээгдэх ижил төрлийн сургуулиудаас өөр болгож байгааг тайлбарлаж байна.

АНУ-ын дээд боловсролын хамгийн гайхамшигтай өвөрмөц онцлог нь түүний олон талт байдал юм. Тус улсын засгийн газар АНУ-ын коллеж болон их сургуулиудын сургалтын хөтөлбөрт буюу заах аргад хяналт тавьдаггүй бөгөөд муж улсын засгийн газар ч мөн л энэ асуудалд бараг оролцдоггүй юм. Гэхдээ сургалтын философи, хөтөлбөр, уламжлалаараа өөр хоорондоо ялгаатай дээд боловсролын “бие даасан” буюу “хувийн” салбарт олон талт байдал хамгийн өргөнөөр дэлгэрсэн байдаг. 600-гаад жижиг коллеж, их сургууль энэхүү салбарыг бүрдүүлж байдаг бөгөөд эдний дотор Америкийн Нэгдсэн Улсын хамгийн хүндтэй сургуулиуд багтаж байгаа юм.

Эдгээр олон янзын өвөрмөц онцлогийг авч үзье. Пенсильвани дахь Эрсинус Коллеж үзэх хичээлүүдийн хооронд анхлан суралцагчдын жилийн хөтөлбөр гэгчийг оруулж, оюутнуудад хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны олон төрлийн сэдвийг заадаг; Хойт Каролина дахь Варрен Вильсоны Коллеж сургууль гар хөдөлмөрт оролцохыг оюутнуудаас шаарддаг бөгөөд үүнийгээ коллежийн сургалтын философийн чухал хэсэг гэж үздэг; Висконсин дэх Нортлэндийн Коллеж

байгаль орчноо хамгаалах, түүнд мэдрэмжтэй хандахад ихээхэн анхаардаг; Баруун Виржини дэх Андерсон-Броаддусын Коллеж ихэнх оюутнаа Баруун Виржинийн уул толгодын дундах жижигхэн хотуудаас элсүүлж, тэдний ихэнхэд нь шинжлэх ухаан, анагаахын чиглэлээр мэргэжил эзэмшүүлдэг; Куэкэрсийн үндэслэн байгуулсан Иельхэмийн Коллеж Индиана мужид байдаг бөгөөд оюутны хотхонд амьдардаг бүх хүмүүсийн зөвшилцлийг шийдвэр гаргах гол хэлбэр болгон ашигласаар байна; Пенсильвани дахь Седар Крестийн эмэгтэйчүүдийн Коллеж олон тооны шинжлэх ухааны цол зэрэгтэй эмэгтэйчүүдийг бэлтгэн гаргаснаараа эмэгтэйчүүд шинжлэх ухаанд тодорч гарч чадахгүй гэсэн үхширмэл ойлголтыг няцааж байна.

Эдгээр 600 шахам тооны коллеж, их сургууль өөр өөрийн онцлог ялгаатай ч тэдэнд нийтлэг хэд хэдэн шинж бий. Үүнд:

- Тэд хэмжээгээрээ харьцангуй жижиг бөгөөд суралцагч оюутны тоо 3000-аас давах нь ховор.
- Тэд гол төлөв буюу бүхэлдээ дипломын өмнөх боловсрол олгох чиглэлээр сургалт явуулдаг бөгөөд дипломын дараах боловсролын зэрэг олгох цөөн хэдхэн хөтөлбөртэй байдаг.
- Бүх эрдэмтэн багш нар зөвхөн заах үүрэгтэй. Хэдийгээр тэдний ихэнх нь судалгааны ажил хийдэг боловч үүнийгээ багшлах үүргийнхээ хажуугаар гүйцэтгэх зүйл гэж үздэг, ихэнх цагаа ангид болон оюутнуудтай ангиас гадуур ажиллахад зориулдаг.
- Сургалтын арга нь дээд зэргээр харилцан санал



Патриция МакДоннелл, AP/WVW

Массачусетс дэх Уэлслийн Коллежийн оюутнууд багштайгаа хамт 24 цагийн турш Шекспирийн зохиол унших ажиллагаанд оролцож байгаа нь



Кевин Г. Рийвс, AP/WVW

Огайогийн Оберлины Коллежийн хөгжмийн ангийн оюутнууд Аргентины дуучидтай хамтран дуурь тоглоход бэлтгэж байгаа нь. Хөгжмийн хөтөлбөрөөрөө алдартай энэ коллеж эмэгтэйчүүд болон Африк гаралтай америк оюутнуудыг анхлан хүлээн авч, сургаж төгсгөснөөрөө бас нэрд гарсан юм.

бодлоо солилцох чиглэл баримталсан, тодорхой чиглэлтэй байдаг.

- Эдгээр коллеж сургалтын ихэнх үйл явц хичээлээс гадуур явагддаг учир оюутнууд хоорондоо болон оюутан, багш хоёр бие биедээ нөлөөлж ажиллах боломж үлэмж их бөгөөд энэ нь сургалтын нэгдсэн төлөвлөгөөний чухал хэсэг гэсэн ойлголттой байдаг.
- Эдгээр сургууль өөрсдийн ард байгаа үнэт зүйлсээ нууж хаадаггүй. Заримдаа эдгээр нь коллежийн үндэс болсон шашны үнэт зүйлс (шашин шүтлэг энд тийм ч гүн биш нөлөөтэй гэвэл түүний цуурай) байх нь бий. Заримдаа эдгээр үнэт зүйлс нь “аугаа номын” коллежууд (эдний дотроос Мерилэнд болон Нью Мехикод оюутны хотхонтой Гэгээн Жоны Коллеж хамгийн алдартай нь) буюу оюутнууд нь суралцахын зэрэгцээ сургуульдаа тус дэм

болох үүрэг хүлээдэг Варрен Вильсоны Коллеж, эсвэл Кентукки дэх Береагийн Коллеж зэрэг “хөдөлмөрийн коллеж”-ууд зэрэг сургалтын онцлог философийн илэрхийлэл болдог.

- Эдгээр сургууль мэргэжлийн ямар сургалт явуулахыг үл харгалзан хүмүүнлэгийн ухаан судлуулах нь оюутнууд сургууль төгссөнийхөө дараа хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чухал хэрэгтэй зүйл хэмээн үздэг.

Эдгээр сургуулийн олгож байгаа дээд боловсролын агуулга, хэлбэр гайхалтай үр дүнтэй байдаг. Боловсролын зэрэгтэй төгсөгчдийн талаарх статистикийн тоо мэдээнээс харахад хувийн жижиг коллежуудыг боловсролын зэрэгтэй төгсөж байгаа оюутнуудын хувь муж улсын харьяаны томоохон их сургуулиудынхаас дээгүүр байна. Түүнээс гадна ийм ялгаа хамгийн авьяаслаг оюутнуудын дунд төдийгүй дунд сургуулийг тааруухан төгссөн буюу SAT [<http://www.collegeboard.com>] оноотой элсэн орж байгаа оюутнуудын дотор ч байгаа юм. Зэрэгтэй төгсөлтийн өндөр хувь коллежийн оролцооны хувь доогуур байгаатай заримдаа холбоотой нийгэм-эдийн засгийн бүлгүүдэд ч, гэр бүл дотроосоо коллежийн оюутан болсон анхны хүүхэд болон хичээлд суухын зэрэгцээ орон тооны ажил хийх шаардлагатай байдаг оюутнуудад, эсвэл үндэсний цөөнхийн янз бүрийн бүлгийн оюутнуудад ч мөн адил хамаарна.

Хувийн жижиг сургуулиудын харьцангуй үр дүнтэй байдлыг эдгээр сургуульд явагддаг “тодорхой чиглэлийн сургалт”-аар тайлбарлаж болох юм. Оюутны үүргийг хянах Үндэсний Хороог (олон зуун коллеж, их сургууль үүнд оролцдог) үндэслэгч Жорж Кухын тэмдэглэж хэлснээр коллежид амжилт гаргах нь багштайгаа танилцах, хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаанд оролцох, хөлсгүй дагалдангаар ажиллах, амаар илтгэл тавих, өндөр давтамжтайгаар бичиг баримт боловсруулахыг шаарддаг хичээл зэрэг сурган хүмүүжүүлэх идэвхтэй арга зонхилсон хичээл сургуульд оролцож байх зэргээс шууд хамаарна. Ийм шинжүүдийг томоохон сургууль гэхээсээ жижиг сургуулиудаас олж харах илүү магадлалтай.

Бие даасан жижиг сургуулиудыг АНУ-ын хаанаас ч, томоохон хот, арай жижиг хот суурин болон хөдөө орон нутгаас олж болно. Эдгээр коллеж янз бүрийн намтар түүхтэй хүмүүсийг, оюутны хотхоны яриа мэтгэлцээнд янз бүрийн авьяас билэг, хэтийн төлвийг авчрах оюутнуудыг дуртайяа хүлээн авч сургадаг. Бусад оронд төрж өссөн оюутнуудыг (сургалт бараг голдуу англи хэл дээр явагддаг ч) хүлээн авч сургах илүү дуртай байдаг.

Эдгээр сургуулийн талаарх мэдээлэл тэдний вэб-сайтад бэлхнээ бий. Бие даасан коллежуудын Зөвлөл эдгээр сургуулийн ихэнхтэй холбоотой ажилладаг. Түүний [<http://www.cic.org>] вэб-сайтад хандана уу.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлтнь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

ҮНДЭСНИЙ ЦӨӨНХӨД ҮЙЛЧИЛДЭГ СУРГУУЛИУД



Тэд С. Варрен, AP/WWP
Луизиана муж улсын Грэмблингийн Их сургуулийн
жагсаалын оркестр сэтгэл сэргэм цоглог
тоглолтоороо улсдаа алдартай

Дурдсан вэб-сайтууд болон бусад эх сурвалжаас авч бэлтгэсэн энэхүү өгүүлэл Африк гаралтай америкчууд, Латин Америк гаралтай америкчууд, Америкийн индианчууд гэсэн гурван төрлийн үндэсний цөөнх хүн амын оюутнуудад үйлчилдэг коллежуудын талаарх мэдээллийг өгч байна.

Үндэсний цөөнхөд үйлчилдэг сургуулиуд нь үндэсний цөөнхийн оюутан, сурагчдын хэрэгцээнд үйлчлэхэд гол анхаарал тавьдаг тусдаа зэрэглэлийн (муж улсын коллеж, хувийн сургууль, шашны дагалгатай коллеж, хүмүүнлэгийн ухааны коллеж, анхан шатны коллеж) коллеж, их сургуулиуд юм. Эдгээр сургууль оюутны өвөрмөц хүн амд үйлчлэх түүхэн уламжлал буюу үүрэгтэй боловч үндэсний цөөнхөд хамаарахгүй оюутнуудад үйлчлэх нь олонтаа байдаг. Тэд нийтлэг ашиг сонирхлын байгууллагуудыг байгуулдаг. Гишүүд нь эл ангилалд багтах гурван бүлэг гэвэл Хар арьстны түүхэн гэгдэх коллеж, их сургуулиуд (ХАТКИС); Латин Америк гаралтай иргэдийн Коллеж, Их сургуулиудын Холбоо (ЛАИКИСХ); омгийн коллеж, их сургуулиудын холбоо болох Америкийн Индианчуудын Дээд боловсролын Консорциум (АИДБК) юм. Үндэсний цөөнхийн оюутнуудад үйлчлэхэд нь коллеж, их сургуулиудад туслах чиглэлээр ажилладаг бусад олон бүлэг, байгууллага бий.

ХАР АРЬСТНЫ ТҮҮХЭН КОЛЛЕЖ, ИХ СУРГУУЛИУД

Хар арьстны түүхэн коллеж, их сургуулиудын талаар Цагаан Ордны Санаачлагаас гаргасан баримт бичгийн дагуу:

ХАТКИС нь Африк гаралтай америк иргэд, түүнчлэн бүх үндэстний амжилт, их бахархлын эх сурвалж мөн. 1965 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Дээд боловсролын тухай Хуульд ХАТКИС-ийг: "...1964 оноос өмнө байгуулагдсан, үндсэн үүрэг нь хар арьстан Америк иргэдэд боловсрол олгох явдал байсан буюу байгаа, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд явуулж байгаа сургалтын чанарыг үнэлэх найдвартай эрх мэдэлтэй хэмээн Боловсролын Сайдын тодорхойлсон магадлан итгэмжлэх агентлаг буюу холбооноос магадлан итгэмжлэгдсэн буюу ийм агентлаг, холбооны үнэлснээр магадлан итгэмжлэгдэж болохуйц бодитой дэвшил гаргаж байгаа хар арьстны аливаа түүхэн коллеж буюу их сургууль" хэмээн тодорхойлсон байна.

2005 оны есдүгээр сард Ерөнхийлөгч Жорж Буш 2005 оны есдүгээр сарын 11-17-ны өдрүүдийг Хар арьстны түүхэн коллеж, их сургуулиудын долоо хоног болгон зарлахдаа ХАТКИС-дыг өндөр чанарын стандарт тогтоож, өсвөр үеийнхнийг амжилт бүтээлд бэлтгэн, адил тэгш боловсрол

олгох үндэсний үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд тус болж байгаад нь талархал илэрхийлж, магтан сайшаасан билээ. Тэрээр хэлэхдээ: “Өндөр чанарын стандартыг мөрдөж, бүх америкчуудад адил тэгш боловсрол эзэмших боломжоор хангаж байгаагаараа үнэ цэнэтэй эдгээр сургууль манай бүх иргэд өөрсдийн боломжийг бүрэн хэрэгжүүлж чадах, хөгжин дэвшсэн, найдвар төгс ирээдүй рүүгээ тэмүүлэх боломжийг хангаж өгөхөд тусалж байна” гэсэн юм. Тэрээр цааш нь, “Хүн болгон Америкийн аугаа их ирээдүйг цогцлуульж чадах тийм нийгэм рүү бид зорьсоор байна” гэж хэлжээ. 105 ХАТКИС-ийн ихэнх нь баруун өмнө зүгийн муж улсууд, Колумбийн тойрог болон Виржиний арлууд дээр оршдог. Тэдгээрийн тоонд дөрвөн жилийн сургалттай улсын 40, хоёр жилийн сургалттай улсын 11, дөрвөн жилийн сургалттай хувийн 49, хоёр жилийн сургалттай хувийн 5 сургууль багтаж байгаа юм. Нэмэлт мэдээллийг <http://usinfo.state.gov/scv/Archive/2005/Sep/26-256508.html>-д буй ХАТ Бид КИС-дын Долоо хоногийн талаарх сонины тусгай өгүүлээс олж уншиж болно.

ЛАТИН АМЕРИК ГАРАЛТАЙ ИРГЭДИЙН КОЛЛЕЖ, ИХ СУРГУУЛИУДЫН ХОЛБОО



Санта Фе-гийн Коллежийн өгсөн зураг Нью Мехико дахь Латин гаралтай иргэдэд үйлчлэх сургууль болох Санта Фе-гийн Коллежид оюутнууд бялдаржуулах урлагийн багштай хичээллэж байгаа нь

Латин Америк гаралтай Америк иргэдийн Коллеж, Их сургуулиудын Холбоо (ЛАИКИСХ) үүсгэн байгуулагч 18 сургуулийн гишүүнчлэлтэйгээр 1986 онд байгуулагдсан. Өнөөдөр ЛАИКИСХ нь АНУ, Пуэрто Рико, Латин Америк болон Испанид Латин Америк гаралтай иргэдийн дээд боловсролыг хөгжүүлэх зорилго, үзэл санаанд үнэнч 400 гаруй коллеж, их сургуулийг төлөөлж байна. Хэдийгээр АНУ дахь ЛАИКИСХ-ны гишүүн сургуулиуд тус улс дахь бүх дээд боловсролын сургуулийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байгаа боловч тэд нийлээд Латин Америк гаралтай иргэдийн коллежийн оюутнуудын дөрөвний гурав гаруй хувийнх нь гэр орон болж байна. ЛАИКИСХ нь Латин Америк гаралтай иргэдэд үйлчлэх сургуулиудыг (ЛАИУС) төлөөлсөн цорын ганц дээд боловсролын үндэсний холбоо юм. 205 ЛАИУС-д оюутнуудын 25 гаруй хувийг Латин Америк гаралтай хүмүүс эзэлж байна. Гишүүн бусад

коллежид сурч буй оюутнуудын 25 хүрэхгүй хувь нь Латин Америк гаралтай хүмүүс байна. http://www.hacu.net/hacu/Default_EN.asp-ийг үзнэ үү.

ОМГИЙН КОЛЛЕЖ, ИХ СУРГУУЛИУДЫН ТАЛААРХ ЦАГААН ОРДНЫ САНААЧИЛГА

Америкийн индианчуудын хүй хамтлагт Омгийн коллеж, их сургуулиудын гүйцэтгэж байгаа чухал үүргийг Ерөнхийлөгч Буш хүлээн зөвшөөрч, 2002 оны долдугаар сарын 3-нд Омгийн коллеж, их сургуулиудын тухай 13270 тоот Гүйцэтгэх захирамжид гарын үсэг зурсан. Энэхүү захирамжийн дагуу Омгийн коллеж, их сургуулиудын асуудлаарх Ерөнхийлөгчийн зөвлөгчдийн Зөвлөл, Омгийн коллеж, их сургуулиудын талаарх Цагаан Ордны Санаачилгыг байгуулсан байна. Ерөнхийлөгч хэлэхдээ:

Омгийн коллеж, их сургуулиуд нь орлууль сольж болшгүй хэл, соёлын уламжлалыг хадгалахад туслаж байна. Үүний зэрэгцээ, мэдээж, тэд мянга мянган оюутанд коллежийн чанар сайтай боловсрол олгож, индианчуудын нутагт маш хэрэгцээтэй хөдөлмөр, эдийн засгийн хөгжлийн бусад арга хэрэгсэлд сургаж байна. ...Бүх америк хүн, түүний дотор Омгийн коллеж болон их сургуулиудад суралцаж байгаа хүмүүс гойд сайн боловсрол эзэмших ёстой гэсэн.

АНУ-д Холбооны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Омгийн коллеж, их сургууль 34 бий. Баруун муж улсуудын дунд болон өмнөд хэсэгт байрладаг омгийн коллеж болон их сургуулиуд нь бүтэн болон хагас ээлжээр хичээллэдэг 30000 орчим оюутанд үйлчилдэг. Тэдгээр сургууль 200 гаруй хичээлээр тусгай мэргэжлийн диплом, зарим үед бакалаврын болон магистрын зэрэг олгодог. Мөн техник мэргэжлийн боловсролын гэрчилгээ олгох 200 хөтөлбөрөөр хичээллэдэг. Хэдийгээр омгийн эдгээр сургууль зөвхөн Америкийн уугуул иргэлийг хүлээж авдаг боловч АНУ-ын дээд боловсролын онцлог шинж чанарын талаархи мэдээллийг өгдөг. Нэмэлт мэдээллийг <http://www.whitehouse.gov/news/releases/2002/07/20020703-16.html> хаягаар үзнэ үү.



Ерөнхийлөгчийн албанаас ирүүлсэн зураг, Хаскеллын Индиан үндэстний Их сургууль

Канзас дахь Каскеллын Индиан үндэстний Их сургуулийн оюутнууд жагсаалын тэргээ чимэглэж байгаа нь

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

БРАУНААС ХОЙШХИ 50 ЖИЛ:

Хар арьстны түүхэн коллеж, их сургуулиуд яагаад хэрэгтэй хэвээр байна вэ?

Биверли Даниел Татум



Спелманы Коллежийн өгсөн зураг

Ангийн ярилцлага дээр оюутан санал гаргаж буй нь

Биверли Даниел Татум хар арьстны түүхэн коллежууд янз бүрийн суурь боловсролтой, янз бүрийн хэтийн зорилготой оюутнуудад орж суралцах боломж олгохын зэрэгцээ тэднийг хувь хүний хувьд хэн болохоо харуулахад ямар үүрэг гүйцэтгэж байгаа талаар ярьж байна. Тэрээр Жоржиа муж улсын Атланта хотын Спелманы Коллежийн захирал бөгөөд “Яагаад бүх хар арьстан хүүхэд цайны газарт нэг дор сууцгааж байна вэ?” болон Арьс өнгө, үндэсний тухай бусад яриа хэмээх ном бичжээ (Basic Books, 2003).

Би 1954 онд буюу сургуулиуд “тусдаа, гэхдээ тэгш” хэмээн салган заагладаг номлолыг хууль бус гэж үзсэн Дээд шүүхийн Браун Боловсролын зөвлөлийн эсрэг хэмээх шийдвэр гарснаас яг дөрвөн сарын дараа төрсөн билээ. Би Флоридагийн Таллахасид сургуульд орж билээ. Тэнд аав маань Флоридагийн А&М Их сургуулийн Урлагийн тэнхимд багшилдаг байсан юм. Тэрээр Флорида муж улсын Их сургуульд сурч, докторын зэрэг хамгаалах хүсэлтэй байсан авч 1954 онд Флоридад хар арьстан аспирантууд сурах боломж хаалттай хэвээр байжээ. Оронд нь тэд эцгийн маань Пенсильвани хүрэх галт тэрэгний зардлыг нь даасан бөгөөд 1957 онд тэрээр Пенн муж улсын Их сургуульд цолоо хамгаалсан гэдэг. Жилийн дараа аав маань миний өсч бойжсон Массачусетс муж улсын Брижуотер хотын Брижуотерийн улсын Коллежийн анхны хар арьстан профессор болсон юм. Өнөөдөр Брижуотерийн улсын Коллеж

анхныхаа өнгөт арьстан ерөнхийлөгчтэй боллоо. 2004 оны хоёрдугаар сард хар арьстан эмэгтэй би Флорида муж улсаас эрхлэн зохион байгуулсан Дээд боловсролын асуудлаарх Бага хурлыг нээж үг хэлсэн билээ. 1954 онд бол энэ талаар бодох ч хэрэггүй байсан болов уу.

Голдуу цагаан арьстнууд сурдаг сургуулиудад арьсны үзлийн талаар олон жил заасан туршлагатай сурган хүмүүжүүлэгчийн хувьд, мөн одоо түүхийн үүднээс хамгийн эртний хар арьстан эмэгтэйчүүдийн коллеж болох Спелманы Коллежийн ес дэх ерөнхийлөгч болсны хувьд би бээр Браун Боловсролын зөвлөлийн эсрэг хэмээгдсэн шийдвэрийн утга санааг сайтар ухааран ойлгож байна. Хар арьстны олон түүхэн коллеж, их сургууль (ТХАКИС)-ийн нэгэн адил Спелманы Коллеж өмнө нь өнгөт арьстнуудыг сургахаас татгалздаг байсан, цагаан арьстнууд зонхилон суралцдаг коллеж, их сургуулиудаас оюутнуудыг өөртөө татахын төлөө шинэ өрсөлдөөнтэй тулгарч байна. Гэхдээ эрчимтэй, ширүүн өрсөлдөөн Спелманы Коллежийг өөрчлөн сайжруулахад хүргэсэн билээ. Браунаас хойшхи үед багш нар эрдэм шинжилгээний болон хэвлэн нийтлүүлэх ажлынхаа талаар улам бүр хүчин чармайлт гаргах явдлыг идэвхтэй дэмжиж, оюутнуудад мэдлэг боловсрол олгох хөрөнгө нөөц бий боллоо. Хөрөнгө нэмэгдүүлэх зорилготой хандив цуглуулах ажил амжилттай болсны ачаар санхүүгийн хувьд тогтвортой ажиллах боломж бүрдэж, хичээлийн болон дотуур байр шинээр барих, өөрөөр хэлбэл өнөөдөр манай сургуулийн нэгдүгээр



Спелманы Коллежийн өгсөн зураг

Ангийн ярилцлага дээр оюутан санал гаргаж буй нь

ангид элсэх 525 хүний нэг болохын төлөө жил бүр өрсөлдөх 4000 шахам авьяаслаг охид, бүсгүйчүүдийг даллах орчныг бүрдүүлэхэд тус болсон юм.

Юуны учир Спелманы Коллеж мэтийн хар арьстны түүхэн коллежууд хэрэгтэй хэвээр байгаа төдийгүй яагаад тэднийг хар арьстан авьяаслаг оюутнууд илүүтэй сонгож байна вэ? Коллежийн сонголт бол хувь хүний өөрийнх нь сонголт бөгөөд тэрээр өөрийгөө юу гэж үзэж байна, тэр одоо хэн бэ, цаашид ямар хүн болохыг хүсч байна вэ гэдгийг харуулдаг юм. Оюутнууд өөрсдийгөө бүрэн харуулах орчинд, боловсролын үйл явцын голд нь байгаагаа олж харж чадах тийм газар руу очигцоодог.

Хэдэн жилийн өмнө би цагаан арьстнууд голдуу амьдардаг орон нутагт төрж өсөөд Хар арьстны коллежид орж суралцсан оюутнуудын дунд омог угсаатны төлөөлөгч хувь хүн хэрхэн төлөвшиж байгааг судлах судалгааны ажлынхаа нэг хэсэг болгож хар арьстны түүхэн их сургуулиудыг сонгосон оюутнуудтай ярилцсан юм. Нэгэн бүсгүй хар арьстны коллежид суралцаж байгаагаа тайлбарлахдаа: “Би оюутны хотхон дотроо алхаж явахдаа ‘энэ бол надад зориулсан газар шүү дээ’ гэж бодоход хичнээн аз жаргалтай сайхан байдаг гээч” гэсэн юм. Хар арьстан эмэгтэй ингэж хэлэх газар Америкт тийм ч олонгүй болов уу. Коллежид хувь хүн өөрийгөө хэн болохоо нотлохын ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй.

1954 оны үеийнхээс өнөөдрийн коллежийн оюутны ихэнх хотхон үлэмж ялгаатай ч бүх оюутныхаа оюуны болон бусдыг тэргүүлэх чадавхийг дээд зэргээр хөгжүүлэх үнэнхүү бүх талын орчныг бүрдүүлэх цагаан толгойг ухаарахын төлөө сургуулиуд тэмцээр байна. Бүх шатны боловсролоор дамжуулан хувь хүнийг хүлээн зөвшөөрүүлэх, хамт олныг бүрдүүлэх, удирдах чадвартай болгох гэсэн үр дүнтэй сургалтын гурван чухал хэмжигдэхүүн нь эдгээр цагаан толгой болно.

Цагаан толгойн энэхүү мэдлэгийг ажил хэрэг болгох явдал нь “Бидний энэ орчинд хэн нь ил харагдаж, хэн нь нүднээс далд байна вэ? Хамт олныг бүрэлдүүлэх, ялгаатай байдлыг давж харилцан ярилцах боломж юу байна вэ? Янз бүрийн нөхцөлд оюутнууд үйл ажиллагаанд хэрхэн оролцож, удирдагчийн ур чадварт хэрхэн суралцаж байна вэ” гэсэн асуултыг бие биедээ ямагт тавьж байхыг шаардаж байна.

Арьс өнгө, үндэсний холбоотой харилцааны мэргэжилтний хувьд би Спелманы Коллеж шиг “нэг төрлийн” сургуулийг удирдах сонголт яах гэж хийснээ өөрөөсөө байнга асуудаг юм. Энэхүү асуулт төгөлдөр бус төсөөллөөс үүдэлтэй нь мэдээж. Хэдийгээр оюутнуудын маань 97 хувь нь арьсны өнгөөрөө “хар” боловч оюутны бие бүрэлдэхүүн маань маш олон янзын хүмүүсээс бүрддэг. Спелманы Коллежид

АНУ-ын өнцөг булан бүрээс, түүнчлэн гадаадын олон орноос ирсэн, цагаан арьстнууд амьдардаг дүүргүүд болон хөдөө орон нутаг, мөн хар арьстнууд амьдардаг дүүргүүдээс ирсэн оюутнууд суралцдаг. Африк цагаачдын бүх бүлгийн төлөөлөл энд бий бөгөөд коллежид суралцаж байгаа охид, бүсгүйчүүдийн үзэж харсан зүйл, хэтийн зорилго нь өөр өөр байдаг нь харилцан ярилцах олон боломж бий болгож байна. Өнгөт арьстай залуу хүмүүсийн амьдралд хөгжлийн биологийн үе гэж байдаг болохоор “бүлгийн доторхи” ярилцлага “бүлгүүдийн хоорондын” ярилцлагатай адил, тэр ч бүү хэл зарим үед илүү ч чухал байдаг юм. ХАТКИС-ийн хувьд ч гэсэн энэ хоёр боломжийн аль алиныг нь бүрдүүлэх бололцоотой.

Бидний дотроос олон хүн коллежийг оюутан бүрийг дээд зэрэгт хүргэхийн тулд хөхиүлэн дэмжиж, боломж нөхцлөөр хангаж байдаг газар гэж ойлгодог. Энэ бол бүлгүүдийн хоорондын тэгш, шударга харилцаагаар тодорхойлогддог олон омог, үндэстний хамт олны тухай ойлголт юм. Энэ бол оюутнуудад шүүмжлэлтэйгээр сэлтгэх, ярих, бичих болон тоон үндэслэгээ гаргах аргыг эзэмшүүлэх замаар оюуны хөгжлийг тэтгэн дэмжих ёстой төдийгүй бүх оюутанд янз бүрийн нийгмийн амьдралд үр нөлөөтэй оролцоход шаардагдах ур чадвар, дадлага туршлага эзэмшүүлэх ёстой боловсролын тухай ойлголт юм. Америкийн нийгмийн өргөн хүрээнд, мөн миний мэдэхээр өөр хаана ч боловсролын ийм үвтэгш орчин ерөөс байхгүй. Гэхдээ ийм ойлголт бол үлгэр болох зураг юм.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлтнь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно..

ШАШНААС ХАМААРАЛТАЙ КОЛЛЕЖИУД

Дээдийн гэгээн Дэвид М. О’Коннелл, С. М.



Чрис Грийнберг/Америкийн Католик шашны Их сургууль
Вашингтонд байдаг Америкийн Католик шашны Их сургуулийн энэ оюутан номоо үзэх тайван газар олжээ

АНУ-ын шашнаас хамааралтай бүх коллеж, их сургууль шашны болон шинжлэх ухааны сургалтыг хослуулан явуулах өөрийн гэсэн арга барилтай. Энэхүү нийтлэлд Америкийн Католик шашны Их сургуулийн захирал, Шашны коллежуудын ирээдүй сэдвээр Харвардын Их сургуулиас зохиосон Бага хуралд илтгэл тавьсан санваартан Дэвид М. О’Коннелл дээд боловсролд “нэмэгдсэн өртөг” бий болгож байгаа шашны коллежуудын талаарх үзэл бодлоо дэлгэж байна. Энэхүү нийтлэлийн дагуу бусад зарим хандлагыг тайлбарлах зорилгоор шашнаасхамааралтай бусад сургуулиудын талаарх мэдээллийг бид энд мөн оруулав. Аль нэг тодорхой сургуулийн өвөрмөц шинжтэй бодлого буюу баримталдаг онолыг сонирхож буй хүмүүс илүү бүрэн мэдээлэл авъя гэвэл эдгээр сургуультай шууд холбоо барих нь зүйтэй. Энэхүү сэтгүүлд ийм мэдээлэл оруулсан нь уншигчдыг мэдээллийн эх сурвалжаар хангах гэснээс бус аливаа тодорхой номлол буюу хөтөлбөрийг дэмжих зорилго агуулаагүй юм.

Оюутнуудыг өөртөө татахын төлөө улам бүр ширүүсч байгаа өрсөлдөөн дунд АНУ-ын коллеж, их сургуулиуд тэдний юу нь хосгүй болох, юу нь онцгойлон анхаарвал зохилтойг

ирээдүйн оюутнууддаа харуулж өгөх ёстой. Сургууль болгон энэ тэр аль нэг хичээлийн хөтөлбөр “хамгийн сайн”, үүгээр “гаргууд мэдлэг” олгоно хэмээх боловч “бусдаас гойд ялгардаг” гэдгийг нь илтгэн харуулж чадах ямар нэг зүйл тэдэнд байгаа юу? Шашны сургуулиудын шашны бус сургуулиас ялгарах онцлог нь сүсэг бишрэлийн үнэлэмж юм.

Тодорхой шашин буюу сүсэг бишрэлийн шууд нөлөөнд байдаг коллежийн хувьд шашны сургуулиуд нь (1) дээд сургуулиудын хүрээнд өөрийн гэсэн ялгагдах онцлогтой бөгөөд (2) энэ нь сүсэг бишрэлээр дамжуулан дээд боловсрол эзэмшүүлэхэд тус нэмэр болно хэмээн итгэдгээ шашны бус сургуулиудад хэлж байна.

Боловсрол оюун санааг гэгээрүүлж, ухаан бодлоор дамжин хүний мэдлэг чадварт ач тусаа өгдөг. Ийнхүү шашны боловсрол нь эргэцүүлэл, сүсэглэл хоёрын Бурхан тэнгэр гэдэг утгаар хүний мэдлэг чадварыг тодорхойлж байдаг. Шашны боловсрол оюун санаа, дотоод сэтгэлийг гэгээрүүлдэг. Бид шашны боловсролоор дамжуулан тунгаан бодох чадвартай тархи ухаанаар л хүрэх боломжтой, гэхдээ илүү гүнзгий түвшинд сүсэглэх сэтгэлд хүртээмжтэй, утга төгөлдөр үнэнтэй учирдаг юм. “Шашин бол юуны өмнө бодит байдлын бус ухамсрын асуудал юм” гэж би нэгэнтээ уншсан билээ.



Даррон Куммингс, AP/WWWP
АНУ-ын Эмэгтэйчүүдийн
Үндэсний сагсан бөмбөгийн
тэмцээний үеэр Уэст Индийн
Сент Винсентээс Бэйлорын
Их сургуульд ирж суралцаж
буй оюутан эмэгтэй багийнхаа
тамирчин Өмнөд Техасын
Баптист шашны сургуулийн
оюутнуудтай ярилцаж байгаа нь

оролцохыг нэг их ач холбогдолтойд тооцолгүй явж ирсэн бөгөөд тиймээс ч дээд боловсролын ялгаатай хоёр загвар болон түүнд хандах хоёр өөр хандлага буюу цэвэр шашны бус загвар/хандлага, шашны загвар/хандлага бий болсон юм. Оюутан болон түүний эцэг эх шашны коллеж юмуу их сургуулийг сонгохын цагт өөрийн гэсэн ялгарах онцлогтой, шашны өвөрмөц уламжлалд үндэслэсэн эрхэм зорилготой сургуулиудыг сонгож байна. Ийм

Шашны коллежууд эргэцүүлэл, сүсэглэл хоёрыг нэгэн цогц үнэний салангид биш, ялгаатай хэдий ч хоорондоо холбоотой бүрдэл хэсэг мэтээр харуулахыг зорьж байна. Дээд боловсролын хамгийн гарамгай, өргөн олонд хүлээн зөвшөөрөгдсөн зарим сургууль өөрсдийгөө сүсэг бишрэлээс гаралтай хэмээн тодорхойлснийг тэмдэглэхэд сонин байна. Гэхдээ зарим учир шалтгаанаар шашны холбоотой эдгээр сургууль цаг хугацааны явцад эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд

уламжлал сургуульд, сургуулийн үйл ажиллагаанд нэвт шингэсэн байх ёстой. Энэ уламжлал хичээлийн анги танхимд ч, оюутны хотхон доторхи амьдралд ч ил тодорхой харагдах учиртай. Сургууль болон тэндэхийн ажиллагсад нь энэхүү эрхэм зорилгод үнэнч байх ёстой бөгөөд онолын хичээлд онцын ач холбогдол өгөхгүй байгаад санаа амарлингуй байх учиргүй. Хэрвээ онолын мэдлэг олгодог сургуулиуд нь үнэхээр шашны сургууль мөн бол шашны коллеж, түүний хүлээсэн үүрэг дээд боловсролд “нэмэгдсэн өртөг” болдгийг, мөн энэхүү нэмэгдсэн өртөг нь хүмүүсийн сонирхдог зүйл, үнэхээр хүсч байгаа мэдлэгийг нь олгох замаар хүмүүсийг сургуулийнхаа зүгт татдаг тийм зүйл юм гэдгийг тэнд сурч байгаа болон сурдаггүй хэн бүхэн тодорхой ойлгох болно. Энэ нь тэр хүмүүсийн боловсрол, амьдралд ач холбогдолтой. Шашны коллежууд шашны болон онолын ерөнхий мэдлэг олгохын хувьд бусдаас дээгүүр гэдгээ урт удаан хугацаанд хэрэгцээтэй боловсрол эзэмшихийг хүсдэг хүмүүст харуулж чадах байдал, эцсийн дүнд үүргээ гүйцэтгэх чадвар нь Америкийн дээд боловсролын онцлог шинж болсон жинхэнэ олон талт байдлыг дэмжин хөгжүүлэхэд тус нэмэр болох юм.

Энэ бол мэдээж Америкийн Нэгдсэн Улс дахь Католик шашны Үндэсний Их сургууль болох Вашингтон хотын Америкийн Католик шашинтны Их сургуульд баримталж байгаа номлол юм.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлтнь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно..

Кэмпбеллийн Их сургууль – Хойт Каролина дахь Өмнөдийн Баптист (Протестант) шашны энэ сургууль нь шүүмжлэлтэйгээр тунгаан эргэцүүлэх арга; оюуны, соёлын болон шашны өв уламжлалыг үнэлэх үнэлэмж; биеэ захирах чадвар; хүмүүстэй хамтран аж төрж, ажиллаж байгаа ертөнц, нийгмээ ухамсарлан ойлгох явдал хосолсон бие, оюун болон дотоод сэтгэлийн цул байдлаар тодорхойлогдох Христосын шажинтан цогц хувь хүн болж хөгжихөд нь оюутнуудад туслах явдлыг өөрийн эрхэм зорилго хэмээн тайлбарлаж байна. Энэхүү Их сургууль хүн болж төрсний хувьд хийх ёстой зүйлийг шүтэн бишрэх, эрэл хайгуул хийж амьдрахын хоорондын зөрчилдөөнгүйгээр үнэнч, нигүүлсэнгүй амьдрах явдал гэж үздэг.

Брэндисийн Их сургууль – Массачусетс дэх энэ их сургууль эрдэм шинжилгээний хамгийн залуу их сургуулиудын нэг, Иеудийн шашны дэмжлэгтэй, аль ч шашныхныг хүлээн авч сургадаг улсдаа цорын ганц сургууль юм. Брэндисийн Их сургуулийн эрхэм зорилгын тухай Мэдэгдлээс үзвэл жүүдийн ёсзүйн болон соёлын эрхэм үнэт зүйлсийг хадгалах, Жүүдийн боловсрол эзэмших амлалтаар АНУ-д талархал илэрхийлэх зорилгоор Америкийн Жүүдийн нийгэмлэгийн ивээн тэтгэсэнээр шашны ялгаваргүй тус Их сургуулийг 1948 онд байгуулжээ. Аливаа үндэстэн, шашин болон улстөрийн чиг баримжааг ялгаварлалгүйгээр оюутан, багш, ажилтнуудыг хүлээн авдаг олон шашны Их сургууль болохын хувьд Брэндис нь Америкийн соёлын олон эшт байдал, тэгш боломж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний өв уламжлалыг сэргээж байна.

Номхон далайн Лютеран шашинтны Коллеж – Вашингтон муж улсад байдаг тус сургуулийг Протестаны Лютеран шашин шүтдэг оршин суугчид үндэслэн байгуулжээ. Номхон далайн Лютеран шажинтны Коллеж нь бурхан шүтэж амьдрахад сургах чиглэл, мөн сургалтын хөтөлбөрийг нэгтгэх, идэвхтэй сургах аргыг гол болгосон онолын мэдлэгийн гаргууд, өвөрмөц хөтөлбөрүүдээ ихэд үнэлдэг юм.

Хартфордын Семинар – Коннектикутад байдаг энэ сургуулийг Протестаны Христос шажинтны нэгдлийн сүсэгтнүүд үндэслэн байгуулжээ. Өнөөдөр семинарт Христос шашны боловсролын хөтөлбөрүүдээс гадна Ислам шашин судалдаг Дунканы Хар арьстнуудын МакДональдсын Төв, Христос-Исламын Харилцаа болон магистрын зэрэг олгодог Исламын санваартны хөтөлбөр багтаж байна. Семинарын зорилго нь өнөөгийн олон шашинт, олон ургальч ертөнцөд ойлголцож, үнэнчээр амьдрах удирдагч, оюутан, сурагч болон шашны байгууллагуудыг бэлтгэх; зааж сургах, эрэл хайгуул хийх, олон нийтэд мэдээлэл хүргэх болон хүмүүсийг харилцан ярилцуулах; ялгаатай болон нийтлэг зүйлсийг ил судлахын зэрэгцээ сүсэг бишрэл, нийгмийн нөхцөл байдлын өвөрмөц талуудыг хүлээн зөвшөөрөх замаар Бурхны үйлст үйлчлэх явдал юм.

ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИУД

Майкл Жей Фридман



Мэтью С. Ганби, AP/WWP

Мэрилэнд дэх АНУ-ын Тэнгисийн цэргийн Академийн хиймэл дагуулын загвар бүтээх курсийн оюутнууд зааварлагч багштайгаа ажиллаж байгаа нь. Өнөөдөр энэхүү хөтөлбөрийнхний бүтээсэн хоёр хиймэл дагуул тойрог замд яваа.

Судалгааны тодорхой салбаруудаар сургалт явуулдаг коллежууд Америкийн Нэгдсэн Улсад бий. Зохиогч урлаг, бизнес буюу цэргийн чиглэлээр сургалт явуулдаг цөөн хэдэн сургуулийн талаар ярьж байна. Майкл Жей Фридман бол АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын мэдээллийн Хөтөлбөрийн Товчоонд орон тооны зохиогчоор ажилладаг хүн.

Америкийн олон их сургууль өргөн хүрээтэй сургалтыг санал болгодог бол зарим нь илүү тодорхой хүрээн дэх сургалтын хөтөлбөрөөр хичээл явуулдаг. Дүрслэх болон тайз дэлгэцийн урлаг, бизнесийн болон технологийн ур дүй буюу цэргийн хэрэг зэрэг тодорхой салбаруудаар төрөлжсөн мэргэжлийн эдгээр сургууль оюутнуудад тодорхой нэг салбарт төвлөрсөн хөтөлбөрөөр хичээллэх боломж олгож байна. Энэхүү хандлага оюутан бүрт машинд нийцтэй биш боловч зарим оюутны хувьд тохирсон мэргэжлийн зарим сургууль онцгой авьяасыг хөгжүүлж, тодорхой ур чадвар эзэмшүүлэн, адил мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажиллах боломж олгодог. Энд дурдсан сургуулиуд нь байгаа боломжийн зөвхөн цөөн хэдийг нь л харуулж байна.

Нью Йорк хотноо байдаг хамгийн шилдэг сургууль болох Жулиардын Сургууль нь оюутнууддаа зориулан хөгжим, бүжиг, жүжгийн чиглэлээр урьдчилсан сургалт явуулдаг. Энэ сургуульд АНУ-ын 43 муж улс, гадаадын 43 орноос оюутан ирж суралцдаг бөгөөд нэр цуутай олон төгсөгчдийнх нь дунд нэрт жүжигчин Йтзак Перлман, Ёо-Ёо Ма, Пинчас Цукерман; шинэ чиглэлийн жааз хөгжмийн төлөөлөгч Телониус Монк, Уинтон Марсалис; тунгалаг цээл хоолойтой дуурийн дуучин Леонтин Прайсаас хөнгөн хөгжмийн хамтлагийн дуучин, хүчтэй хоолойтой Нина Симон хүртэлх дуучид байгаа юм. 1971 оноос хойш тус сургууль олон хүн улс орны анхны урлагийн цогцолбор бөгөөд Жулиардаас гадна Метрополитений Дуурийн театр, Нью Йоркийн Филармони, Линкольн дэх Жааз хөгжим болон урлагийн бусад найман байгууллагын гэр орон хэмээн үздэг Манхэттэний Линкольн төвд ирж байрлажээ.

Харьцангуй шинэ сургууль болох Жоржиа муж улсын Саванахад байдаг Саванахын Урлаг, дизайны Коллеж (СУДК) үзүүлэх болон тайз дэлгэцийн урлаг, дизайн, мөн бүтээх болон дүрслэх урлаг, уран барилгын түүхийн мэргэжлээр оюутан сургаж байна. Энэхүү төв судалгаа шинжилгээний буюу

хүмүүнлэгийн ухааны сургуулиудад нийтлэг байдаггүй гол мэргэжлийн хичээлүүдийг заах боломжийг Саванахад олгож байна. Оюутнууд сурталчилгааны дизайн, хүүхэлдэйн кино, реклам чимэглэлийн гэрэл зураг болон бусад хэдэн арван төрлөөр мэргэжлийн зэрэг авдаг. Эдгээр салбарын аль нэгээр мэргэжил эзэмших гэж буй олон оюутан хичээлээ нэг дор төвлөрүүлэн явуулах боломжийг



Пигер Шааф/Жулиардын Сургууль

Нью Йоркийн Жулиардын Сургуулийн жааз хөгжмийн хамтлагийг уран сайхны удирдаач Виктор Гоинс удирддаг.

өндөр үнэлдэг юм. Коллежийн захирал Паула С. Уолласын хэлсэнчлэн “СУДК-ийн оюутнууд гоо сайхны ойлголтоо мэргэжлийн тусгай мэдлэг болон өгөөжтэй хэгийн ажил үйл болгон хувиргах техникийн ур чадвар бүхий бүтээлч сэтгэлгээг олж авч байна”.

Дизайн болон дүрслэх урлагийн зам хөөх гэсэн оюутнууд СУДК болон Жулиард мэтийн сургуулиудад орж суралцдаг. Бусад олон оюутан бизнесийн ертөнц буюу хөгжиж байгаа технологийн салбарт амжилт олохуйц ур чадвар эзэмших боломжийг эрэлхийлдэг. Эдгээр оюутны дунд насаар ахмад, хэдүйнээ хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс байх нь олонтаа. Ашгийн төлөө хэд хэдэн “өмчийн сургууль” тэдний хэрэгцээг хангахад үйлчилж байна. Оюутны 70 гаруй хотхонтой, он-лайн сургалт



Саванахын Дүрслэх урлаг, дизайны Коллежийн өгсөн зураг

Жоржиа муж улсын Саванахын Дүрслэх урлаг, дизайны Коллежийн багш, оюутан хоёр хүүхэлдэйн киноны хичээл дээр загвар болон жинхэнэ дүрийг үзэж байгаа нь

явуулдаг ДеВри Их сургууль зэрэг сургуулиуд голдуу бүрэн бус цагаар буюу их сургуулиас гадуур бүтэн ээлжээр ажилладаг мэргэжлийн багш, ажиллагсад бүхий нэмэлт багш нарын бүрэлдэхүүнээр практик зааварчилгаа өгдөг. Өмчийн сургуулиуд нь голдуу шөний цагаар болон амралтын өдрүүдэд хичээллүүлэх буюу бүрэн бус цагаар хичээллэхийг дэмжих замаар эцэг эхчүүд болон ажил хийдэг оюутнуудын завгүй, шахуу цагийн хуваарийг зохицуулдаг. Компьютерийн шинжлэх ухаан, программчлал, бизнес болон технологийн холбогдолтой бусад салбарт суралцах нь түгээмэл. Америкийн зарим ажил олгогчид ажиллагсдынхаа бизнесийн удирдлагын магистрын зэрэг авахаар үргэлжлүүлэн суралцах сургалтын төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн эргэж төлөгдөх нөхцөлтэйгөөр олгодог.



Стив Матео, AP/WIDEWORLD

Иллинойс муж улсын ДеВри Их сургуулийн Аддисон дахь оюутны хотхоны нэг оюутан телекоммуникацийн төсөл дээр ажиллаж байгаа нь

АНУ-ын ихэнх их сургууль эсвэл хувийн, эсвэл муж улсаас буюу зарим үед орон нутгийн захиргаанаас санхүүждэг сургуулиуд байдаг. Гэхдээ Холбооны засгийн газар Армитай холбоотой АНУ-ын Цэргийн Академи; Цэргийн нисэх хүчний болон Тэнгисийн цэргийн Академиуд болон Эргийн хамгаалалтын, Худалдааны флот зэрэг үндэсний цэргийн академиудын үйл ажиллагааг хариуцан явуулдаг.

Жишээ болгон дурдахад, Мэриленд муж улсын Анаполис дахь АНУ-ын Тэнгисийн цэргийн Академид элсэхэд маш өндөр шалгууртай бөгөөд оюутнуудыг (Тэнгисийн цэргийн сургуулийн сонсогч гэдэг) Конгрессын аль нэг гишүүн, АНУ-ын Ерөнхийлөгч болон дэд Ерөнхийлөгч, Тэнгисийн цэргийн Флотын командлагч сонгон томилдог. Цэргийн сургуулийн сонсогч нь нас, бие бялдар болон ерөнхий мэдлэгийн талаар тавигддаг шаардлагыг хангаж байх ёстойгоос гадна гэрлээгүй байх ёстой. Түүнчлэн АНУ-ын иргэн

байх шаардлагатай боловч олон улсын болон флот хоорондын харилцааны ашиг сонирхлын үүднээс Батлан хамгаалахын сайдын томилсон 60 хүртэлх тооны гадаадын сонсогч оюутан элсэн суралцаж болно. 1976 оноос хойш эмэгтэйчүүд элсэх боломжтой болсон бөгөөд нэгдүгээр ангийн 2009 элсэгчдийн тавны нэг орчим нь эмэгтэйчүүд байна.

Сонсогч болгон үнэ төлбөргүй суралцаж, дотуур байранд амьдардаг бөгөөд сар бүр тэтгэлэг авдаг. Хичээлийн хөтөлбөр нь математик, техникийн ухаан, тэнгисийн цэргийн хэрэгт голчлон чиглэдэг бөгөөд олон сонсогч далай судлал, агаар-сансрын технологи, буюу тэнгисийн барилга байгууламж зэрэг далайн холбогдолтой хичээлүүдийг сонгодог. Зарим нь түүх, эдийн засаг болон бололцоотой бусад төрлийн чиглэлийг судлахад анхаарлаа төвлөрүүлдэг. Төгсөгчид АНУ-ын Тэнгисийн цэргийн дэслэгч буюу Усан цэргийн бага дэслэгч цолтой төгсдөг бөгөөд доод тал нь зургаан жил жинхэнэ цэргийн алба хаах үүрэгтэй байдаг.

Энэхүү товч мэдээлэлд Америкийн Нэгдсэн Улсад байдаг бүрэн дунд боловсролын дараах төрөл бүрийн шатны боловсролын талаар л зөвхөн дурдав. Мэргэжлийн дээд сургуулиуд нь бүрэн бус ээлжээр суралцагсад, эцэг эхчүүд болон хөдөлмөр эрхэлж

байгаа хүмүүс зэрэг уламжлалт бус оюутнуудад үйлчлэх замаар судалгаа шинжилгээний болон хүмүүнлэгийн ухааны сургуулиудын орыг нөхөж байдаг. Түүнчлэн ихэнхдээ илүү нарийн чиглэлтэй тэдний сургалтын хөтөлбөр төрөлхийн авьяаслаг, зорилгодоо хүрэх гэсэн эрмэлзэл тэмүүлэлтэй оюутнуудад авьяас чадвараа хөгжүүлэх, мэргэжлийн зорилгодоо хүрэхэд нь туслаж чадна.

КОЛЛЕЖИЙН ЗЭРЭГЛЭЛ

Зөвлөгч нар сургалтын хөтөлбөр, хэмжээ, арга барил, төлбөр, байршлаа хамгийн сайн хослуулсан коллежийг сонгохыг ирээдүйн оюутнуудад зөвлөж байна. Ирээдүйн оюутнуудад Америкийн Нэгдсэн Улсын мянга мянган коллеж, их сургуулиудаас сонголт хийхэд нь тус болох олон материал байгаагийн дотроос тэдгээрийг зэрэгцүүлэн үнэлэх хэд хэдэн хэрэгсэл буй.

- Петерсон болон Каплан нь боловсролын холбогдолтой олон янзын бүтээгдэхүүн гаргадаг хоёр компани юм. Peterson's guide to Competitive Colleges хэмээх Петерсоны лавлах байдаг. Kaplan Publishing's Most Interesting Colleges болон 2005 – The Unofficial Unbiased Guide to the 331 Most Interesting Colleges нэртэй товхимлуудыг Каплан гаргасан байна.

- Томоохон сонинуудад боловсролын асуудлаар бичдэг хүмүүс санал болгож буй сургуулиудынхаа жагсаалтыг мөн гаргажээ. Нью Йорк таймс сонинд боловсролын сэдвээр олон жил бичиж байгаа Лорен Попе Pope's Colleges that change Lives, 40 Schools You should know About Even if You're Not a Straight-A Student; Нью Йорк таймс сонины боловсролын асуудал хариуцсан редактор асан Эдвард Б. Фиске Fiske Guide to Colleges зэрэг товхимол гаргасан бөгөөд Вашингтон Пост сонинд боловсролын сэдвээр бичдэг Жей Мэттью Harvard Schmarvard: Getting Beyond the Ivy League to the Colleges That is Best for You лавлахдаа сонгож болох нэр хүндтэй 10 коллежийг жагсааж үзүүлсэн байна.

- Пенсильвани дахь Темплетоны Сан Templeton Guide: Colleges That Encourage Character Development товхимол гаргасан байна.

- Коллежийн ахмад зөвлөх Фредерик Е. Рагг коллежуудыг санал болгохын зэрэгцээ чанартай сургуулиудын нэртэй тэнхимүүдийн жагсаалтыг гаргаж үзүүлсэн Rugg's Recommendations on the Colleges товхимол бичжээ.

- Yale Daily News's The Insider's Guide to the Colleges 2005 лавлахад коллежийн зэрэглэлийг тогтоохын тулд албаны хүмүүсийн илтгэлд бус оюутнуудтай хийсэн ярилцлагад тулгуурлан 300 гаруй коллежийн амьдралыг харуулжээ.

Томоохон сэтгүүлүүд ч мөн адил харьцуулалт хийж байна. Хэд хэдэн сэтгүүлд ихээхэн анхаарал татаж байгаа коллежуудын зэрэглэлийн жагсаалтыг гаргажээ. Эдгээрийн дотроос хамгийн нөлөө бүхий, хамгийн их ишлэлд хэрэглэгддэг Education USA and World Report сонины "America's Best Graduate Schools" болон "America's Best Colleges" [<http://www.usnews.com/usnews/home.htm>] болно.

Education USA сэтгүүлд үндэсний их сургуулиуд (улсын хэмжээгээр жагсаасан), магистрын зэрэг олгодог их сургуулиуд (бүс нутгаар жагсаасан), бизнесийн хамгийн сайн хөтөлбөрүүд, хүмүүнлэгийн ухааны хамгийн сайн коллежууд, техникийн ухааны дээд зэргийн хөтөлбөрүүд, хамгийн сайн

цогцолбор их сургуулиуд гэсэн хэд хэдэн ангиллаар коллежуудын зэрэглэл, тэдгээрийн талаарх гол мэдээллийг агуулсан, эхлэн суралцах хүчтэй сайн хөтөлбөртэй, суралцагсадын 50 гаруй хувь нь хүмүүнлэгийн ухааны хичээлүүдээс гадна өөр ямар нэг зүйл судалдаг (бүсчилсэн жагсаалтад орсон) коллежуудын үндэсний хэмжээний жагсаалтыг нийтэлсэн байна.

Хамгийн сүүлчийн эх сурвалж бол Урбана-Чемпэйн дэх Иллинойсын Их сургуулийн Боловсрол, Нийгмийн ухааны номын сангийн веб-сайт болно. Энэхүү сайт зэрэглэл тогтоох алба, коллеж, их сургуулиудын талаарх мэдээллийн өөр эх сурвалжуудтай холбож өгнө. Бүр зарим сайт дээд зэрэглэлийн харьцангуй үнэ цэнийн талаар ч авч үзэх нь бий. [<http://www.library.uiuc.edu/edx/rankings.htm>]

АМЕРИКИЙН "ТОП" СУРГУУЛИУД

Америкийн шилдэг сургуулиуд

Ю-Эс энд Уорлд Рипорт сэтгүүлд бичсэнээр "дээд зэргийн" хэмээгдэх нь олонтаа байдаг зуун их сургуулийн зарим нь төрийн буюу муж улсын их сургууль, зарим нь хувийн их сургууль байдаг. Бүлэг болгоход сургуулиудад үзэж байгаа хичээлийн чанар, том хэмжээний лаборатори болон номын сан зэрэг хөрөнгийн байдал, эдгээр сургуультай холбоотой байдаг төгсөгчид болон дэмжин туслагчдын өргөн сүлжээ зэргийг харгалзаж үзсэн байна. Эдгээр их сургуульд дипломын өмнөх боловсролын олон төрлийн хичээл ордог бөгөөд магистрын болон докторын зэрэг олгодогос ихэнх нь судалгааны ажлыг чухалчилдаг.

Ю-Эс энд Уорлд Рипорт, 2006 оны үндэсний шилдэг 20 их сургууль:

1/2 Харвардын их сургууль, Принстоны их сургууль

3 Ёйлын их сургууль

4 Пеннсилванийн их сургууль

5/6 Дюкийн их сургууль, Стенфордын их сургууль

7/8 Калифорнийн технологийн институт,

Массачусеттсийн технологийн институт

9/10 Колумбийн их сургууль, Дартмуутын коллеж

11 Сент Луис дахь Вашингтоны их сургууль

12 Нортвестерн их сургууль

13/14 Корнеллын их сургууль, Жонс Хопкинсын их сургууль

15/16 Броуны их сургууль, Чикагогийн их сургууль

17 Райсын их сургууль

18/19 Нотр Дамын их сургууль, Вандербилтын их сургууль

20/21 Ернорын их сургууль, Калифорни-Берkeleyн их сургууль

[http://www.usnews.com/usnews/edu/college/rankings/rankindex_brief.php]

БИЗНЕСИЙН БОЛОН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ЧИГЛЭЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮД

Олон байгууллага АНУ-ын коллеж, их сургуулиудын зэрэглэл, үнэлгээг тогтоох буюу тойм шүүмж гаргадаг. Янз бүрийн жагсаалт хоорондоо хэр нийцэж байгааг тогтоох гэсэн аливаа байгууллагын хувьд харамсалтай нь эдгээр байгууллага нэг л төрлийн сургуулиудын чиглэлээр хааяахан зохион байгуулагдсан байдаг бөгөөд нэг л төрлийн эх сурвалж (жишээ нь, албаны хүмүүсийн илтгэл) ашиглах буюу онцсайн, эсвэл хамгийн сайн гэсэн нэг л янзын тодорхойлолтын талыг барьдаг байна. Жишээ нь, хоёр салбар дахь хамгийн чанартай гэсэн сургуулиудын хоёр янзын жагсаалтыг дор үзүүлэв. Янз бүрийн байгууллагын гаргасан зэрэглэлийг харьцуулж, жагсаалт бүрт дээгүүр орсон 20 сургуулийг жагсаах замаар эдгээр жагсаалтыг гаргажээ. Зэрэглэлд жагсаалтын дэс дараа онцын ач холбогдолгүй учраас эдгээр жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар гаргав.

Бакалаврын зэрэг олгох инженерчлэлийн хөтөлбөрүүд

Education USA and World Report сэтгүүлээс гаргасан “2005 оны хамгийн сайн коллеж” ангилал болон Students Review.com-оос тавьсан асуултад Массачусетсийн Технологийн Институтыг төгссөн оюутнуудын өгсөн хариултад үндэслэн энэхүү жагсаалтыг гаргав.

Корнеллын Их сургууль, Нью Йорк
Жонс Хопкины Их сургууль, Мэриленд
Массачусетсийн Технологийн Институт, Массачусетс
Пенсильванийн Улсын Их сургууль, Пенсильвани
Пурдюгийн Их сургууль, Индиана
Ренсселиерын Политехникийн Институт, Нью Йорк
Райсын Их сургууль, Техас
Стэнфордын Их сургууль, Калифорни
Коллеж Стэйшн дэх Техас А ба М Их сургууль, Техас

Урбана-Чэмпэйн дэх Иллинойсын Их сургууль, Иллинойс
Вержинийн Политехникийн Институт болон Улсын Их сургууль, Вержиниа



Эмблем

Бакалаврын зэрэг олгох бизнес сургалтын хөтөлбөрүүд

Education USA and World Report сэтгүүлд гарсан “2005 оны хамгийн сайн коллеж”, Business Week сэтгүүлийн “2004 оны хамгийн сайн бизнесийн сургууль” (энэхүү жагсаалтыг хоёр жил тутам гаргадаг) жагсаалтууд болон Forbes сэтгүүлд тухайн сургуульд суралцагчдын оруулсан хөрөнгийн дээд зэргийн үр өгөөжийг харуулахыг чармайсан 2003 оны бизнесийн сургуулийн зэрэглэлийн жагсаалтыг ашиглан дараах жагсаалтыг гаргав.

Карнеги Меллоны Их сургууль, Пенсильвани
Корнеллийн Их сургууль, Нью Йорк
Эморийн Их сургууль, Жоржиа
Массачусетсийн Технологийн Институт, Массачусетс
Нью Йоркийн Их сургууль, Нью Йорк
Мичиганы Их сургууль, Мичиган
Чапел Хилл дэх Хойт Каролины Их сургууль, Хойт Каролина
Пенсильванийн Их сургууль, Пенсильвани
Аустин дэх Техасын Их сургууль, Техас
Вержинийн Их сургууль, Вержиниа



АЙВИЙН ЛИГИЙН СУРГУУЛИУД

“Айвийн Лиги” гэдэг нь АНУ-ын хамгийн түүхтэй, хамгийн нэр хүндтэй их сургуулиудын найм нь юм. Эдгээр сургууль нь уг холбооныхоо нэрээр спортын тэмцээнд оролцох, тамирчид нь хичээл сурлагадаа мөн адилхан амжилт гаргах тохиролцоотой ажилладаг. АНУ-ын хамгийн эртний дээд сургуулийн тоонд ордог эдгээр коллежийн ихэнх нь ороонго өвсөөр дээвэрлэсэн эртний

барилга байшингуудаараа онцлог, оюутны өвөрмөц, түүхэн хотхонуудтай. Гишүүн сургуулиудыг нь Айвийн Холбоо хэмээдэг. АНУ-ын дээд зэрэглэлийн сургуулиудын тоонд Брауны Их сургууль, Колумбийн Их сургууль, Корнеллийн Их сургууль, Дартмусын Их сургууль, Харвардын Их сургууль, Пенсильванийн Их сургууль, Принстоны Их сургууль болон Йелийн Их сургууль гэсэн найман сургууль багтдаг. Сургуулиудын нэр, Айвийн Лиги гэсэн нэр Америк дээд боловсролын дүр төрхийг илтгэн харуулсаар байна.



Education USA and World Report бол АНУ-ын Төрийн Департаментын Боловсрол, Соёлын хэрэг эрхлэх Товчооны дэмжлэгтэйгээр дэлхийн 170 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг зуучлал, мэдээллийн 450 гаруй төвийг нэгтгэсэн дэлхийн хэмжээний сүлжээ юм. Эдгээр төвүүд нь АНУ-д боловсрол эзэмших боломжийн талаар бүх талын, үнэн зөв, бодитой, цаг үеийн мэдээлэл өгөх, шалгаруулалтад тэнцсэн хүмүүст эдгээр боломжийг хэрхэн ашиглах талаар зааварчлага өгөх зэргээр АНУ-ын дээд боловсролыг идэвхтэй дэмжиж байна.

Education USA and World Report -ийн зуучлах төвүүдэд олонхи нь өөрсдөө АНУ-д суралцсан болон/буюу АНУ-ын Төрийн Департаментаас зөвшөөрөн баталсан АНУ-ын дээд боловсрол болон зуучлах үйл ажиллагааны талаарх сургалтанд хамрагдаж арга туршлага эзэмшсэн мэргэжлийн зөвлөхүүд ажилладаг. Тэдгээр хүмүүс ойролцоогоор жил бүр АНУ-д ирж суралцах 25 сая гадаад оюутнуудад биечлэн, утсаар, цахим шуудангаар буюу интернетээр дамжуулан туслалцаа үзүүлж байна.

Education USA and World Report -ийн зөвлөхүүд гадаадын оюутнуудад коллежид орж суралцах талаар судалгаа хийх бүх үе шатанд маш олон төрлийн мэдээлэл, үйлчилгээгээр үнэгүй хангаж байна. Тэдгээр хүмүүс АНУ-ын олон төрлийн коллеж, их сургуулиудын ялгааг мэддэг бөгөөд тухайн хүний боловсрол болон мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг нь хамгийн сайн хангаж чадахуйц сургуулийг хэрхэн олж тодорхойлох талаар мэдээлэл өгдөг. Тэд мөн элсэлтийн журмыг мэдэх учир шалгалт, зохион бичлэг, батлан даалт зэрэг асуудлуудаар зөвлөгөө өгч, мөн санхүүгийн дэмжлэг туслалцаа олж авахад нь туслалцаа үзүүлж чадна.

Education USA and World Report -ийн зөвлөхүүд АНУ-ын цагаачлалын хууль болон аюулгүй байдлын шаардлагуудын талаарх шинэлэг мэдээллийг байнга хүлээж авч байдаг тул оюутны виз мэдүүлэх, ярилцлагад орох талаар зааварчлага өгч мөн чадна.

Education USA and World Report -ийн олон төв зохион бичлэг болон товч намтраа бичих талаар зааж сургах, суралцахаар мордохын өмнөх бэлтгэлийг нь хангуулах, бичиг баримтыг нь орчуулах болон хянах зэргээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.

Танд ойрхон байгаа төвийг <http://www.educationusa.state.gov/> интернэт хаягаар орж олно уу.

ОЛОН УЛСЫН БОЛОВСРОЛЫГ ТЭМДЭГЛЭХ ДОЛОО ХОНОГ


Олон улсын Боловсролын Долоо хоног нь олон улсын боловсрол болон дэлхий нийтийн солилцооны үр өгөөжийг тэмдэглэх нэгэн боломж юм. АНУ-ын Төрийн Департамент болон АНУ-ын Боловсролын Департаментын энэхүү хамтарсан санаачилга бол америкчуудыг даяаршлын орчинд бэлтгэх, ирээдүйн удирдагчдыг хилийн чанадаас уриалан дуудаж АНУ-д суралцуулах, туршлага солилцуулах хөтөлбөрийг дэмжих бидний хүчин чармайлтын нэг хэсэг юм.

Бүх хүмүүс, мөн сургууль, коллеж, их сургууль, ЭСЯ, олон улсын байгууллага, бизнесийн холбоо болон орон нутгийн байгууллагууд зэрэг олон улсын боловсрол, солилцооны үйл ажиллагааг с онирхож байгаа бүх байгууллага, хувь хүмүүсийн оролцоог бид хөхиүлэн дэмжиж байна. [<http://iew.state.gov/>]



Коллежийн амьдралаас

Спелманы Коллежийн өгсөн зураг



Тав тухтай сууж газраа олсон бол коллежийн гэрийн даалгавраа хийх гэдэг хялбархан ажил. Жоржиагийн нарлаг сайхан энэ өдөр хичээлээ давтах нь Спелманы Коллежийн эдгээр оюутанд тун ч тааламжтай байна.



Массачусетсийн Харвардын Их сургуулийн нэгдүгээр курсийн оюутнууд энэ том танхимд хооллодог.

Жон Чейз, AP/WIDEWORLD



Коллежийн амьдралаас



Стефен Тортон, AP/WWP

Зүүн гар талд, Саваннахын Дүрслэх урлаг, дизайны Коллежийн оюутнууд Жоржиагийн сургуульд жил бүр зохиогддог Явган хүний зам дээрх Уран зургийн наадмын үеэр “Амьд урлаг” сэдэвт хичээлээс гадуурх ажилд оролцож байна.

Баруун гар талд, Шри-Ланкаас ирсэн эгч дүү Таранга, Эранга хоёр Гүнтеллике Өмнөд Каролины Конверс Коллеж дэх La Bohemia-гийн суудал дээр. Цунамигаас сар шахмын дараа гамшигт нэрвэгдэгсдэд зориулан тэд жүжигт тоглож 8000 доллар цуглуулсан бөгөөд дуурт дуулж илүү их мөнгө хуримтлуулна гэж найдаж байна.



Мэри Анн Частайн, AP/WWP



Сара Д. Дэвис, AP/WWP

Зүүн гар талд, Эмэгтэйчүүдийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн Нотр-Дамын Их сургууль, Калифорни-Лос Анжелесын Их сургуулийн (КЛАИС) тоглогчдын өрсөлдөөнийг өрнүүлэв.



Коллежийн амьдралаас



Линда А. Цицерон, Стэнфордын Мэдээний алба



Зүүн гар талд, Стэнфордын Ардын урлагийн бүжгэн жүжиг, ба доод талд, Линда А. Цицерон, Стэнфордын Мэдээний алба, оюутнуудын тоглосон Стэнфордын Тарнийн бүжиг зэрэг нь 1970-аад оноос эхтэй, Калифорнийн Их сургуулийн хамт олны гишүүдэд бие биенээ илүүтэй таньж мэдэхэд туслах зорилготой соёлын арга хэмжээнүүдийн жишээ юм. Бүжгэн жүжиг нь Мексикийн соёлыг сурталчилж байна. Стэнфордын Америкийн Индианчуудын Байгууллагаас зохион байгуулдаг тарнийн бүжигт тус улсын өнцөг булан бүрээс ирсэн 30 мянга гаруй хүн оролцдог.

Линда А. Цицерон, Стэнфордын Мэдээний алба



Дэвидсоны Коллежийн өгсөн зураг

Техасын Их сургуулийн хөл бөмбөгийн эдгээр тамирчид коллеж хоорондын хамгийн нэр хүндтэй тэмцээний нэг болох Роуз Боулын тэмцээнд ялалт байгуулжээ.



Райл Сакума, AP/WIDEWORLD

Хойт Каролина дахь Дэвидсоны Коллежийн энэ оюутан хятад хичээнгүй бичгийн дадлага хийж байгаа нь





Коллежийн амьдралаас



Эд Андриески, AP/WWP



Колорадогийн Нисэх хүчний Академийн сонсогчид төгсөлтийнхөө баярыг тэмдэглэж байгаа нь



Дэймон Ж. Харглей

Дээд талд, Төв Мичиганы Их сургуулийн улс төрийн ухааны ангийн оюутнууд Мичиган муж улсын Сенатын гишүүдэд хандан ихээхэн маргаантай байгаа оюутны шагналын тэтгэлгийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах нухацтай санал тавьж байгаа нь



Нати Херник, AP/WWP

Небраскагийн Омаха дахь Метрополитенийн анхан шатны коллежийн оюутнууд их танхимд хичээлээ давтаж байгаа нь





Коллежийн амьдралаас



Жен Блайт, AP/WWP

Жоржиа муж улсын Их сургуулийн үлээвэр хөгжимчид сагсан бөмбөгийн тэмцээнд хүчээ нэмэрлэж байгаа нь



Матт Хаустон, AP/WWP

Дээд талд, Мэрилэндийн Их сургуулийн оюутан гэрийн тавилга хийж байгаа нь. Тэр эмэгтэйн багийнхан Вашингтоны ойролцоох Үндэсний худалдааны төвд олны өмнө шинэ технологи танилцуулах Соляр Декатлон-д зориулсан загвар бүтээж байна.

Фред Фолк, AP/WWP



Миссиссипи муж улсын Их сургуулийн оюутнууд 2001 оны есдүгээр сарын 11-ний террорист халдлагад өртөгсдийн дурсгалыг хүндэтгэхээр цуглараад байгаа нь

ПЕНСИЛЬВАНИЙН ИХ СУРГУУЛИЙН ГАДААД ХАРИЛЦАА

Майкл Ж. Фридман



Франк Плантан

Ливиа Рюар-Хьюгенс, Мохаммад аль-Али, Мэттью Фриш нар (зүүнээс баруун гар тийш) нар Пенсильванийн Их сургуулийн Гадаад харилцааны хөтөлбөрийн дагуу суралцаж байгаа оюутнууд юм

Манай тэргүүлэх их сургуулиудын нэгэнд хэрэгжүүлж байгаа салбар хоорондын энэхүү хөтөлбөр дэлхийн хэрэг явдлыг сонирхдог оюутнуудад тодорхой зорилгод нийцүүлэн хичээллэх боломжийг олгож байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу тэд эх орондоо болон хилийн чанадад бизнес, удирдлага, эрдэм шинжилгээ болон бусад салбарын мөр хөөхөөр бэлтгэгдэж байна. Майкл Жей Фридман бол АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн Товчооны орон тооны зохиогч юм.

АНУ-ын их сургуулиудад суралцаж байгаа оюутнууд голдуу хоёрдахь жилийнхээ эцсээр ямар “гол” салбарын чиглэлээр суралцахаа сонгон хүсэлтээ гаргадаг. Эдийн засаг, улс төр болон соёлын даяаршил өргөжиж буй болохоор олон улсын харилцаа (ОУХ) Филадельфид байдаг Пенсильванийн Их сургуульд үзэх хамгийн түгээмэл хөтөлбөрийн нэг болжээ. ОУХ нь томилогдсон сургагч багшийн удирдлага дор хэд хэдэн янзын салбарт курсын ажил хийж, 40-50 хуудас сэдэв бичиж ирүүлэхийг шаарддаг салбар хоорондын хөтөлбөр юм.

Гол мэргэжлээрээ суралцахад элсэлтийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай. Өргөдөл гаргагч нь (4.0 гэсэн үнэлгээгээр) 2,8 дундаж оноо авсан байх, мөн улстөр, өрнөдийн иргэншил, микро-болон макро эдийн засгийн чиглэлээр бэлтгэл анги төгссөн байх шаардлагатай. Элсэн орсныхоо дараа оюутнууд олон улсын харилцааны онол, олон улсын эдийн засаг, дипломат харилцааны түүх болон олон улсын бодлогын чиглэлээр үндсэн хөтөлбөрийг үздэг. Дүрслэх урлаг болон байгалийн шинжлэх ухааны Коллеж, мөн Уартоны Бизнесийн Сургуулиас гаргасан саналуудаас сонгон авч баталсан жагсаалтаас үндсэн хөтөлбөрөө сонгох боломж бас бий. Энэ нь Зүүн Азийн судлалаас эхлээд олон улсын санхүүгийн антрапологи хүртэлх судлах зүйлээ аль нэг байдлаар хүсэлдээ нийцүүлэн сонгох боломжийг оюутнуудад олгодог. Оюутнуудад олон улсын харилцаа болон бусад салбар, ихэвчлэн түүх, улстөр, эдийн засгийн ухааны салбарт боловсролын зэрэг олгох олон сонголт байдаг нь “давхар зэрэг” болдог учир ОУХ нь ихээхэн түгээмэл сонголт болдог.

Олон улсын харилцааны хөтөлбөр бүрээр сонгож авсан ОУХ-ны холбоотой асуудлаар сэдэв бичиж хамгаалдаг. Саяхны сонгосон сэдвүүд нь “Хоёр

талын харилцаанд түүхэн санамжийн гүйцэтгэх үүрэг: Япон-Хятад болон Япон-Өмнөд Солонгос” гэдгээс авахуулаад “Олон улсын бизнесийн эрхзүйд Олон үндэстний Корпорациас тавьж буй шаардлага” гэх хүртэл өргөн хүрээтэй байлаа.

Канадын Торонто хотоос ирсэн, төгсөх ангийн оюутан Мэттью Фриш ОУХ-ны хөтөлбөрийг олон төрлийн сэдвээр судалгаа хийх боломж олгодог учраас түүнийг сонгон суралцахаа мэдэгдсэн бөгөөд үүнийг тэр “мэдлэгийнхээ суурийг олон чиглэлээр өргөтгөж байна” гэжээ. Тэрээр Анненбергийн Холбоо харилцааны Сургуульд өөрийн хичээллэдэг сонгон суралцах курсийг өндөр үнэлдэг юм. “Холбоо харилцаа ба Ерөнхийлөгч байхуй” нэртэй тус хөтөлбөр өөрийн сонголтоор ерөнхийлөгчийн номын санд орж судалгаа хийх тэтгэлэг олгодог юм. М. Фриш Жон Ф. Кеннедийн Номын сан болон Бостон дахь Мускум-д очиж, Жон Кеннедийн Хүйтэн дайн ба Иргэний эрхийн бодлогын харилцан үйлчлэл сэдвээр семинарын ажилд зориулан судалгаа хийжээ. Хожим нь түүний энэ ажлыг оюутнуудын эрхлэн гаргадаг Penn History Review сэтгүүлд нийтэлжээ.

АНУ-Кувейтын хос харьяалалтай иргэн, олон улсын харилцаа болон эдийн засгийн хөтөлбөрөөр давхар суралцдаг, гуравдугаар ангийн оюутан Мохаммад Аль-Али нэмж хэлэхдээ ОУХ-ны хөтөлбөр нь түүний хоёр өв соёл, хоёр орчны хооронд буй “ангалыг холбох гүүр” болж байна гэсэн юм. Гэр бүлээрээ АНУ-д улстөрийн орогнол авсан АНУ-Бельгийн хос харьяалалтай иргэн Ливиа Рюар-Хьюгенсийн суралцаж буй олон улсын

харилцаа-франц хэлний давхар хөтөлбөрийн хувьд ОУХ нь түүний сонирхож байгаа дүрвэгсдийн олон улсын эрхзүйн мэргэжил эзэмшихэд нь тус болох хамгийн сайн хөтөлбөр юм.

ОУХ-ны хөтөлбөрийн дагуу суралцагсад нь эрдэм шинжилгээ, нийгэм болон мэргэжлийн өмнөх олон төрлийн үйл ажиллагаанд хамрагддаг бөгөөд олонхи нь оюутнуудын удирддаг Олон улсын харилцааны мэргэжлээр төгсөх ангийн оюутнуудын Холбоо (ОУХТАОХ)-ноос дэмжлэг авдаг. Тус байгууллагын зүгээс оюутнуудын Нью Йорк, Вашингтон хотоор аялж, хууль, эрхзүй болон олон улсын харилцааны чиглэлээр сургалт явуулдаг тэргүүлэх коллеж, их сургуулиудын эрдэмтэн багш нартай хамтарч ажилладаг жил бүрийн аяллыг ивээн тэтгэдэг хэмээн ОУХТАОХ-ны өнөөгийн ерөнхийлөгч Рюар-Хьюгенс хэлж байна.

Пенний ОУХ-ны хөтөлбөрөөр суралцагсад коллеж төгссөнийхөө дараа их зүйл хийж байна. ОУХ-ны Хөтөлбөрийн нэг ерөнхийлөгч Франк Платаны ажигласнаар “олон улсын ажил хэргийн мэдлэгтэй, судалгаа хийх, бичиж боловсруулах болон бусад авьяас чадвартай хүмүүсийн эрэлт маш их байна. Эх орондоо болон хилийн чанадад бизнес, удирдлага, эрдэм шинжилгээний болон бусад салбарт ийм хүмүүс шаардлагатай байна.”

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлтнь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно..

АНУ-ЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ТАЛААРХ ТОЙМ

“Магадлан итгэмжлэл нь дээд боловсролын тогтолцоонд коллеж, их сургуулиуд болон дээд боловсролын хөтөлбөрүүдийн чанарыг хэрхэн хангаж, хэрхэн сайжруулж буй байдлыг нягталдаг чанарын гадаад хяналтын үйл явц юм. Америкийн Нэгдсэн Улсад магадлан итгэмжлэх үйл ажиллагаа 100 гаруй жилийн түүхтэй бөгөөд нийтийн эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх гэсэн санаа зорилгоос үүдэлтэй юм.

АНУ-д магадлан итгэмжлэлийг чухамхүү энэ зорилгоор буй болсон ашгийн төлөө бус хувийн байгууллагууд гүйцэтгэдэг. Дээд боловсролын чанарын гадаад хяналт бол төрийн бус үйл ажиллагаа юм. Бусад оронд магадлан итгэмжлэх, чанарыг хангуулах үйл ажиллагааг голдуу засгийн газар эрхлэн явуулдаг..

Магадлан итгэмжлэгч нар нь 50 муж улс болон гадаадын хэд хэдэн орны коллеж, их сургуулиудад хяналт шалгалт хийдэг. Хууль эрхзүй, анагаах ухаан, бизнес, асрамжлал, нийгмийн хамгааллын ажил, эмзүй, урлаг болон сэтгүүл зүй зэрэг олон мэргэжлийн хүрээнд олон мянган хөтөлбөрийг хянан шалгадаг.”

Дээрх баримт бичгийн дагуу бүс нутгийн, үндэсний, тусгай мэргэжлийн гэсэн гурван төрлийн магадлан итгэмжлэгч бий. Магадлан итгэмжлэл нь чанарыг хангах, холбооны сангаас дэмжлэг авах боломжтой мэргэшлийг тодорхойлох, нэг сургуулиас нөгөөд шилжин суралцах боломжийг хөнгөвчлөх, сургуулиас олгож байгаа мэргэжлийн зэрэг буюу зөвшөөрөлд итгэх итгэлийг ажил олгогчдод төрүүлэх зорилгод үйлчилж буй юм.

[http://www.chea.org/pdf/overview_US_accred_8-30.pdf]

Юдит С. Ийтон

Ерөнхийлөгч, Дээд боловсролын магадлан итгэмжлэл хариуцсан Зөвлөл

ГАДААДЫН ОЮУТНУУД ӨӨРИЙН ОРНЫ БОЛОН ДЭЛХИЙ ДАХИНЫ ЗОРИЛГЫГ МЭДЭЖ АВЧ БАЙНА

Ричард Холден



Том Стрикленд

Иельхэмийн Коллежийн Квакер хандлагатай үйлчилгээ, үйл ажиллагаа нь Афганистан оюутан Жавад Жойя, Кени оюутан Иветт Иссар нарын сэтгэлийг Индиана муж улсын Ричмондын коллежид татсан юм

Индиана муж улсын Ричмонд дахь Иельхэмийн коллеж бол Квакерийн (Найз нөхдийн шашны нийгэмлэг) нөхцөлд дээд зэргийн чанартай боловсрол олгох зорилготой хүмүүнлэгийн ухааны бие даасан коллеж юм. Үнэнийг зааж сургах, үнэнийг хүндэтгэх гол чиг баримжаатай энэхүү коллеж оюутнуудыг суралцаж байхдаа ч, төгсөж гарсан хойноо ч идэвхтэй, асууж лавладаг сурагчид байх, тэдний оюуны эрэлхийллийг амьдралыг гол болгосон даяаршсан боловсрол, мөргөлдөөнийг энхийн замаар шийдвэрлэх явдал, хүмүүсийн тэгш байдал болон хувийн зан үйлийн дээд стандарттай хослуулах явдлыг дэмждэг. Ричард Холден Иельхэмийн Коллежийн олон нийтийн мэдээлэл хариуцсан захирал байгаад тэтгэвэрт гарчээ.

Иельхэмийн Коллежид сурч байгаа гадаадын аль ч оюутантай нөхөрсгөөр ярилцаж үзвэл мөрөөдөмтгий нэгэнтэй учирч гэдгээ итгэлтэй мэдэх болно. Хүмүүнлэгийн ухааны багахан сургууль дэлхий ертөнц дээрх эргэлт өөрчлөлтүүдийг шударга, энхийн замаар шийдвэрлэх аргыг олох эрмэлзэлтэй оюутнуудыг өөртөө татах хандлагатай байна. Тэдгээр оюутны ихэнх нь бэрхшээл зовлонтой ертөнцөд очихын өмнө сургуулиа дүүргэе гэж хүлээхгүй байна. Ийнхүү тэсч ядаж суугаа хоёр хүн бол Афганистанаас ирсэн Жавад Сепери Жойя, Кени улсын оюутан Иветт Иссар нар яах аргагүй мөн. Энэ хоёр оюутан хоёулаа дэлхий даяар буй болсон нийгэм, улс төрийн үймээн самууныг зохицуулахад сурч мэдсэн зүйлээ ашиглах олон арга замыг хэдүйнээ олж мэджээ.

Гадаадын оюутнууд эх орондоо шударга бус байдалтай тулгарч явсан хувийн туршлагатай байдаг нь тийм явдлын эсрэг өөрийгөө зориулахад хөтлөх нь элбэг байдаг. Жавад бол бараг боломжгүй мэт санагдах нөхцөл байдлыг найдлага, зүтгэлээр даван туулж чадахын амьд жишээ юм. 1990-ээд оны сүүлээр Кабулын эмх замбараагүй байдал дунд амьдардаг, саа өвчний улмаас тахир дутуу хүний тэргэнцэрт хадагдсан, бичиг үсэг тайлагдаагүй ядуу шийтийн лалын шашинтны хүү болох энэ хүний ирээдүй тун бүрхэг байсан юм. Эрх баригч Талибанчууд ялангуяа охид бүсгүйчүүд болон тахир татуу хүмүүсийн боловсрол эзэмших боломжийг ерөнхийдөө хаасан байлаа. Улаан Загалмайн байгууллагад ажиллаж байсан нэгэн итали эмч түүний сурах чадвартайг олж харан, нууцаар хэд хэдэн гэрийн багш олж өгчээ. Жавад хэл амархан сурч, мөн компьютер дээр ажиллах чадвартай болсон байна. Тэр үед 13 настай байсан Жавад Улаан Загалмайн байгууллагад программчаар ажиллаж, өөрийнхөө төлөө амьдрахын учрыг ухаарч эхэлжээ. Тэрээр эмчтэйгээ нөхөрлөж, Талибаны дэглэм унасны дараагаар 2002 онд Италийн нэгэн сэтгүүлчтэй танилцсанаар дайнд сүйдсэн Афганистанаас явж, Италийн Триест хотноо сургуульд оржээ. Тэрбээр тэнд олон улсын бакалаврын диплом удахгүй авах гэж байх үедээ АНУ, Канадын коллежуудад элсэх өргөдлөө өгсөн байна. Сургалтын хувьд хүчтэй сайн сургуулиудын нэг байсан Иельхэмийн Коллеж түүнийг хүлээн авч, оюутны бүрэн тэтгэлэг олгосон ажээ.

“Энд байгаагаараа би бахархахаас өөр аргагүй. Энд би томоохон их сургуульд байгаагаас ч хавьгүй их зүйл хийх боломжтой гэж бодож байна” хэмээн Жавад ямагт нүүр дүүрэн инээмсэглэж явдаг зангаараа инээмсэглэн өгүүлж байна. Одоо Иельхэмийн Коллежийн хоёрдугаар ангид суралцаж байгаа Жавад шинжлэх ухааны хичээлүүд голлон үзэж, хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр курсын ажил давхар бичиж байна. “Олж авсан мэдлэг, туршлагадаа үндэслэн би байгалийн жам ёсны үүднээс энхийн асуудлыг судлахыг улам сонирхох болсон. Биологид төрөл зүйлүүдийн хоорондын өрсөлдөөний асуудал байдаг. Нэгэнт хүн гэдэг эдгээр төрөл зүйлийн нэг учраас асуудлыг би янз бүрийн өнцгөөс харж, бид хүн байдлаар өрсөлдөж чадах арга замыг хайж байна” хэмээн тэрээр тайлбарлаж байна. Тэрээр энэхүү сонирхсон сэдвээ дипломын дараахь сургалтанд хамрагдан үргэлжлүүлэн үзэхээр төлөвлөж байна. Тэгснээр аль нэг их сургууль, сан буюу эрдэм шинжилгээний байгууллагад заавал ч үгүй томилогдоно гэж Жавад найдаж байна.

Хичээлээс гадуурх болон оюутны хотхоны хамт олны нийгмийн амьдралд бүр ч идэвхтэй оролцдог Жавад Үлгэр жишээ НҮБ, Энх тайван ба Глобал судалгааны Клуб, Эмнести Интернейшнл болон Азийн Оюутны Холбооны ажилд оролцдог. Оюутны тэтгэлгээ нэмэгдүүлэх үүднээс тэрээр Иельхэмийн Энх тайван ба Глобал судалгааны (ЭТГС) Хөтөлбөртэй хамтран ЭТГС-ны сургалтын хөтөлбөрийг хэрхэн үр нөлөөтэй болгох талаар судалгаа явуулдаг төлбөртэй дагалдан сургалт ажиллуулж байна.

Өнгөрсөн зун тэрээр АНУ-ын коллежуудын 40 төлөөлөгчийн нэг болж Калифорни муж улсын Стэнфорд дахь Стэнфордын Их сургуульд зохиогдсон Япон-Америкийн Бага хуралд оролцож, дараа нь мөн муж улсын Фремонтод байрладаг Хойт Америкт суугаа Афганистан мэргэжилтнүүдийн Нийгэмлэгт ажиллахаар очжээ. Энэ жил Жавадын хөдөлмөрийг үнэлж, “оюутны хотхонд, орон нутагт болон дэлхий дахинаа энхийг тогтоох, шударга үнэнийг олоход хувь нэмэр оруулсны төлөө” Энх тайван, шударга ёсны Үндэсний Ассоциацийн оюутны дээд шагналыг олгосон байна. Үүнийг дагалдаад Индиана муж улсын Гошен дахь Гошен Коллежид болсон Плоушарын Оюутны Энхтайвны Бага хурлаас мөн шагнал хүртээсэн байна.

Өнөөдөр өөртөө Афганистан, Итали, Америкийн боловсрол агуулсан 20 настай Жавад өөрийгөө “дэлхийн иргэн” хэмээн нэрлээд, дээр нь бас “Өнөөдөр юунаас өмнө надад дэлхийд зорчих виз хэрэгтэй байна” гэж хэлж байна.

Иветт Иссар Иельхэмийн олон улс судлалын хөтөлбөрийн гуравдугаар дамжаанд сурч байна. Тэр бүсгүй коллежийн Квакерийн өв уламжлалд татагдаж, “үл хүчирхийлэл, энгийн байдал, нийгмийн шударга ёсны” язгуур чанарыг хүндэтгэдэг тухайгаа дурдсан юм. Иветт, Кенийн нийслэл Найробид энэтхэг айлд төрж өсчээ. “Хэдийгээр би энэтхэг хүнтэй илүү адилхан байж болох авч хоёр газраас зэрэг төрсөн юм шиг өөрт минь санагддаг. Анх ирэхдээ (Иельхэмд) би Америкийн баруун зүгийн энэхүү жижигхэн хотод амьдрах онцгүй биз гэж дурамжхан бодож байж билээ. Гэтэл гайхалтай сайхан газар байсан. Энд сурч байгаа хамт олон ер бусын гайхамшигтай, үнэнч сайхан сэтгэлтэй ард түмэн хүрээлж авсан шүү” хэмээн тэрээр ярьж байна.

Иельхэмд, Иветт дэлхийн өнцөг булан бүрийн коллежийн оюутнуудтай нүүр тулсан видео бага хурал хийж, дэлхийн хэмжээний бэрхшээлт асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэх зөвшилцлийн замыг эрэлхийлдэг Мэдээлэлт ардчиллын төлөө Америкчуудын нийгэмлэг (МАА)-ийн салбарыг зохион байгуулсан байна. Өнөөдөр Америкийн Нэгдсэн Улс болон хилийн чанадад оюутнуудын удирддаг 70 МАА-ийн салбар ажиллаж байна. “Намайг МАА-д ирэхэд бүгд л санаанаасаа буцаж эхэлцгээж байсан бөгөөд жирийн америкчуудад бусад улс орныг хэрхэн илүү сайн танилцуулах вэ, үүний зэрэгцээ бусад орны ард түмэнд жирийн америкчуудыг ойртуулах боломжийг яаж хангах вэ гэдэг талаар хачирхалтай санаа агуулсан хүмүүс тааралдаж байсан юм”

Энэ жилд л гэхэл Иветт, АНУ-д суралцаж байгаа оюутнууд болон Пакистан, Австрали, Филиппин, Гондурас, Шри Ланка болон бусад олон орны оюутнуудыг оролцуулсан дөрвөн бага хурал зохион байгуулжээ. Оюутнуудын авч хэлэлцсэн асуудлууд дотор “Байгалийн гамшигтай дэлхий нийтээрээ мэдрэмжтэй хандах нь”, “Америкийн Нэгдсэн Улс далайн чанадад ардчиллыг хөгжүүлэх гэж зүтгэх ёстой юу?” гэсэн сэдвүүд байлаа.

Жавадын нэгэн адил Иветт Үлгэр жишээ НҮБ-д гүнзгий татагдан орсон юм. Өнгөрсөн жил Иветт Чикагод болсон Үлгэр жишээ НҮБ-ын бүсийн чуулганд Ливаныг төлөөлөн оролцсон. “Өөр орны сонирхлыг төлөөлнө гэдэг хүний гутал өмссөнтэй адил. Гэхдээ үүний цаана хүчин чармайлтаа нэгтгэхэд бусад оронтой хэрхэн хамтарч ажиллах, дэлхий нийтийн сайн сайхны төлөө буулт хийж сурах асуудал байгаа юм” хэмээн тэрээр ярьж байна.

Түүнчлэн Иельхэмийн Найрал дууны бүлгийн дуулаачийн хувьд Иветт хөгжмийн шохоорхлоороо таашаал авах цаг зав гаргадаг юм. Өнгөрсөн хавар тэрээр Коллежийн Венагийн Найрал дууны Семестрт оролцсон аж. “Энэ надад гайхалтай дурсамж үлдээсэн. Европын зүрхнээ очиж, тэндэхийн алдартай сүмүүдэд дуулах боломж тэгэхэд надад олдсон юм. Үүнийгээ би хэзээ ч мартаггүй” хэмээн Иветт ярьж байна.

Америкийн Нэгдсэн Улсын Коллежид суралцахдаа олж мэдсэн хамгийн чухал зүйл тань юу вэ хэмээн асуухад Иветт бодлогоширон тааз ширтсэнээ “Хүнд байж болох хамгийн чухал зүйл нь хамт олон юм. Бусадтай холбоогүйгээр, тэднийг хайрлаж, тэднээр хайрлуулахгүйгээр та зовлонт нөхцөл байдлын дунд байгаа яг л эзэнгүй арал мэт. Хүмүүс бие биенээ хайрлаж, халамжлах ёстой, хөршүүдээ асран тэтгэх ёстойг би мэдэж авсан. Үүнийг би ямагт мэддэг байсан ч АНУ-д үүнийг жинхэнэ утгаар нь сурч авсан” хэмээн хариулж билээ.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлтнэ АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

ОРОН НУТАГТ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Робин Л.Йежер



Гэрэл зургийг авсан Рогелио Солис, AP/WWP

Өмнөд Миссиссипийн их сургууль болон Иллиноисийн их сургуулийн оюутнууд Миссиссипийн Жэксонд нутгийн иргэдэд зориулан баригдаж байгаа байшингийн барилга засварын ажлыг дуусгахаар дээвэр дээр авирч гарч буй нь

Робин Йежер нь АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн товчооны орон тооны зохиогч бөгөөд тэрээр Америкийн коллеж, их сургуулиудаас оюутнуудыг орон нутгийнхаа төлөө хүчин зүтгэхэд хэрхэн дэмжин сайшааж буй талаар өгүүлж байна..

Америкийн Нэгдсэн Улс нь сайн дураараа олон нийтэд туслах үйл ажиллагаа явуулах (волонтаризм) тогтсон уламжлалтай орон билээ. Залуу хүмүүсийг бага наснаас нь тухайн орон нутгийн олон нийтэд туслах үйл ажиллагаанд оролцох арга замын зааж өгч аль болох туслалцаа дэмжлэг үзүүлдэг байна. АНУ даяар коллеж болон их сургуулиуд оюутнуудад сайн дураараа бусдад туслах үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээнд оролцоход нь өргөн боломж олгодог юм. Зарим тохиолдолд, оюутнууд энэхүү ажил хийснийхээ төлөө хичээлийн жилийн хугацаанд кредит авдаг хэдий ч тэдгээрийн гол шагнал нь зүгээр л бусдад тусалснаар үүргээ биелүүлж буйд оршиж буй бөгөөд ингэснээр хэдийгээр тэд залуу боловч аливаа өөрчлөлт дэвшлийг авчирч чадна гэдгийг ойлгох явдал юм. Оюутны хотхоны нэгтгэлээс энэхүү үзэл баримтлалын тухай <http://www.compact.org> вэб хуудсанд тодорхой тайлбарласан байдаг бөгөөд тухайлбал, энэ эвсэл нь “5 сая орчим оюутнуудыг төлөөлсөн 950 гаруй коллеж болон их сургуулиудын

ерөнхийлөгчдийг нэгтгэсэн үндэсний эвсэл бөгөөд түүний үйл ажиллагаа нь орон нутгийн хэмжээнд явуулах үйлчилгээг хөхүүлэн дэмжих, иргэний үүргээ биелүүлэх, дээд броловсролд сургалт-үйлчилгээг хослуулахад чиглэгдэж буй” гэж дурьдагдсан байдаг.

1992 онд байгуулагдсанаас хойш, Миссиссипи муж улсын Хэтисбург дахь Өмнөд Миссиссипийн их сургуулийн Орон нутагт үйлчилгээ явуулах сургалтын алба (ОНҮЯСА) нь их сургуулийн хамт олны бүх гишүүдийн олон нийтийн үйлчилгээ болон энэхүү үйлчилгээнд сургах сайн дурынхны үйлчилгээ явуулах гол төв бөгөөд үйлчилгээ үзүүлэх төвлөрсөн газар болдог байна. Жилд 20 000 гаруй цагийг орон нутагт болон оюутны хотхонд олон нийтийн ажил явуулахад зарцуулдаг аж. Их сургуулийн боловсролын давуу тал, олон нийтэд хандсан үйлчилгээ болон оюутнуудын амжилт нь хөтөлбөрийн цөм болж буй бөгөөд энэ нь орон нутаг, улс үндэстэн болон дэлхийн олон нийтийг хамарсан үйлчилгээнд оролцох, улмаар түүний нэгэн бүрэлдэхүүн хэсэг болгоход оролцогчдыг хөхиүлэн дэмждэг болно. Өмнөд Миссиссипийн их сургууль бол сургалтыг өндөр хэмжээнд явуулж буй 6 институтийн нэг бөгөөд одоогоор тэрээр хичээлийн жилийн хугацаанд үйлчилгээнд сургах загварыг нэвтрүүлэх талаар Зүүн Мичиганийн их сургуультай хамтран ажиллаж байна. Их сургууль нь Орон



Гэрэл зургийг авсан Тэд С. Уорэн, AP/WWP

Вашингтоны Сизетлийн их сургуулийн оюутны хотхоноос эрхлэн тус сургуулийн оюутнууд майхан хотхонд амьдарч буй орон гэргүй сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг Америкийн дохио зангааны хэлэнд зааж сургаж байгаа нь

нутгийн болон иргэний оролцооны Миссиссипийн төвийн түшиц байгууллага болж буй билээ. (<http://www.usm.edu/ocs/>).

Урбана – Кампэйн дахь Иллиноисийн их сургууль нь үйлчилгээнд сургах арга замыг дараах байдлаар тайлбарлаж байна. Үүнд:

Либерал боловсролын үндсэн зорилго нь оюутнуудыг иргэн хүн болоход нь бэлтгэхэд оршино. Чингэхдээ, оюутны үүрэг оролцоог хичээлийн танхимд олсон дадлага туршлагатай нь нягт уялдуулан холбодог юм.

Либерал боловсрол нь оюутнуудын оюуны болон нийгмийн төлөв байдлыг төлөвшүүлж буй бөгөөд энэ нь нэг талаас сонирхолтой болон хариуцлагатай аж. Сонирхолтой байдгийн учир нь, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, дэлхий ертөнцийг олон хувилбараар төсөөлөх, хэвшмэл бодол сэтгэлгээг эвдэх хүсэл эрмэлзлийг бий болгодогт оршдог. Нөгөөтэйгүүр, дэлхийн олон нийттэй бүх талаар холбогдож байгаагаараа хариуцлагатай аж.

Ийм учраас, нийгмийн өмнө хариуцлага хүлээлгэх замаар оюутнуудыг нийгэмтэй холбоотой болгох нь чухал ач холбогдолтой юм. Жишээ нь, хоёр семестрийн хугацаанд оюутнууд барилга

архитектурын зургийн урландаа дэлхийн хүн төрөлхтөнд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй байр орон сууцыг зохион бүтээх том зорилго тавин ажилласан байна. Энэ онцлог орон сууцыг бий болгох хөдөлгөх хүч нь иргэний харуцлагаас үүдэлтэй үнэт зүйлс болон сонголтын иж бүрэн цогц бөгөөд бага орлоготой айл өрхөд тохиромжтой байр орон сууцыг бий болгох, улмаар эрчим хүчний хэмнэлтийг хангахад чиглэгдсэн дэвшилтэд технологийг үр дүнтэй ашиглахад чиглэгдсэн байна. (<http://www.union.uiuc.edu/sle/>).

Нью Инглэндийн бүс нутагт, Дартмаусийн коллеж, Вермонтын их сургууль, Гэгээн Михаилын коллеж, Норвичийн их сургууль, Чамплэйны коллеж болон Кастлтон муж улсын коллеж нь орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус олон арван байгууллагуудтай хамтран МӨРӨӨДЛИЙН (амралт чөлөөт цаг, боловсрол, адал явдал, манлайллаар удирдан чиглүүлэх) хөтөлбөр боловсруулж, бага орлоготой хөрш зэргэлдээ айл өрхийн хүүхдүүдтэй ажиллах удаан хугацааны



Уофордын коллежээс ирүүлсэн зураг

Вофорд коллежийн оюутан Өмнөд Каролинад хүүхдүүдэд дасгал хийхэд нь туслаж байгаа нь

халамжлан хүмүүжүүлэгчдийг томилон ажиллуулдаг билээ. Энэхүү хөтөлбөр нь 1999 онд Дартмаус хотод хэрэгжиж эхлэн, одоогийн байдлаар муж улс даяар үйлчилгээний салбартай болсон бөгөөд эдгээр нь олон хот суурин газарт хүүхдүүдий дунд халамж, үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг билээ. Хөтөлбөр нь залуучуудын хөгжил болон орон нутгийн хөгжлийн зарчмуудыг хослуулдаг бөгөөд долоо хоног тутам удаан хугацааны гэрээт хүмүүжүүлэгчидтэй уулзалт хийх, аялал, спортын арга хэмжээ, зуны зуслан зохион байгуулах зэрэг хэлбэрээр залуучуулын амралт чөлөөт цагийг идэвхтэй өнгөрүүлж, спортын аварга, орон нутгийн алдар цуутай хүмүүстэй уулзалт, холбоо тогтоох арга хэмжээ зохион явуулдаг байна. Хамтран ажиллагч түншлэгчид нь өөрийн байртай байгууллагууд байдаг бөгөөд тухайлбал, Скаут охид, Бэн, Жэрригийн мөхөөлдөсний компани зэргийг дурдаж болох юм. (<http://www.dreamprogram.org/>).

Вашингтон муж улсын Сиэтл хотын Сиэтлийн их сургуулиас 2005 оны 11 дүгээр сард орон гэргүй хүмүүсийн асуудлаар үндэсний бага хурал эрхлэн зохион байгуулсан. Тус их сургуулийг ээлжит V бага хурлыг зохион байгуулахаар урьсан учир нь гэвэл, тэрээр 2005 оны 2 дугаар сард санаачлан 100 орон гэргүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг байрлуулах боломжтой хөдөлгөөнт Майхан хот 3 - ыг сарын хугацаанд зохион байгуулсан юм. Сиэтлийн их сургууль нь орон гэргүй хүмүүсийг ийнхүү хүлээн авсан анхны их сургууль юм. Үндэсний бага хурлыг Сиэтлийн их сургуулийн оюутнууд болон Вашингтон дахь оюутны хотхоны нэгтгэлийн гишүүд бие даан

зохион байгуулсан юм. Энэхүү оюутны хотхоны нэгтгэл нь дээд боловсролд иргэний хариуцлагыг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн нийт муж улсыг хамарсан коллеж, их сургуулиудын ерөнхийлөгчдийн эвсэл юм. Бага хурлын талаар нэмэлт мэдээллийг дараах Вэб хуудаснаас авч болно. (<http://www.studentsagainsthunger.org>).

Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн хөтөлбөр Өмнөд Каролинагийн Гринвил дахь Фурманы их сургууль дээр хэрэгжиж буй билээ. Тэдний Вэб хуудсанд ирээдүйн оюутнуудад зориулан дараах мэдээллийг байрлуулжээ. Үүнд:

“Манай ихэнх хичээлийн ангид үйлчилгээнд суралцах эрхийг хичээлийн хөтөлбөрт тусгасан байгаа. Үүнд шашин, боловсрол, нийгэм судлал болон улс төрийн шинжлэх ухаан зэрэг сургалт хамрагддаг. Амьдралын бэрхшээлтэй залуучуудад уншиж сургах, орон нутгийн ашгийн бус байгууллагуудтай хамтран арга хэмжээ зохион явуулах, хувиараа хөдөлмөр эрхлэгчидтэй хамтран бизнесийн төлөвлөгөө боловсруулах зэрэг олон чиглэлээр та орон нутгийн олон нийтийн дунд ажиллах өөрийн сонголтоо хийж болно” гэж дурьдагдсан байдаг.

Үйлчилгээнд суралцах нь зөвхөн хичээл ангиар хязгаарлагдахгүй. Жил бүр Фурманы их сургуулийн 800 сайн дурын оюутнууд оюутны зуучлах Макс ба Трайд Хэллэр коллежийн боловсролын үйлчилгээний корпорацийн шугамаар Гринвиллийн 45 агентлагт тусалцаа үзүүлдэг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ Авран туслах арми, Тусгай хүүхдүүдэд зориулсан Мейерийн төв болон Латин Америк гаралтай хүмүүсийн хэрэг эрхлэх газар, Скаут охидын байгууллагыг хүртэл хамардаг байна (<http://www.furman.edu/main/community.htm>).

Өмнөд Каролинагийн Спартанбург дахь зэргэлдээ Уофордын коллеж нь үйлчилгээний сургалтын хөтөлбөрийг мөн хэрэгжүүлдэг. Чөлөөт сэтгэлгээнд тулгуурласан жижиг коллежийн оюутнууд төслийн шугамаар сайн дурын үйл ажиллагаанд шууд оролцох эсвэл орон нутгийн агентлаг, байгууллагын шугамаар оролцох эсэхээ өөрсдөө сонгодог байна. Зарим оюутнууд бие даан сайн дурынхны хэлбэрээр үйл ажиллагаанд нь оролцдог байна; нөгөө хэсэг нь клуб болон ахан дүүсийн байгууллага зэрэг оюутны хотхоны гишүүдтэй хамтран оролцдог аж. Уофордын коллежийн оюутнууд хоолны газар (өлсөж буй хүмүүст хоол бэлтгэж үйлчлэх) болон гэр оронгүй хүмүүсийн оромжинд очиж цэвэрлэгээ, үйлчилгээний ажил хийдэг байна. Тэд орон нутгийн дунд сургуулиудын ангиудыг дааж авдаг бөгөөд орон нутагт үнэ төлбөргүй үйлчилгээ явуулдаг эмнэлэгт ажилладаг байна. Тэд Зул сарын бэлгийг амьдралын гачигдалтай хүүхдүүдэд гардуулан өгдөг бөгөөд оюутны хотхон, хот суурин газруудын тохижилт үйлчилгээг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг байна (<http://www.wofforf.edu/serviceLearnibg/default.asp>).

Бүх төрлийн коллежууд үйлчилгээний сургалтын хөтөлбөртэй аж. Орон нутгийн коллежуудын Америкийн холбооны (ОНКАХ) судалгаанас үзэхэд АНУ-ын орон нутгийн коллежуудын тэн хагас нь өөрсдийн хичээлийн хөтөлбөрт үйлчилгээний сургалтын хичээлийг ямар нэгэн байдлаар тусгасан байдаг. ОНКАХ- оос энэ асуудлаар нилээд хэдэн ном товхимол хэвлүүлэн гаргасан бөгөөд сонирхолтой хоёр нь 8 хуудас бүхий Үйлчилгээний сургалтыг тогтвортой явуулах нь: Их дээд, сургуулиудын ахлах багш нарын үүрэг роль болон 86 хуудас бүхий Хичээлийн хөтөлбөрт иргэний хариуцлагын тухай тусгах талаар гарын авлага. Энэ хоёр ном, товхимлыг дараах Вэб хуудаснаас олж харж болно:

http://www.aacc.nche.edu/Content/NavigationMenu/ResourceCenter/Projects_Partnerships/Current/Horizons_ServiceLearningProject/Publications/Publications.htm.

Нью - Мексико дахь Албакеркийн Техник

– мэргэжлийн хүрээлэн нь (АТМХ) орон нутгийн коллежийн хэмжээнд үйлчилгээний сургалтыг хэрхэн явуулах талаар гайхамшигтай жишээг танилцуулсан болно. Тэрээр Үндэсний болон Орон нутгийн үйлчилгээний Корпорацийн буцалтгүй тусламж авсан бөгөөд мөн түүнчлэн Үндэсний “Bellwether” 1999 оны шагнал, Орон нутгийн коллежийн Үйлчилгээний сургалт явуулахад орон нутгийн хүлээх үүрэг хариуцлага болон иргэний үүрэг хариуцлагын Үндэсний төвийн 2004 оны шагналыг тус тус хүртсэн байна. 50 гаруй орон нутгийн агентлагуудад АТМХ-ийн оюутнууд залуучуудын хөтөлбөр, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгэм болон хууль, эрх зүйн үйлчилгээ, ой хамгаалах үйлчилгээ, тусгай олимпийн тоглолт, конгресийн 2 салбар байгууллага, хүмүүнлэгийн болон нийгмийн байгууллагын шугамаар ажиллах сонголтоо хийх боломжтой (<http://planet.tvi.cc.us/experientiallearning>).

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

ТҮРГЭН АВСАН 7 ГЭРЭЛ ЗУРАГ

Боловсрол эзэмших боломжуудыг загварлан сонгон авсан нь

АНУ-ын элчин сайдын яамдууд болон Консулын газрууд өөрийн олон төрлийн үйл ажиллагаанд тус дөхөм болгох зорилгоор тухайлбал, боловсрол, соёлын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зэрэг ажилд тухайн орны үндэсний боловсон хүчнийг авч ажиллуулж байгаа бөгөөд энэ нь бие биенээ харилцан ойлгоход чухал ач холбогдолтой юм. 2005 оны 4 дүгээр сард Төрийн Департамент нь эдгээрээс 18 албан хаагчдыг дадлага хийлгэх зорилгоор АНУ-д урьж ирүүлсэн бөгөөд энэ хугацаанд тэд Хойд Каролина дахь Шарлот хотын болон тус хотын зэргэлдээх хэд хэдэн коллежид зочилж, оюутны хотхонд амьдарч байгаа гадаадын оюутнуудын ажил, туршлагатай танилцав. Энэхүү өгүүлэл нь дээрх төлөөлөгчдийн нэгдсэн ажлын тайланг хураангуйлэн танилцуулж буй бөгөөд АНУ-д боловсрол эзэмших маш олон төрлийн боломж байгаа талаар санааг толилуулж буй болно.

Шарлотыг сонгон авсны учир нь гэвэл, тэрээр Зүүн - Өмнөд нутгийн банк санхүү, олон нийтийн хэвлэл мэдээлэл, бизнес, соёлын болон тээврийн төв болж байгаагийн зэрэгцээ олон төрлийн сургалтыг хамарсан боловсролын байгууллагуудын өлгий нутаг юм. Эдгээр 18 оролцогчид хэд хэдэн багт хуваагдаж тус тусдаа өөр өөр оюутны хотхонд зочилж оюутнуудтай уулзаж, хичээлийн явцтай нь танилцаж, тухайн сургуулийн оюутнуудтай тэдгээрийн санхүүгийн нөөц чадвар, хэтийн зорилгын талаар ярилцаж, гадаадын оюутнуудын ажил, амьдралын туршлагатай шууд танилцах боломжтой байв. Эдгээр бүх сургуулиуд гадаадын оюутнуудыг татах ихэд сонирхолтой байдаг бөгөөд өөрийн Вэб хуудсаа байнга шинэчилж, түүнийг авч ашиглахад хялбар болгох, улмаар мэдээллийг бусдад нээлттэй байлгахыг зорьж байдаг. Дэвидсоны коллежийн Вэб хуудасны нэгэн хэсэгт коллежууд гадаадын оюутнуудыг өөрийн сургуульдаа урьж суралцуулах нийтлэг сонирхолтой байдаг талаар илэрхийлсэн болно:

Дэлхий нийтийг хамарсан тулгамдсан асуудлын талаар олон улсын хамтын нийгэмлэгийн анхаарал, оролцоо нь Дэвидсоны боловсролын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Дэлхийн олон үндэстний орчинд аж амьдран сурч боловсорч байгаа оюутны хувьд, танд манай коллежийн хамт олны гишүүдтэй өөрийн санал бодлоо хуваалцах талаар олон зүйл байгаа гэдэгт бид итгэж байгаа. Элсэлтийн явцад таны талаар болон таны туршлагын талаар бид олон зүйл олж мэднэ гэдэгт найдаж байна.

Долоон сургууль



Бэльмонтын шашны коллежээс ирүүлсэн зураг

Бэльмонт хийдийн коллеж бол 1000 оюутантай бөгөөд чөлөөтэй сэтгэн бодох чадвар дээр тулгуурлан жижиг коллеж бөгөөд “гэр бүлсэг” орчин бүрдүүлсэн, хүний бие, сэтгэл, ухааныг хөгжүүлэхийг эрхэмлэдгээрээ олонтай тэмдэглэгдсэн байдаг билээ. Тус коллеж нь Хойд Каролина муж улсын Шарлотын зэргэлдээ Бэльмонтод байрладаг бөгөөд Бэльмонтын хийдийн Бэнэдикитийн сумд хамаардаг аж (<http://www.belmontabbeycollege.edu/>).

Пьедмонттын орон нутгийн төв коллеж (ПОНТК) бол Өмнөд Каролинагийн орон нутгийн томоохон коллеж бөгөөд тус коллежийн 70000 оюутнууд хэд хэдэн оюутны хотхонд 100 гаруй хөтөлбөрт оролцдог байна. Ерөнхийлөгч Жорж Буш 2005 оны 4 дүгээр сарын 5-нд хөдөлмөр эрхлэлтийг хөгжүүлэх тухай санаачлалгыг зарлан тунхаглах газраа Пьедмонттын орон нутгийн төв коллежийг болгон сонгосон юм. Тус коллеж нь 100 гаруй орны гадаадын оюутнуудыг сургаж буйгаараа бахархдаг билээ (<http://www.cpsc.edu>).



Пьедмонттын орон нутгийн төв коллежээс ирүүлсэн зураг

ПОНТК-ийн компьютерийн ангид багш оюутанд туслаж буй нь



Дэвидсоны Коллежээс ирүүлсэн зураг

Дэвидсоны коллежийн оюутнууд үдийн хоолны сарын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тодорхой нэг орны хоол хийж, хөгжим сонсож, гоёл чимэглэлийн зүйл хийж сурч буй аж. Энэ зураг дээр сайн дурын оюутнууд талх барихад туслаж буй.

Дэвидсоны коллеж бол Өмнөд Каролинагийн Дэвидсон дахь Шарлотаас хойд зүгт 30 минутын хугацаанд явах газар байрладаг: 8000 хүн амтай. Коллеж нь чөлөөтэй сэтгэн бодох чадвар дээр тулгуурлан сургалтаа явуулдаг бөгөөд тус коллежид 1600 оюутан суралцдаг. Анх 1837 онд Пресбитарчуудаар үүсгэн байгуулагдсанаас хойш 23 Rhodes эрдэмтдийг төрүүлсэн юм. Дин Раскийн Олон улсын судлалын хөтөлбөр нь 20 жилийн өмнө бий болж, түүний нэрээр Дэвидсоны оюутны байрыг нэрлэсэн бөгөөд тэрээр төрийн нарийн бичгийн даргын алба хашиж байжээ. Энэхүү хөтөлбөр нь оюутнуудад маш гайхамшигтай бололцоо олгож буй хөтөлбөрүүдийн нэг. Тэрээр анх зөвхөн эрэгтэй сурагчдын сургууль байсан бол өнөөдөр тус сургуульд суралцаж байгаа эрэгтэй эмэгтэй оюутнуудын тоо ойролцоогоор тэнцвэртэй байна. (<http://www.davidson.edu/>)

Жонсон ба Уэлсийн их сургууль нь өөрсдийгээ “Америкийн албан тушаалд дэвших их сургууль” гэж нэрлэдэг. Тус их сургууль нь 4 муж улсад өөрийн оюутны хотхонтой; Шарлотын оюутны хотхон 2004 онд нээгдсэн. Их сургууль нь гол төлөв бизнес, үйлчилгээ (зочид буудал, зоогийн газар), нарийн нэр төрлийн хоол хийх чадвар эзэмших чиглэлээр тухайн сургуулийн шинжлэх ухааны гишүүний (хоёр жил), бакалаврын (дөрвөн жил) боловсрол тус тус олгодог. Тус их сургуулийн вэб хуудаснаас 17 улсын хэлээр мэдээлэл олж авч болно (<http://www.jwu.edu/charlotte/>)



Гэрэл зургийг авсан Викторио Арочо. AP/WWP

Жонсон ба Уэлсийн оюутнууд Үндэсний талх үйлдвэрлэгчдийн дээд хэмжээний уулзалтын үеэр баярын чимэглэсэн талх хийж үзүүлж байгаа нь



Жонсон С. Смитын Их сургуулиас ирүүлсэн зураг
Жонсон Смитийн их сургуулийн үйлчилгээнд сургах хөтөлбөрийн дагуу коллежийн оюутнууд халамж анхаарал шаардагдаж буй хүүхдүүдтэй хамтран ажилладаг бөгөөд энэ хөтөлбөрийг Бямба гарагийн Академи гэж нэрлэдэг аж. Энэ хөтөлбөрт хамрагдсанаар тоо болон унших хичээлийн түвшингээс хоцорсон хүүхдүүд улсын дундаж түвшинд хүрч өөрсдийн ангидаа бусдыгаа сурлагаар гүйцдэг байна.

Жонсон С. Смитын их сургууль нь түүхэнд Хар их сургууль гэж нэрлэгдэж ирсэн. Шарлотын төвөөс ердөө л нэг милийн газар байрладаг энэхүү оюутны томоохон хотхонд 1400 оюутнууд суралцан амьдарч байгаа бөгөөд оюутнуудын дунд нөхөрсөг уур амьсгал бий болгоход тус сургуулийн захиргаа, багш, ажилтнуудаас ямагт дэмжин сайшааж, оюутнуудад өөрсдийн зүгээс байнгын анхаарал халамж үзүүлдэг аж. Коллеж нь оюутнуудыг сургуулиа амжилттай дүүргэхийн тулд орон нутгийн олон нийтийн үйлчилгээний ажилд оролцохыг шаарддаг бөгөөд гадаадын 9 улс оронд суралцах, оюутны солилцоонд хамрагдах болон 90 гаруй компаний шугамаар боловсрол, ажлын туршлага эзэмших боломжийг оюутнуудад олгодог байна (<http://www.jcsu.edu/>).



Шарлот дахь Куины Их сургуулиас ирүүлсэн зураг
Куинсийн их сургуулийн оюутнууд төгсөлтийн ёслолын арга хэмжээнд бэлтгэж буй нь

Шарлотын Куинсийн их сургууль нь анх эмэгтэйчуудын семинар хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж эхэлж байжээ. Өнөөдөр, Прэсбитэрийн сумд харьяалагдаж байгаа бөгөөд мастерийн зэргийн түвшинд сургалт явуулж байгаа хувийн болон улсын сургуулийн дээд боловсролын өмнөх боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй оюутнуудын 30 орчим хувийг эрэгтэй оюутнууд эзлэж буй аж. Куинсийн их сургууль нь хотын оршин суугчдын тохилог бүсэд байрладаг бөгөөд чөлөөтэй сэтгэн бодох чадвар дээр тулгуурласан иж бүрэн хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ дээд боловсролын өмнөх хөтөлбөрийн хүрээнд 24 мэргэжлийн үндсэн сургалтад хамрагдах боломжийг оюутнуудад олгож буй билээ. Куинсийн их сургуульд 2200 оюутан суралцдаг бөгөөд эдгээрээс факультетээр суралцагсадын харьцаа 13:1 байна (<http://www.queens.edu/>).

Шарлот дахь Хойд Каролины их сургууль (ШХКИС) нь 19500 гаруй оюутантай бөгөөд бакалаврын, мастерын болон докторын зэрэг олгодог. Тус их сургуулийн байр нь Шарлот хотын төвөөс 10 милийн зайтай газар оршдог орчин үеийн оюутны хотхонд байрладаг бөгөөд бүс нутгийн бизнесийн болон судалгаа шинжилгээний томоохон төв болсон байна. ШХКИС-д суралцахаар АНУ-ын өнцөг булан бүрээс болон дэлхийн 80 орчим улс орноос оюутнууд ирдэг байна (<http://www.uncc.edu/>).



Гэрэл зургийг авсан Уэйд Брютон /UNC
Оюутнуудын өөрсдийн гараар бүтээсэн хүний баримал нь оюутны хотхоны шав газар болоод байгаа бөгөөд ШХКИС-ийн оюутнуудын зургаа татуулах дуртай газар аж.

Зөвлөмжүүд

Элсэлт ба элсэлтийн журам. Элсэлтийн журмын шаардлагууд янз бүр байдаг байна. Дэвидсон болон Куиний их сургуулиуд өөрсдийгээ өндөр шалгууртай гэж үздэг байна. Бэльтонтын сүмийн харьяа сургууль нь онолын болон оюуны хөгжилд түлхүү анхаардаг бол Жонсон Смитийн их сургууль элсэгчдийн хувийн зан төрх болон тэдгээрийн сурлагын дүнд ихээхэн анхаардаг байна. Пьедмонтын төв их сургууль нь бараг хүн тус бүрт зориулсан хөтөлбөртэй бөгөөд харин хүн бүр хөтөлбөр бүрт тохирно гэсэн үг биш юм. Шарлот дахь Хойд Каролины их сургууль болон Пьедмонтын орон нутгийн төв коллеж зэрэг эдгээр томоохон хоёр сургууль хангалттай нөөц хөрөнгөтэй боловч энэ байдал нь бусдыг сүрдэхэд хүргэдэг байна. Үнэн хэрэгтээ, элсэлтийн журам болон сургалтын хөтөлбөрүүд сургууль тус бүр дээр өөр өөр байдаг боловч шударга өрсөлдөөний дүнд сургуульд элссэний дараа оюутнууд үнэхээр сэтгэл хангалуун байдаг байна. Бүх сургуулиуд өөрийн Вэб хуудастай бөгөөд түүнээс элсэлтийн журам, санхүүгийн тусламж, мөн түүнчлэн гадаадын оюутнуудад зорулсан тусгай мэдээ, мэдээлэл зэргийг олж мэдэх боломжтой аж.

Байр, хоол, хөрөнгө нөөц, эрүүл мэнд, аюулгүй байдал. Пьедмонтын төв их сургууль нь өөрийн гэсэн оюутны хотхоны байргүй бөгөөд харин энд дурьдагдсан бусад их сургууль, коллежүүд өөрийн оюутны байртай тул оюутнуудад байрны захиалгыг хэрхэн өгөх талаар мэдээлэл өгөх боломжтой аж. Хоол, хүнсний хөтөлбөр нь оюутны хотхон бүрээс хамаарч өөр өөр байдаг боловч ч эхэнх нь ялангуяа, сургалтын эхний жилд олон төрлийн хоол, хүнсний сонголтыг оюутнуудад санал болгодог байна. Бүх сургуулиуд номын сантай бөгөөд компьютер ашиглах боломжтой бөгөөд оюутны хотхоны аюулгүй байдлын талаар бүгд мэдээлэл гаргадаг байна. Бүх

сургуулиуд оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамрагдах шаардлага тавьдагийн зэрэгцээ сургууль бүр тэдэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Оюутнуудад коллежийн нөхцөлд сурч, амьдарч дасахад нь туслах зорилгоор зөвлөлгөө өгдөг алба ч ажилладаг байна. Дээрх үйлчилгээний төлбөр, даатгал нь сургууль сургуулиас хамаарч өөр өөр байдаг байна. Сургууль бүрийн үндсэн сургалтын хугацаа өөр байдаг бөгөөд жил бүр өөрчлөгдөж байдаг. Иймд ирээдүйд дээрх сургуульд суралцахыг хүссэн оюутнууд Вэб хуудас болон бусад боломжтой мэдээллийн эх сурвалжаас сургалтын хугацаа, реферат бичих эцсийн хугацаа болон амралтын өдрүүд зэргийн талаар олж мэдэж болно.

Сургуулийн зүгээс үзүүлэх дэмжлэг туслалцаа. Зарим сургуулиуд англи хэл заах болон англи хэлээр бичих дадлага олгох хөтөлбөрийн хүрээнд оюутнуудад тусламж дэмжлэг үзүүлдэг байна. Ихэнх номын сангууд оюутнуудад эх сурвалжийг хэрхэн ашиглах болон эрдэм, шинжилгээний ажлыг хэрхэн явуулах талаар зааж сургадаг байна. Бүх сургуулиуд ажил эрхлэлтийн яармаг үзэсгэлэн зохион байгуулах болон сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах зэрэг бусад үйлчилгээг явуулахад туслалцаа үзүүлдэг байна.

Гадаадын оюутнуудад үзүүлэх үйлчилгээний алба ба байгууллагууд. Коллежууд тэмдэглэлт үйл явдал, бусад арга арга хэмжээ зохион явуулах алба болон холбоо, клубуудтэй бөгөөд эдгээр нь гадаадын болон америкийн оюутнуудыг нэг дор хамтран цуглуулдаг байна. Зарим байгууллагууд оюутнуудын яс үндэс болон газар зүйн гарал үүслээс хамаарч төрөлжөн байгуулагддаг байна. Гадаадын оюутнуудад

үйлчилгээ үзүүлэх зарим байгууллагууд, ялангуяа амралтын үеэр гадаадын оюутнуудыг тухайн орон нутгийн оюутнууд болон айл өрхтэй холбон танилцуулдаг аж. Зарим тохиолдолд, нэг хотын хэд хэдэн сургуулийн оюутнууд нийлж Шарлотын олон улсын хаус зэрэг ашгийн бус байгууллагуудын тусламжтайгаар тухайн хотод ажиллаж сурч буй бусадтай уулзах боломжтой болдог байна.

Шашин шүтлэг. Төрийн Департаментын урилгаар ирсэн эдгээр зочид төлөөлөгчид шашин шүтлэгийн талаар асуухад улсын, хувийн болон шашны чиглэлийн оюутны аль ч хотхонд ямар ч шашин шүтлэгтэй оюутнуудыг талархан хүлээн авч хүндэтгэлтэй ханддаг гэж тэдэнтэй уулзсан бүх оюутнууд болон гадаадын оюутнуудын зөвлөхүүд нотлон хэлжээ.

Дүгнэлт

Энэхүү танилцах аялал хэдийгээр богино хугацаанд зохион явагдсан болов ч АНУ-д ирээхээс өмнө уншиж, сонсож байсан зүйлийн талаар илүү их ойлголттой болж улмаар амьдралд хэрэгжүүлэхэд тус дөхөм боллоо гэж аяллын багийн гишүүд үзэж байна. АНУ-д суралцах олон төрлийн хийгээд маш олон арга зам байдаг гэдгийг харуулсан нь энэхүү аяллын хамгийн чухал үр дүн байсан юм.

Аялалд оролцогчид (гэрэл зураг үзнэ үү) – Мохамед Ахмед Абдалла Ахмед, Доха, Катар улс; Вивьян Абдалла, Йерусалим; Параскеви Вивьен Аллимонос, Мельбурн, Австрали улс; Нада А.Аль-Созе, Багдад, Ирак; Майка Брожстек, Краков, Польш улс; Бори Бендэзу-Велез, Лима, Перу улс; Жосита Экуеви-Амави, Ломе, Того улс; Алехандра Эскобоза, Хэрмисило, Мексик улс; Усавадее Катпичай, Бангкок, Тайланд улс; Памела Кували, Лилонгве, Малави

улс; Ратна Мухержи, Ченай, Энэтхэг улс; Мариа Паола Пьерини, Ром, Итали улс; Дана Полчикова, Братислав, Словакийн Бүгд Найрамдах улс; Карин Розничек, Мюнхен, Герман улс; Луиза Мариа Виау, Гватемала хот, Гватемал улс; Беатрис ЖП Вилэн, Пор-о-Принс, Гаити улс; Карнелиа Влачу, Бухарест, Румын улс; Зу Хонг, Гуанжоу, БНХАУ.



Гэрэл зургийг авсан Роберт Кайзер, АНУ-ын Төрийн Департамент

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

Тогтолцоо хэрхэн үйлчилдэг вэ

КОЛЛЕЖИД ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАА ХЭРХЭН СОНГОХ ВЭ

Линда Тобаш




Stew Milne, AP/WWP

Хичээлийн танхим том болон жижиг эсвэл сургалт нь албан болон албан бус байж болно. Энэхүү гэрэл зурганд Брауны их сургуулийн багш Род Айлэнд дахь оюутны хотхонд хичээлийн танхимд зааварчлага өгч байгаа нь.

Зохиогч нь сургалтын хүрээнд “үндсэн” болон “дагалдах” мэргэжлийн сургалтыг тодорхойлж буй бөгөөд сургалтын чиглэлээ зөв сонгоход нь оюутнуудад хэрэгтэй зөвлөлгөө өгч танилцуулж байна. Линда Тобаш нь Олон улсын боловсролын хүрээлэнгийн их сургууль төгсөгчдийг албан тушаалд хувиарлан байршуулах албаны захирлаар ажилладаг юм.

“Ихэнх хүмүүстэй нэгэн адил, мэргэжлийн үндсэн сургалтын чиглэлээ сонгосон тэр жилийг би сайн санаж байна. Үнэн хэрэгтээ, энэ талаар өөрийн шийдвэрээ би гурван удаа өөрчилж гаргаж байсан”, гэж Д-р Давид Брөунли, Пенсильваний их сургуулийн урлагийн түүхийн професор өгүүлж байна (http://www.college.upenn.edu/curriculum/major_choosing.html).

Олон зуун үндсэн мэргэжлийн сургалт болон олон мянган коллеж, их сургуулиудаас алийг нь сонгох, ямар мэргэжлээр хаана суралцах талаар залуучууд хэрхэн шийдвэр гаргадаг вэ? Зарим хүмүүсийн хувьд, эхний шийдвэр бол хаана суралцахаа эхлээд сонгодог. Жишээ нь, инженер, технологи болон компьютерийн шинжлэх ухааны чиглэлийн хөтөлбөрөөр суралцах боломж олгож буй улсын олон их сургууль, чөлөөт сэтгэлгээний үзэл бодол дээр тулгуурласан коллеж болон төрөлжсөн сургалттай сургуулиуд уу, эсвэл хот суурин газарт уу эсвэл хөдөө орон нутагт уу, далайн эрэг орчим уу эсвэл уулархаг нутагт уу, гэрийнхээ дэргэд үү эсвэл гэрээсээ алс хол уу, санхүүгийн туслалцаа үзүүлдэг сургуульд уу эсвэл хөл бөмбөгийн багт



Гэрэл зургийг авсан Пэт Литл AP/WWP

Пэнсильваны технологийн коллеж нь асар том машин техникт засвар тохиргооны ажил хийдэг. Тухайн коллежийн оюутан нь Бэнжамин Франклины хүсэлтээр гэрээслэн үлдээсэн хөрөнгө санхүүгээс сургалтын тэтгэлэг авдаг аж.

тоглох, оюутны хотхоны телевизийн болон радио станц, сонины редакцид ажиллах, драмын жүжигт тоглох, кино бүтээхэд оролцох боломж олгодог зэрэг хичээлээс гадуур тусгай үйл ажиллагаа явуулдаг сургуульд уу? гэдэг асуулттай байнга тулгардаг.


Гэвч ихэнх залуучуудын хувьд, юуны өмнө суралцах коллежээ сонгохдоо ямар чиглэлээр тэд суралцах хүсэлтэй байгаа болон нэгэнт сонгосон үндсэн мэргэжлийн чиглэлээр чанартай сайн сургалт явуулдаг сургууль хаана байна зэргийг тодорхойлдогос эхэлдэг.

Бусад орны үндэсний боловсролын тогтолцоотой харьцуулахад эдгээр орны коллеж аль нэг мэргэжилд суралцахад тухайн оюутан ерөнхий боловсролын сургуульд юу сурсан эсвэл коллежийн элсэлтийн шалгалтанд ямар баал (оноо) авсанаас ихээхэн хамаардаг бол АНУ-ын коллеж, их сургуулиуд ерөнхий боловсролын сургууль төгссөн элсэгчдэд дуртай мэргэжлээр нь суралцах өргөн боломжийг олгодог байна. Мэдээж хэрэг, зарим ихээхэн нэр хүндтэй цөөн сургуулиудын элсэлтийн өрсөлдөөний шалгуур босго өндөр байдаг тул сурлага, мэдлэгээрээ шалгарсан цөөн тооны оюутнууд л дээрх

сургуульд элсэн орох боломжтой байдаг. Бүр зарим тохиолдолд, энгийн зарим сургуулиудад жишээ нь, сувилагч болон инженерийн ангид суралцахад хязгаартай бөгөөд элсэлтийн өндөр шаардлага тавьдаг байна. Гэхдээ, ер нь ирээдүйн оюутнууд мэргэжлээ сонгох боломж өргөн хүрээтэй байдаг байна.

КОЛЛЕЖИЙН ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ГЭЖ ЯГ ЮУ ВЭ?

Станфордын их сургуулийн Вэб хуудсанд “үндсэн мэргэжлийн сургалт бол дээд сургуульд суралцах хугацаандаа сонгосон сургалтын чиглэлээр мэргэших салбар юм. Таны хийсэн сонголт нь их сургуулийн тухайн хичээлд зарцуулсан цаг, хичээл зүтгэлээр тодорхойлогдох болно. Харин үндсэн мэргэжлийн сургалтын шаардлага болон их сургуулийн шаардлагыг амжилттай биелүүлж дүүргэсэн тохиолдолд та бакалаврын зэрэг эзэмшинэ. Таны хамрагдсан үндсэн мэргэжлийн сургалт нь таны оюун ухааныг хөгжүүлэх, суурь боловсролоос гүнзгийрүүлсэн сургалт руу дэвшин орох таны



Жорж Саваны Урлаг, дизайны коллежийн оюутан анатомийн тэмдэглэл хийж байгаа нь

чадавхийг илэрхийлэхэд сайхан боломж олгоно. Таны юу сурах нь хувь хүний хувьд таны өөрийн шийдэх чухал асуудал юм” хэмээн өгүүлсэн байна (<http://www.stanford.edu/susanz/Majors.html>).

Оюутан үндсэн мэргэжлийн сургалтаа сонгохдоо тэрээр үндсэн боловсролын шаардлага (их сургуулийн

шаардлага) болон их сургуулийн үндсэн мэргэжлийн сургалтын шаардлага хоёроос бүрддэг сургалтын хөтөлбөрийг дүүргэх талаар коллежтой гэрээ байгуулдаг. Өөрөөр хэлбэл, коллежийн сургалтын хөтөлбөр нь зөвхөн үндсэн мэргэжлийн сургалтын хүрээгээр хязгаарлагдаггүй. Үнэн хэрэгтээ, курсын ажлын 50-60 хувь нь ерөнхий боловсрол ба сонгож авсан хичээлээс буюу, өөрөөр хэлбэл, тухайн оюутны үндсэн мэргэжлийн сургалтын хүрээнд болон уг хүрээнээс гадуур бусад олон чиглэлийн сургалтад хамрагдсан хичээлээс бүрддэг юм. Үндсэн мэргэжлийн сургалтын хичээлийг ерөнхий боловсролын хичээлийн хувьтай харьцуулахад тухайн сургууль болон үндсэн мэргэжлийн сургалтаас хамаарч янз бүр байдаг бөгөөд гэхдээ, бүх боловсролын сургуулиуд ямар нэгэн ерөнхий боловсролын хичээлд суухыг шаарддаг байна. АНУ-ын ерөнхий боловсролын дараах сургалт нь чөлөөтэй сэтгэн бодох чадварын уламжлал дээр үндэслэгдэж байгаа бөгөөд ерөнхий боловсролыг чухалчлан үздэг байна. Дээд боловсролын дараах бакалаврын сургалтын зорилго нь оюутан бүрийн онцгой сэтгэн бодох чадвар болон аливаа зүйлд суралцах чадамжийг хөгжүүлэхийн зэрэгцээ их сургуулийн тусгай салбарын чиглэлээр мэргэших чадавхийг хөгжүүлэхэд оршдог байна.

Ихэнх боловсролын сургуулиудад оюутнууд үндсэн мэргэжлийн сургалт болон дагалдах мэргэжлийн сургалтыг өөрсдөө чөлөөтэй сонгох эрхтэй аж. Дагалдах мэргэжлийн сургалт буюу төвлөрсөн сургалт бол ихэнхдээ их сургуулийн үндсэн мэргэжлийн сургалттай нягт холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн оюутны үндсэн мэргэжлийн сургалт нь англи хэл байхад дагалдах мэргэжлийн сургалт нь театрын хичээл, эсвэл үндсэн мэргэжлийн

сургалт нь түүх байхад дагалдах мэргэжлийн сургалт нь улс төрийн шинжлэх ухаан буюу эсрэгээр байж болох талтай. Зарим цөөн төрлийн дагалдах мэргэжлийн сургалт нь зэрэг дэвтэй байхыг шаарддаг бөгөөд ихэнх тохиолдолд үндсэн мэргэжлийн сургалтын зэрэг, дэвтэй “дүйцсэн” байх шаардлагатай.

Зарим сургуульд их сургуулийн зөвлөхүүдтэй нягт хамран ажиллаж буй оюутнууд өөрсдийн үндсэн мэргэжлийн сургалтыг тусгайлан боловсруулж болдог байна. Хос мэргэжлийн сургалтыг сонгож буй их, дээд сургуулийн оюутнуудын тоо нэмэгдэх хандлагатай болсон. Өөрөөр хэлбэл, тэд хоёр мэргэжлээр суралцаж төгсөх шаардлага хангадаг байна. Энэхүү хос мэргэжлийн сургалт нь ихэнх тохиолдолд хоорондоо уялдаа холбоотой байдаг. Тухайлбал, түүх болон нийгэм судлалын чиглэлээр хос мэргэжилтэй байж болно. Эсвэл хос мэргэжлийн сургалт нь тэс өөр байж болдог. Тухайлбал, биологи ба уран зохиолын мэргэжилтэй байж болох юм. Ихэнх тохиолдолд, оюутнууд ирээдүйд ажил эрхлэх, албан тушаал дэвшихэд бэлтгэлтэй байх болон сургуулиа төгсөөд бусадтай өрсөлдөх чадвартай байх зорилгоор нэгээс дээш үндсэн мэргэжлийн сургалтад хамрагддаг. Гэхдээ, зарим тохиолдолд оюутнууд хувийн хүсэл сонирхлын дагуу хос мэргэжил эзэмших хүсэлтэй байдаг. Зарим боловсролын байгууллагуудад хос мэргэжлийн сургалтанд нэгэн зэрэг хамрагдаж болдог байхад зарим сургуульд тус тусад нь ээлж дараалан суралцаж байна. Ихэнх тохиолдолд, эрдмийн зэрэг эзэмших хугацаа бага зэрэг урт байдаг боловч оюутнууд үндсэн мэргэжлийн сургалтаа сургуульд элссэн өдрөөс эхлэн шууд сонгодоггүй. Мөн түүнчлэн ихэнх тохиолдолд, үндсэн мэргэжлийн аль нэг сургалтын хүрээнд ерөнхий боловсролын болон заримдаа бүр тусгай сонгосон хичээлийн сургалт нь дагалдах мэргэжлийн сургалтын зэрэг, дэвтэй дүйцсэн байх шаардлагатай байдаг.

Бүх боловсролын байгууллагуудын зүгээс сургуульд суралцаж төгсөхөд биелүүлэх сургалтын шаардлага болон гарах үр дүнг оюутнуудад ойлгомжтой хэлбэрээр тодорхойлсон байдаг. Оюутнууд, ихэнх тохиолдолд, их сургуулийн зөвлөхтэй тогтмол уулздаг бөгөөд тэрээр тэдэнд эрдмийн цол, зэргийн шаардлагад нийцсэн сургалтыг сонгоход туслалцаа үзүүлдэг байна. Ихэнх боловсролын сургуулиуд сургалтын хөтөлбөр эсвэл эрдмийн цол, зэргийн шаардлагыг хангаж буй эсэхийг шалгах асуулга, тестэд хамруулж оюутнуудад аргачлалын туслалцаа мөн үзүүлдэг байна.

КОЛЛЕЖИЙН МЭРГЭЖЛИЙН ҮНДСЭН СУРГАЛТЫН СОНГОЛТЫГ ХЭЗЭЭ ХИЙХ ВЭ?

Зарим оюутнууд коллежид элсэн орохдоо юу сурахыг хүсч байгаагаа мэддэг, зарим нь мэдэж байгаа гэж өөрсдийгээ боддог, зарим нь энэ талаар

ямар ч бодолгүй байдаг байна. Ихэнх оюутнууд үндсэн мэргэжлийн сургалтаа ямар ч байсан нэг удаа сольж өөрчилдөг байна.

АНУ-ын их, дээд сургууль, коллежийн оюутнуудын гуравны хоёр нь сургуулиа төгсөхөөс өмнө үндсэн мэргэжлийн сургалтаа хэдэнтэй сольж өөрчилж, эцсийн шийдвэрт хүрэхээсээ өмнө 4-5 удаа үндсэн мэргэжлийн сургалтыг өөрчилж сонгодог тул ихэнх боловсролын сургуулиуд оюутнуудыг коллежид орж суралцаж эхэлсний дараа үндсэн мэргэжлийн сургалтаа шууд сонгохыг заавал шаарддаггүй байна. Тэр ч байтугай, элсэлт авах үед сурлага сайтай оюутнуудаас үндсэн мэргэжлийн сургалтаа сонгон тодорхойлохыг шаарддаг сургуулиуд хүртэл оюутнуудад “тодорхой бус байгаа” гэсэн хэлбэрээр эсвэл “албан ёсоор сонголтоо хийлгүйгээр” үндсэн мэргэжлийн сургалтанд хамрагдаж болох аж.

Үндсэн мэргэжлийн сургалтаа сонгох хугацаа оюутнуудад хязгаартай байдаг тул бакалаврын зэрэг олгох сургалт нь 4 жил буюу семестрийн 120 кредит цагийг хамардаг учраас (хавсралтыг үзнэ үү) ихэнх тохиолдолд оюутнууд хоёрдугаар дамжаагаа төгсөх үед шийдвэрээ гаргаж улмаар



Мэри Вашингтоны Их сургуулиас ирүүлсэн зураг “Дасгал хий, дасгал хий” - энэ бол Мэри Вашингтоны Виржинийн их сургуулийн мэргэжлийн үндсэн сургалтын амьдралын хэм аж.

үлдсэн хугацаанд бакалаврын сургалтаа дүүргэх боломжтой байдаг байна. Мэдээж хэрэг, орон нутгийн коллежид суралцахаар шийдсэн оюутнууд (хоёр жилийн хугацаатай сургалттай тухайн байгууллагын шинжлэх ухааны гишүүний зэргийг олгодог аж) үндсэн мэргэжлийн сургалтаа эртхэн сонгох нь чухал байдаг. Мөн түүнчлэн, олон цагийн хичээл шаарддаг (жишээ нь, өндөр техникийн болон эрүүл мэндийн салбарын) эсвэл бэлтгэлийн хичээлд суралцах шаардлагатай (гүнзгийрүүлсэн сургалтад хамрагдахаас өмнө зайлшгүй суух шаардлагатай анхан шатны сургалт) мэргэжлийн үндсэн сургалтыг сонгосон зарим оюутнуудын хувьд эцсийн шийдвэрээ аль болох эртхэн гаргах нь чухал байдаг.

МЭРГЭЖЛИЙН ҮНДСЭН СУРГАЛТАА ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Зарим нь сурч байгаа хичээлдээ үнэхээр дур сонирхолтой байдаг. Зарим нь ерөнхий боловсролын сургуульдаа маш тухайн чиглэлээр сайн сурдаг байсан аж. Зарим нь ажил мэргэжлийнхээ замаар замнах, албан тушаалд дэвших зорилгоор үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдах зорилготой байдаг. Жишээ нь, сувилагч хийх, багшлах, уран бүтээл хийх, инженерийн мэргэжил эзэмших г.м. Гэхдээ, олон оюутнууд энэ талаар юу ч мэддэггүй. Тэд коллежоо төгсөөд юу хийх талаар зарим нэг санаа, бодолтой байдаг боловч ажил дээр гарахад ямар чиглэлээр суралцах нь ирээдүйд илүү ач тустай байх талаар сайн ойлголтгүй байдаг байна. Ганцхан үндсэн мэргэжлийн сургалт нь тодорхой ажил мэргэжил эзэмших, албан тушаал эрхлэх, дэвшихэд хангалтгүй байх талтай. Үнэн хэрэгтээ, зарим сургуулиуд ажил мэргэжил сонгох болон мэргэжлийн үндсэн сургалт сонгох нь хоорондоо тусдаа, үйл явц болохыг оюутнуудад анхааруулдаг байна.



Гэрэл зургийг авсан Дамиан Доварганес, AP/WWP Карнеги-Мелон их сургуулийн оюутан Невада муж улсад зохион байгуулагдах уралдаанд оролцохоор Пенсилванаас авч ирсэн хүнгүй явдаг, шагнал хүртэж байсан моторт дугуйнд медаль зүүж байгаа нь

Оюутнууд мэргэжлийн үндсэн сургалтаа сонгохдоо юу хийхийг хүсч байгаа, суралцах чадвар нь ямар байгаа, ямар чиглэлээр суралцах сонирхолтой байгаа зэргийгээ тодорхойлох нь чухал гэж ихэнх багш, сурган хүмүүжүүлэгчид үздэг. Мэргэжлийн үндсэн сургалтаа сонгоход тухайн коллеж, их сургуулиудаас оюутнуудад ихээхэн тус дөхөм үзүүлдэг. Олон боловсролын байгууллагууд ирээдүйн болон одоо сурч буй оюутнуудад мэргэжлийн үндсэн сургалтаа сонгоход нь зориулж маш өргөн мэдээлэл, санал, зөвлөмжийг өөрсдийн Вэб хуудсанд байрлуулдаг байна. Мөн түүнчлэн, зарим их, дээд сургууль, коллежиуд Вэб хуудсандаа зөвхөн өөрсдийн сургуулийнхаа сургалтын хөтөлбөр, үйлчилгээний талаар гол төлөв танилцуулахыг анхаардаг бол бусад ихэнх сургуулиуд ямар ч коллежид элсэхэд тус дөхөм болохуйц мэдээ, мэдээллийг Вэб хуудсандаа байрлуулдаг байна (хавсралтыг үзнэ үү).

Олонтаа өгөгддөг зөвлөлгөөг дор сийрүүлэв. Үүнд:

- Өөрийнхөө талаар ихийг мэдэж авахыг эрмэлз. Таны сургалтын давуу болон сул тал нь юу вэ? Юу нь танд таалагддаг вэ? Та юу сонирхдог вэ? Таны эрхэмлэдэг үнэт зүйл юу вэ? Таны ойрын зорилт юу вэ? - сургуулиа төгссөний дараа ажилд орох уу, эсвэл дараагийн шатны сургуульд орох уу?
- Хувийн мэдлэг, чадварынхаа түвшинг тогтоосон үнэлэлт дүгнэлттэй байх нь чухал. Хэрэв ийм тодорхойлолтыг өөрийн сурч байгаа сургууль болон амьдарч байгаа хотын холбогдох газраас авах боломжгүй бол энэ талаар АНУ-ын Боловсролын зөвлөлгөө, мэдээллийн төвөөс асууж лавлаж болно. АНУ-ын Төрийн департамент нь АНУ-ын Боловсролын хөтөлбөрөөр дамжуулан дэлхийн 170 оронд 450 гаруй төвүүдийг ажиллуулдаг (<http://www.educationusa.state.gov>).
- Их сургуулийн тэнхимүүдийн Вэб хуудсыг үзнэ үү. Санал болгож буй мэргэжлийн үндсэн сургалтын талаар та танилцана уу. Санал болгож буй сургалтын хөтөлбөр болон эрдмийн цол, зэрэг эзэмшихэд тавигдах нөхцөл, шаардлагыг

судалж үзнэ үү. Зарим сургуулийн эрдэмтэн багш нар Вэб хуудсандаа өөрийн сургуулийнхаа сургалтын хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй танилцуулсан байдаг. Хэдий чинээ сурагалтын хөтөлбөр, мэргэжлийн үндсэн сургалтын талаар өргөн мэдээлэлтэй байна төдий чинээ сайн байх болно.

- АНУ-д очсон тохиолдолд та оюутны хотхоны боловсролын албанд хандаж тэндхийн ажилтнууд, тэнхимийн багш нар, оюутнуудтай уулзах хэрэгтэй.
- Коллежийн ажил эрхлэлтийн асуудал эрхэлсэн төвд очиж сургууль төгсөгчдөөс ажил олсон тухай жагсаалттай танилцаж, улмаар тэд ямар мэргэжлийн үндсэн сургалтаар сургууль төгссөн талаар танилцах нь зүйтэй.
- Сургуульд элссэний дараа өөр өөр тэнхимийн төрөл бүрийн курс, дамжааг туршаад үз. Мөн мэргэжлийн үндсэн сургалтыг явуулж буй тэнхимийн гишүүд болон тухайн сургуульд суралцаж буй оюутнуудын талаар их зүйл мэдэж авахыг хичээ.
- Хэрэв та мэргэжлийн үндсэн сургалтаа буруу сонгосон гэж үзвэл энэ талаар санаа зовоод хэрэггүй. АНУ-ын коллежийн ихэнх оюутнууд сонгосон мэргэжлийн үндсэн сургалтаа байнга сольж өөрчилдөг. Таалагдахгүй, өндөр шаардлага тавьдаггүй, сонирхолгүй байгаа мэргэжлийн үндсэн сургалтанд суралцах шаардлагагүй.
- Мэргэжлийн үндсэн сургалтын сонголттой адилтгаж бүү андуур. Ямар ч мэргэжлийн үндсэн сургалт нь олон төрлийн ажил эрхлэх боломж олгодог. Вашингтоны их сургуулийн Вэб хуудаснаас үзэхэд “коллежийн боловсрол нь таныг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэхэд тус дөхөм болдог боловч ямар нэгэн тодорхой ажил мэргэжлийг эзэмших явцуу шаардлага биш юм” хэмээжээ.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН СОНГОЛТ БА АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЗАМЫН СОНГОЛТ ХОЁРЫН ХООРОНДОХ УЯЛДАА, ЯЛГАА

Үндсэн мэргэжлийн сургалтаа сонгох нь яах аргагүй том сорилт билээ. 3600 коллеж болон их сургуулиудад 900 гаруй үндсэн мэргэжлийн сургалт явуулдаг хэмээн Коллежийн удирдах зөвлөлийн Үндсэн мэргэжлийн сургалтын тухай гарын авлагад тодорхойлжээ. Олон арван ном, гарын авлага нь таны сонирхсон үндсэн мэргэжлийн сургалтыг олж сонгоход тусладаг бол коллежуудын Вэб сайтуудад ороход ямар ч үнэ төлбөргүй бөгөөд тэндээс маш олон төрлийн, үр ашигтай мэдээ, мэдээлэл олж авах боломжтой.

Бүх коллеж болон их сургуулиуд нь өөрсдийнхээ каталог болон Веб хуудсанд өөрсдийн санал болгож буй үндсэн мэргэжлийн сургалтын чиглэл болон эрдмийн зэргийн талаарх бүрэн жагсаалтыг танилцуулсан байдаг. Эдгээр коллеж, их сургуулиуд нь үндсэн мэргэжлийн сургалтын талаар ойлголт авах, сонголт хийхэд зориулагдсан байдаг бөгөөд өргөн цар хүрээтэй мэдээлэл, сургуульд хэрхэн элсэх талаар зааварчлага өгч холбогдох мэдээллийн эх сурвалжаар хангадаг. Жишээлбэл, Миннесотагийн их сургуулийн Вэб хуудас нь коллежийн үндсэн мэргэжлийн сургалтын талаар болон ирээдүйд ажил эрхлэх, албан тушаал дэвших тухай хүртэл холбогдолтой мэдээллээр хангадаг байна. Тухайлбал, “Таны үндсэн мэргэжлийн сургалтаа сонгох ба сольж өөрчлөх талаархи гарын авлага”-ыг дурьдаж болно[<http://ucs1.ucs.umn.edu/www/majorworkbook.html>].

Олон төрлийн үндсэн мэргэжлийн сургалтын тухай

Зарим үндсэн мэргэжлийн сургалт нь ажил мэргэжил эзэмших, албан тушаал дэвших сонголттой шууд холбоотой байдаг бол нөгөө хэсэг нь төдийлэн хамааралгүй байдаг аж. Ажил

мэргэжлийн хэтийн төлөвөөс хамааран үндсэн мэргэжлийн сургалтыг дараах гурван ангилалд хуваадаг байна. Үүнд:

Техник- мэргэжлийн бус тусгай сургалт
Техник- мэргэжлийн бус тусгай сургалт нь тусгай албан тушаал эрхлэх буюу тодорхой нэгэн нарийн мэргэжлийн салбарт ажиллахад зориулагдаагүй болно. Ажлын холбогдох дадлага туршлага болон тухайн байгууллага дээр хийх дадлагын ажил хоёрыг хослуусан тохиолдолд уг хөтөлбөр нь тодорхой нэг ажил эрхлэх зэрэг, цолтой болоход нөлөөлдөг. Үүний нэг тод жишээ бол түүх, улс төр болон нийгэм судлалын чиглэлийн сургалт юм. Зарим оюутнуудын хувьд эдгээр сургалт нь гүнзгийрүүлсэн сургалтанд хаирагдах бэлтгэл болдог бөгөөд түүнийг ажил дээрээ эсвэл дилломын дараахь сургалтын олж эзэмших боломжтой юм.

Техникийн болон тусгай мэргэжил олгоход чиглэгдсэн сургалт

Техникийн болон тусгай мэргэжил олгоход чиглэгдсэн үндсэн мэргэжлийн сургалт нь тусгай нэг төрлийн ажил эрхлэхэд буюу яг нэг чиглэл, салбарт чиглэгдээгүй байдаг. Энэ чиглэлийн мэргэжлийн үндсэн сургалтын хүрээнд та дадлагажигчийн түвшинд л ажил эрхлэхээр бэлтгэгдэх аж. Үүний тод жишээ бол сэтгүүл зүй, менежмент болон математикийн шинжлэх ухааны цол зэрэг юм.

Техникийн болон тусгай мэргэжлээр бэлтгэх сургалт

Техникийн болон тусгай мэргэжлээр бэлтгэх үндсэн мэргэжлийн сургалт нь тусгай ажил эрхлэх, мэргэжил эзэмшихэд чиглэгдэж улмаар бэлтгэл сургалт болдог байна. Эдгээр хөтөлбөр нь тухайн мэргэжлийн тусгай зөвшөөрөл, лицензийн боловсролын шаардлагыг хангахад чиглэгдсэн байдаг. Үүнийн жишээ бол багш, сувилагч болон инженерийн мэргэжил юм.

Мэргэжлийн үндсэн сургалтын ерөнхий жагсаалт

Хөдөө аж ахуй	Ургамал судлал	Компьютер ба математикийн шинжлэх ухаан
Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан	Мал эмнэлгийн шинжлэх ухаан	Ном зүйн шинжлэх ухаан
Мал, амьтан судлал	Компьютерын шинжлэх ухаан	Музей ба түүхийн үнэт зүйлсийн хадгалалт, хамгаалалт
Ургамал ба хөрс судлал	Компьютер ба мэдээллийн шинжлэх ухаан	Боловсрол
Хөдөө аж ахуйн бизнес ба менежмент	Компьютерын программ хангамж	Хос хэл эзэмших болон олон үндэстний соёлын боловсрол
Фермерийн аж ахуйн менежмент	Мэдээллийн боловсруулалт	Тусгай боловсрол
Хөдөө аж ахуйн механикжуулалт	Мэдээлэл менежментийн шинжлэх ухаан ба системийн хангамж	Өмгөөлөл

Насанд хүрэгчидийн болон тасралтгүй боловсрол
Анхан шатны боловсрол
Сургуулийн өмнөх боловсрол
Өсвөр үеийн боловсрол
Ахлах ангийн боловсрол
Соёл урлаг, дуу хөгжим ба драмын жүжгийн боловсрол
Гэр ахуйн эдийн засгийн боловсрол
Биеийн тамир\Эрүүл мэнд\
Бялдаржуулах боловсрол
Шинжлэх ухааны боловсрол
Техник мэргэжлийн\ аж үйлдвэрийн боловсрол
Бизнесийн боловсрол
Гадаад хэлний багшийн боловсрол
Либерал соёл, урлагийн боловсрол
Нийгмийн шинжлэх ухааны боловсрол
Математикийн боловсрол
Компьютерын шинжлэх ухааны боловсрол
Шашны боловсрол
Инженерчлэл
Сансар судлал, сансарын хөлөг, техник, технологийн инженерчлэл
Сансарын хөлөг, техник, технологийн инженерчлэл
Хөдөө аж ахуйн инженерчлэл
Барилгын архитектурын инженерчлэл
Био-инженерчлэл
Био-эмнэлгийн инженерчлэл
Шавар, шаазан эдлэлийн инженерчлэл
Химийн инженерчлэл
Браилгын инженерчлэл
Холбоо харилцааны инженерчлэл
Компьютерын инженерчлэл
Цахилгааны инженерчлэл
Цахим техникийн инженерчлэл
Геологийн инженерчлэл
Геофизикийн инженерчлэл
Аж үйлдвэрийн инженер ба дизайн, загвар зохион бүтээх инженерчлэл
Механик инженерчлэл
Төмөрлөгийн үйлдвэрлэлийн инженерчлэл
Уул уурхай, эрдэс

баялгийн инженерчлэл
Далайн инженерчлэл
Тэнгэсийн барилгын инженерчлэл
Цөмийн инженерчлэл
Газрын тосны инженерчлэл
Газрын тандалт, газрын зураг зүйн шинжлэх ухаан
Техник, технологийн системийн задлан шинжилгээний инженерчлэл
Инженерчлэлтэй холбогдолтой технологи
Төсөл зохион бүтээх шинжлэх ухаан
Автын инженерчлэл ба технологи
Цахилгааны технологи
Цахилгаан механикийн технологи
Байгаль орчин\эрчим хүчний хяналтын технологи
Инженерчлэл механик
Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн технологи
Барилга байгууламжийн технологи
Иргэний нисэх ба агаарын тээвэрлэлт
Тээвэрлэлт\логистик
Англи хэл ба утга зохиол
Англи хэл
Сонгодог утга зохиол ба сонгодог утга зохиол судлал
Харьцуулсан утга зохиол
Хэл зүй ба уран яруу бичлэг
Хэл шинжлэл
Америкийн утга зохиол
Английн утга зохиол
Хэлэхүй ба уран илтгэлийн урлаг
Техникийн болон бизнесийн хэл бичлэгийн зүй
Угсаатны зүйн судлал
Африк судлал
Америк судлал
Ази болон Номхон далайн судлал
Европ судлал
Латин Америк судлал
Ойрох Дорнод судлал
Африкаас гаралтай америк үндэстний (хар арьстан) судлал
Америкийн уугуул

иргэдийн түүх судлал
Испани-америкийн судлал
Лалын шашин судлал
Жүүд болон жүүд үндэстний судлал
Гадаад хэл
Гадаад хэл утга зохиол
Хятад хэл
Япон хэл
Ази үндэстнүүдийн хэл
Герман хэл
Скандинавын хэл
Франц хэл
Итали хэл
Испани хэл
Португал хэл
Латин хэл
Грек хэл
Хебрю хэл
Ойрох Дорнодын хэл
Орос хэл
Слав хэл
Ерөнхий болон олон талт шинжлэх ухаан судлал
Хүмүүнлэгийн ухаан
Маргааныг шийдвэрлэх \энхийг сахиулах үйл ажиллагааны судлал
Эмэгтэйчүүдийн асуудал судлал
Либерал ба ерөнхий шинжлэх ухаан судлал
Олон талт шинжлэх ухаан судлал
Хувь хүн сонгон судалдаг үндсэн мэргэжил
Математикийн шинжлэх ухаан
Математикийн шинжлэх ухаан
Даатгалын шинжлэх ухаан
Хэрэглээний математик
Статистикийн шинжлэх ухаан
Цэргийн шинжлэх ухаан ба Батлан хамгаалахын үйлчилгээ
Цэргийн шинжлэх ухаан
Эрүүгийн эрх зүй ба хууль зүй сахиулах
Албадан хүчлэлт
Галын хамгаалал, аюулгүй байдал
Цэцэрлэгт хүрээлэн ба амралтын бүс
Цэцэрлэгт хүрээлэнгийн

удирдлага
 Биеийн тамир спорт, амралт,
 чөлөөт цагийн судлал
 Морин спорт судлал
 Байгаль орчны менежмент
 ба хамгаалал
 Ойн модны гаралтай
 бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 болон боловсруулалт
 Зэрлэг ан амьтан болон
 загасны менежмент
 Экологийн шинжлэх ухаан
 Байгаль орчны шинжлэх ухаан
 Философи, шашин
 шүтлэг, шашин судлал
 Философи
 Шашин шүтлэг, шашин судлал
 Философи ба шашин
 Библийн судрын хэл
 Библийн судар судлал
 Шашны боловсрол
 Шашны дуу хөгжим
 Сүм хийдийн удирдлага
 Олон нийтийн хэрэг
 ба хууль зүй
 Эрүүгийн эрх зүй ба хууль зүй
 Албадан дайчилгаа
 Олон нийтийн хэрэг
 ба захиргаа
 Нийгмийн ажил ба үйлчилгээ

Хуулийн хүрээнд үзүүлэх
 урьдчилсан үйлчилгээ
 Хуулийн зөвөлөлгөө
 өгөх үйлчилгээ
 Шинжлэх ухаан
 Биологи
 Биохими
 Биофизик
 Ургамал
 Эд эсийн болон
 молекулярын биологи
 Микробиологи/бактериологи
 Амьтан судлал
 Далайн биологи судлал
 Биологийн шинжлэх ухааны
 төрөлжсөн мэргэжил
 Биеийн тамирын
 шинжлэх ухаан
 Одон орны судлал
 Сансрын физик судлал
 Агаар мандлын шинжлэх
 ухаан ба цаг уур судлал
 Хими судлал
 Геологийн шинжлэх ухаан
 Физикийн шинжлэх ухаан
 Газар ба одон орны
 шинжлэх ухаан
 Шинжлэх ухааны технологи
 Нийгмийн ухааны
 шинжлэх ухаан

Хүний хөгжил, гарал
 үүслийн судлал
 Археологийн шинжлэх ухаан
 Криминалоги
 Эдийн засгийн шинжлэх ухаан
 Газар зүйн шинжлэх ухаан
 Засаглалын шинжлэх ухаан
 Түүх судлал
 Олон улсын
 харилцааны судлал
 Улс төрийн шинжлэх ухаан
 Сэтгэл зүйн шинжлэх ухаан
 Нийгэм судлал
 Хот байгуулалт, төлөвлөлт
 Урлаг, уран сайхан
 Гар урлал
 Бүжгийн жүжгийн урлаг
 Загвар зохион бүтээх урлаг
 Гэрэл зургийн урлаг
 Драммын жүжгийн урлаг
 Кино урлаг
 Дүрслэх урлаг
 Хөгжмийн боловсрол
 Барилга, байгууламжийн
 дотоод засал,
 тохижилтын урлаг

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

Ихэнх бакалаврын зэрэг олгох сургалтыг
 бүтэн дөрвөн жилийн хугацаанд явуулахаар
 төлөвлөгдсөн байдаг. Бакалаврын зэрэг нь
 эрдмийн зэргээр цаашид суралцах болон
 ажил эрхлэх боломжийг олгодог. Шинжлэх
 ухааны гишүүний зэргийг голдуу хоёр жилийн
 сургалттай орон нутгийн коллежууд (эсвэл
 гурван жилийн сургалттай бага коллежууд)
 олгодог журамтай аж. Тухайн сургуулийн
 шинжлэх ухааны гишүүний зэрэг нь дөрвөн
 жилийн хугацаатай дээд боловсролын өмнөх
 сургалтанд хамрагдах эсвэл ажил эрхлэх боломж
 олгодог.

Ихэнх хичээлийн жил нь 15 долоон хоногийн
 хоёр семестертэй байдаг.*

Хичээлийн жил нь голдуу найм буюу есөн
 сард эхэлж, тав буюу зургаан сард дуусч, арван
 хоёр буюу нэг сард богино хугацааны “өвлийн”
 амралттай байдаг. Зургаа, долоо буюу найман
 сард зуны амралт болдог тул сургуулийн өмнөх
 түвшний сургалтанд элсүүлэх ажиллагаа энэ

үеэр заавал явагдах шаардлагагүй байдаг.

“Дамжаа”

Freshman: Эхний жилдээ суралцаж буй
 оюутан;

Sophomore: Хоёр дахь жилдээ суралцаж буй
 оюутан;

Junior: Гурав дахь жилдээ суралцаж буй сурагч
 оюутан;

Senior: Дөрөв дэхь жилдээ суралцаж буй
 оюутан;

* Бусад нийтлэг хичээлийн жилийн хөтөлбөрт
 “сургууль, коллежид гурван сарын хугацааг”
 буюу “триместрийг” хамруулдаг ба энэ нь ижил
 гурван хугацаатай буюу тус бүр нь 10-12 долоо
 хоногтой тогтолцоо бөгөөд “улирлын буюу 3
 сарын хугацаатай” тогтолцоо тус бүр нь 10 долоо
 хоногоос бүрдсэн дөрвөн ижил хугацаа юм.
 Иймд оюутнууд хичээлийн жилийн сургалтын
 хөтөлбөрийг бүрэн хангасан гэж тооцогдохын
 тулд эдгээр 4 улирлын сургалтын хугацааны
 гуравт нь хамрагдсан байх ёстой.

БАКАЛАВРЫН ЗЭРГЭЭР СУРАЛЦАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Ихэнх бакалаврын зэргүүд нь 120 кредит цаг (улирлын буюу 3 сарын тогтолцоотой бол 180 цаг)-аас бүрддэг. Висконсен муж улсын Милуоки дахь Боловсролын итгэмжлэлийн үнэлгээний үйлчилгээний ажилтан, хатагтай Маргарет Шварцман нь кредит цагийн талаар тайлбарыг дараах байдлаар хийсэн байна.

Их, дээд сургуульд хичээлийн жилийн сургалтын хөтөлбөрийг бүрэн биелүүлэх үндсэн дээр элсэх хүсэлтэй байгаа оюутнууд тухайн сургалтын тодорхой нэг хугацаанд ямар ч байсан 15 семестрийн кредит цаг буюу жилд 30 кредит цагийн хичээлд хамрагдсан байх ёстой аж. Үүнд,

Эхний жилд суралцаж буй оюутан (Freshman): 1-30 кредит цаг;

Хоёр дахь жилд суралцаж буй оюутан (Sophomore): 31-60 кредит цаг;

Гурав дахь жилд суралцаж буй оюутан (Junior): 61-90 кредит цаг;

Дөрөв дэхь жилд суралцаж буй оюутан (Senior): 91-120 кредит цаг;

ОНОЛЫН ХИЧЭЭЛ

Нэг кредит цаг нь 50 минут (ангид хичээллэх хугацаа) -аар долоо хоногт нэг семестр (15 долоо хоног) хичээллэх хугацааг хамардаг. Иймд

оюутнууд долоо хоногт гурван удаа тус бүр 50 минутын хугацаатайгаар гурван кредит курсыг ангидаа хичээллэнэ. Ихэнх их, дээд сургуульд элсэхээс өмнөх сургалтанд хамрагдаж буй оюутнууд таван курс буюу нийт 15 кредит цагийг авдаг. Тиймээс, оюутнууд долоо хоногт 15 цагийг ангидаа хичээллэнэ. Хичээлд бэлтгэх хугацаанд уншлага, гэрийн даалгавар хийх, номын санд судалгаа хийх, тест болон асуулт, хариултын уралдаан, тэмцээнд бэлтгэх ажлууд орох ба эдгээр нь анги, танхимдаа хичээллэх цаг дээр нэмэгдэж тооцогддог.

ЛАБОРАТОРИЙН, ДАДЛАГЫН АЖИЛ БОЛОН УРЛАНД ХИЙХ СУРГАЛТ (соёл урлаг, уран зураг, шугаман зураг г.м)-ЫН КУРС

Нэг семестрийн хугацаанд нэг долоо хоногт 2-оос 4 удаа 50 минуттай тэнцэх нэг кредит цагийг анги, танхимд хичээллэх учиртай. Өөрөөр хэлбэл, оюутнууд лабораторийн болон дадлагын ажилд, урланд онолын сургалтанд 2-4 удаа тус бүр нэг кредит цаг зарцуулах ёстой аж. Гадуур хийх давтлагад кредит цагийн хязгаар буюу шаардлага тавьдаггүй болно. Жишээ нь, тухайн оюутан лабораторт явагдах сургалтанд долоо хоногт хоёроос доошгүй удаа явж сургалт бүрт наад зах нь 50 минутын 2 кредит цагийг зарцуулсан байх учиртай.

ИНТЕРНЭТ ДЭХ СОНИРХОЛ ТАТАХУЙЦ ВЭБ ХУУДАСНУУД

Америкийн олон их сургуулийн Вэб хуудсанд Их дээд сургуульд элсэн суралцах хүсэлтэй оюутнуудад зориулсан хэрэгтэй мэдээ, мэдээллийг байрлуулсан байдаг (зохиогч дараах Вэб хуудаснуудыг санал болгож байгаа болно).

Бэркли дэхь Калифорний их сургуулийн [<http://Is-advice.berkeley.edu/choosingmajor/intro.html>] вэб хуудас нь мэргэжлийн үндсэн сургалт гэж юу вэ, түүнд хэрхэн бэлтгэх, хоёр дахь жилийн эцэст мэргэжлийн үндсэн сургалтаа эцэслэн сонгох, мэргэжлийн үндсэн сургалтын болон ажил эрхлэх, албан тушаал дэвших зааварчлагын талаарх зарим нэгэн бодит үлгэр жишээг олж мэдэх, мөн түүнчлэн өөрийн зорилгоо хэрхэн тодорхойлох талаар зөвлөлгөө өгдөг байна.

Минесотийн Их сургуулийн Вэб хуудсанд [<http://ucs.umn.edu/www/majorworkbook.html>] хувь хүний сонирхол, ур чадвар, эрхэмлэдэг үнэт зүйлс болон “зан төрхийг” тодорхойлсон доктор Жонн Холландын боловсруулсан гарын авлагатай шууд онлайн хэлбэрээр танилцаж болно. Энэхүү гарын авлага нь оюутнуудад өөрсдийнхээ “зан төрхийг”-ийг танин мэдэх болон ямар үндсэн мэргэжлийн сургалт тэдэнд тохирч буй эсэхийг мэдэхэд нь тус дөхөм болох юм.

Оклахома муж улсын их сургууль [http://home.okstate.edu/homepages.nsf/toc/chp_15_1] нь “Коллежийн бэлтгэл 101” гэсэн мэдээллийн эх сурвалжийг боловсруулан гаргасан бөгөөд үүнд коллежид элсэн орохоос өмнө оюутнууд юу хийх ёстой болон сургуульд орсныхоо дараа оюутнууд юу мэдэх шаардлагатай талаар дэлгэрэнгүй зөвлөгөөг тусгажээ. Үндсэн мэргэжлийн сургалтын сонголтын талаар тусгай бүлгийг мөн энд оруулсан байна.

Пенсилван муж улсын их сургуулийн [<http://www.psu.edu/dus/md/mdmisper.htm>] Вэб мэдээлэлд үндсэн мэргэжлийн сургалтын сонголтын талаар түгээмэл буруу ташаа ойлголтын тухай хэлэлцсэн байдаг, жишээ нь: үндсэн мэргэжлийн сургалтаа хэрхэн сонгох нь ажил мэргэжлийн замаа сонгохтой ижил төрлийн асуудал биш гэдгийг тайлбарлаж улмаар ямар нэг үндсэн мэргэжлийн сургалтыг сонгосноор бусад төрлийн сургалтаас өөрийгээ хязгаарлаж буй хэрэг биш гэдэг талаар дэлгэрэнгүй тайлбар өгсөн байдаг.

Пенсилванны их сургуулийн [http://www.college.upenn.edu/curriculum/major_factors.html] Вэб хуудсанд оюутнуудад өөрсдийнхээ хүсэл сонирхол, суралцах үндэслэл, эрхэм зорилгоо тодорхойлоход нь туслах зорилгоор асуулга-тестийг санал болгодог байна.

БАКАЛАВРЫН ЗЭРГИЙН БУЮУ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛИЙН ТАНХИМ

Линда Тобаш



Майкль Конрой, AP/WWP

Анги танхимд оюутнууд хичээлийн цагаар сэдвийн талаар хамтран ярилцлага явуулахад оролцож байх ёстой.

Оюутанд тавих шаардлага багш бүрийн болон курс болгоны хувьд ялгаатай байдаг. Гэхдээ, Америк багш бол оюутан сурагч аа анги танхимд харилцан ярилцах хэлбэрээр хичээлийн явцад идэвхитэй оролцох, бие даалтын ажил ба бусад даалгаврыг хичээлийн хөтөлбөрт заасан хугацаанд нь цаг алдалгүй гүйцэтгэхийг шаардаж, эцсийн дүнг гаргахдаа явцын болон эцсийн шалгалтын дүнг харгалзахаас гадна курсийн ажлын дүнг суурь болгох нь тогтсон жишиг болсон. Линда Тобаш нь Олон улсын боловсролын институтын Их сургуулиудын түвшин тогтоох албаны захирал бөгөөд энэхүү өгүүллэгээрээ Америкт хэрэгжүүлдэг боловсролын олон төрлийн практикын заримаас тайлбарлан танилцуулж байна.

АНУ-ын дээд боловсролын анги танхимыг, оюутан сурагчид сургалтын явцад эхнээс нь аваад дуустал маш идэвхитэй оролцоно гэж тооцоолж, тийм уур амьсгалтай байлгах аргаар урьдаас төлөвлөдөг. Багш бүр өөрийн гэсэн заах аргатай, мөн оюутандаа тавих шаардлага нь өөр хоорондоо ялгаатай хэдий ч тэд оюутнуудын зүгээс хичээлдээ бүгд адил идэвхитэй оролцох шаардлагыг тавьдаг нь нийтлэг зүйл юм. Анхны хичээлийн үеэр багш хичээлийн хөтөлбөрийг оюутнуудад танилцуулна эсвэл уг хөтөлбөрийг тухайн хичээлийн Вебсайтаас олж авахыг зөвлөж хаягийг нь хэлж өгнө. Хичээлийн хөтөлбөр нь сургалтын гол зорилгуудыг тодорхойлж,

уншиж танилцах ёстой материал, бие даалтын ажлын сэдэв, сургалтын дүнг тооцолон гаргах аргачлал, хичээл тасалсаныг хэрхэн тооцох арга зэргийг агуулахаас гадна хичээлийн талаар багшийн баримтлах байр суурь буюу бодлогыг тайлбарласан байх нь цөөнгүй байдаг. Багш хүн оюутнаас хичээлд хэрхэн оролцох, яаж хандах талаар юу хүлээж байдаг тухай зарим жишээг дурдаваас:

- Оюутан нь юуны өмнө хичээлдээ суух ёстой. Олон сургуулиудад оюутны ирцийг тооцох талаар багш нар өөрийн гэсэн аргачлалтай байдаг. Зарим сургуулиудад оюутан нь хичээлийг 3-аас илүү удаа тасалсан байх ёсгүй гэх мэтчилэн үзэх нэгдсэн бодлоготой байдаг. Оюутны ирц бүртгэх нь тийм ч ер бусын асуудал биш, харин ч бүр заавал хийгдэх ёстой ажил гэж үздэг. Хичээл их таслах нь эцсийн дүнг гарахад шууд нөлөөлөх нь цөөнгүй байдаг. Түүнээс гадна багш нар урьдаас хэлж мэдэгдэлгүйгээр гэнтийн байдлаар явцын шалгалт авах буюу хяналтын ажил хийлгэх нь цөөнгүй байдаг. Тухайн өдөр хичээл таслаж дүнг авч чадаагүй нь оюутны эцсийн дүнд нөлөөлдөг.
- Оюутан хичээлдээ урьдаас бэлдсэн байх ёстой. Хичээлийн хөтөлбөрт багшаас оюутанд өгөх даалгаврын тухай урьдчилж тэмдэглэсэн байдаг. Иймд оюутан нь хичээл дээр яригдах сэдвээр зохих ном материалыг уншиж танилцсан байх, хичээлийг хамтдаа хэлэлцэж ярилцахад оролцох



Зураг авсан Eastern Mennonite University

Виржиния мужийн Зүүн Меннонит их сургуулийн оюутнууд лабораторийн хичээлийн үеэр

бэлтгэлтэй ирэх ёстой. Зарим тохиолдолд оюутнуудыг хэсэг бүлэгт хувааж, тодорхой нэг сэдвээр судалгаа хийх, төсөл боловсруулах даалгавар өгдөг. Ихэнхи коллежийн оюутны гарын авлагад оюутнуудыг даалгавраа цаг тухайд нь хийж, хичээлийн явцаас хоцрохгүй байхыг онцгойлон тэмдэглэсэн байдаг. Оюутны хийх ёстой даалгавар нь хэмжээний хувьд их байдаг ч нэг л хоцорвол дараа нь гүйцээд авна гэдэг бол худал болдогийг анхааруулжээ. Багшаас өгсөн даалгавар ба бусад хийх ёстой ажлыг цаг тухайд нь хийж, хичээлийн явцаас хоцрохгүй байх нь амжилтанд хүрэх шилдэг аргын нэг гэж үздэг.

- Оюутан нь бие даалтын ажил, даалгавраа цаг тухайд нь өгч шалгуулж байх ёстой. Товлосон цагаас хоцроох нь дүн хасагдахад хүргэдэг. Зарим багш цаг хугацаанд нь хураалгаагүй бие даалтын ажил, судалгааны төслийг хүлээж авахаас шууд татгалзаж, ямар нэгэн тайлбар, шалтгаан тоочихыг сонсохыг хүсдэггүй.
- Оюутан нь хичээлд идэвхитэй оролцох үүрэгтэй байдаг. 200-гаас илүү тооны оюутантай лекцийн үеэр багш сурагчдын хоорондох харилцан ярилцлага хязгаарлагдмал байж болно. Харин цөөн тооны сурагчтай семинар дадлагын хичээлийн үеэр хичээлийн сэдэв ярилцах явцад идэвхитэй оролцох нь хичээлийн дүнд шууд нөлөөлнө. Оюутан нь багшийн асуултанд хариулахаас гадна өөрөө асуулт асууж чаддаг байх ёстой. Оюутныг үзсэн хичээлээ бүрэн ойлгож эзэмшихийн зэрэгцээ тухайн хичээлийн талаар өөрийн гэсэн ойлголт, байр суурьтай болгох нь хичээлийн нэг гол зорилго юм. Өөрөөр хэлбэл, оюутан нь хичээлийг бүрэн ойлгож эзэмшихээс гадна тухайн сэдэв, холбогдох салбараар өөрийн үзэл бодлыг баяжуулан хөгжүүлж илэрхийлдэг, өөрийн байр суурийг хамгаалж чаддаг болсон байх учиртай.

Бакалаврын зэрэг буюу дээд боловсрол эзэмшихээр сурч буй оюутан нь сонгосон хичээлээ олон хэлбэрээр сурч болохоос алийг нь шилж авах нь зүйтэй вэ? Нэг хичээл нь хэд хэдэн арга хэлбэрээр заагдах тохиолдол байдаг. Эхний жилд сурагч

нь 100 буюу түүнээс илүү тооны оюутан бүхий лекцийн хэлбэрийг сонгох нь цөөнгүй байдаг. Ийнхүү хичээлийг лекцийн хэлбэрээр сурахад маш их хэмжээний материал унших болдог ба оюутан нь өөрийн тэмдэглэлийг тун сайн хөтлөсөн байх ёстой

СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

A НУ-д дараах сургалтын үнэлгээг хамгийн А өргөнөөр хэрэглэдэг:

A = 4

B = 3

C = 2

D = 1 /АНУ-ын үнэлгээ/

F = 0 Огт тэнцээгүй гэсэн үг, зарим тохиолдолд

E гэдэг

Багш нар оюутнуудаа дараах үнэлгээгээр ялгаж тэмдэглэх нь түгээмэл байдаг:

I = Бүрэн биш / бүрэн гүйцэт оюутан болоогүй/

W = Сургуулиас гарсан

WU = Албан бусаар гарсан

Audit = Сонсогч /Бусад оюутны адил

хичээлд сууж даалгавар хийнэ, гэхдээ

дүн, кредитын оноо авахгүй/

Pass / Fail = Шалгалт Тооцсон /Тооцоогүй

буюу Өгсөн/ Унасан /Оюутан нь үүнээс өөр

дүн авахгүйгээр хичээлд сууж байгаа/

Pass No Credit = Шалгалт өгнө гэж

эсвэл кредит цуглуулахгүйгээр хичээлд

суух оюутныг ийнхүү тэмдэглэнэ.

Багш бүр зааж буй хичээлээрээ оюутны сурлагыг үнэлж эцсийн дүн гаргахад өөрийн гэсэн үнэлгээний шат, аргачлалыг гаргаж хэрэглэдэг.

Багш нар эхний хичээл дээрээ оюутнууддаа энэхүү

дүн, үнэлгээний шат, аргачлалаа танилцуулдаг,

мөн заах хичээлийн хөтөлбөрт оруулсан байдаг.

Түүнчилэн ихэнхи багш нар явцын шалгалт,

шинжилгээ, судалгааны буюу бие даалтын ажлыг

хэрхэн үнэлэх тухайгаа танилцуулдаг. Жилийн

эцсийн дүн зөвхөн явцын шалгалт буюу бие

даалтын ажлын үнээс хамаарч гарна гэдэг бол

тун ховор байдаг. Эцсийн дүнг, маш олон зүйлийг

хамтад нь авч үзэж байж /%/ хувиар гаргаж

дүгнэдэг. Эдгээрийн заримыг доорх жагсаалтаас

харж болно. Үүнд:

- Анги танхимд хичээлийн явцад идэвхитэй оролцсон эсэх
- явцын шалгалт, хяналтын ажлуудын дүн
- өвлийн улирлын шалгалтын дүн
- жилийн эцсийн шалгалтын зүн
- жилийн эцсийн шинжилгээ судалгааны ажил, бүтээлийн дүн



байдаг. Лекцийн үеэр хэд хэдэн тест шалгуурын материал орж ирдэг. Цөөн оюутантай хэсэг бүлэгт face-to-face (F2F) гэгдэх нүүр тулан учран хамтарч ажиллах буюу Вэб дээр тулгуурлан ажиллахыг оюутнуудаас шаардаж болох юм.

Гэхдээ ихэнхи тохиолдолд хичээлийг 30-40 оюутнаас бүрэлдсэн анги танхимаар заадаг ба ийм үед оюутнууд хичээлд идэвхитэй оролцох нь нэн чухал байдаг. Анги дэвших бүрийд ангийн хэмжээ багасч, зарим хичээл нь 10 буюу түүнээс цөөн оюутнуудтай болж, семинарын хэлбэрээр явагддаг. Давтан хэлэхэд, ийнхүү цөөн оюутнаас бүрэлдсэн ангид хичээлийн явцад идэвхитэй оролцож суралцах нь оюутны хувьд нэн чухал байдаг.

Хичээлийн бусад хэлбэр нь лабораторийн хичээлүүд байж болно. Голдуу нарийн шинжлэх ухаан, тоо математикаар туршилт шинжилгээ хийх зэрэгт ийм хэлбэрийг сонгоно. Дүрслэх урлагийнхны хувьд хичээлийн зонхилох хэсэг студид явагдаж, тэнд хичээлийн концепцийг судлаж төсөл дээр ажиллана. Түүнчилэн бүжиг, жүжиг, дуу ба хөгжмийн мэргэжил эзэмшигчдийн хичээлийн дийлэнхи хэсэг нь практик ба биет тоглолт дээр суурилж явагдана.



Жонсон С.Смитын их сургуулийн гэрэл зураг

Хойт Каролина-д байдаг Жонсон С.Смитын их сургуулийн оюутны дотуур байрны нэгэн өрөө - энд унтаж амрах, хичээлээ хийх зэргээр чөлөөтэй амьдарч болно.

Зарим хичээлийг сурагч бие даах байдлаар эзэмшиж болно. Ингэсэн тохиолдолд багштайгаа урьдчилан уулзаж, семестрын явцад сурагчийн зүгээс хийх ёстой бие даасан судалгаа, бие даалтын ажил зэргийг хийж багшдаа шалгуулах, багштайгаа уулзаж ярилцах, зөвлөлгөө авах цаг хугацааг товлож, тухайн хичээлийг эзэмших талаар урьдчилсан зураг төлөвлөгөө гаргаж авна.

Сampus буюу оюутны хотхонд нь оюутнаас F2F буюу нүүр тулан нэг ангид сууж суралцах эсвэл Вэб сайтаар дамжуулан зайн сургалтаар сурах хоёр хэлбэрээс алийг нь сонгохыг шаарддаг болсон нь улам түгээмэл болж байна. Оюутнууд хичээлийн зарим нэгийг ангид сууж сурах, бусдыг нь Вэбээр бие даан сурахаар сонгодог болсон нь ердийн үзэгдэл болоод байна. Оюутнуудаас нэг нь ч зайн сургалтын хэлбэрийг сонгоогүй байхад багш нар нь нэмэлт мэдээлэл, даалгавар өгч, оюутныг мэдээллийн шинэ эх сурвалж руу чиглүүлэн сурч боловсроход нь

Веб-ийг өргөн хэрэглүүлэх нь бараг моод болсон гэмээр. Иймд оюутан нь тухайн сургуулийн Вебд суурилуулсан хичээлийн функционал хэрэглээг сайн эзэмшиж сурсан байх ёстой.

Бакалаврын зэргээр сурч буй зарим оюутан сургалтынхаа хөтөлбөрийн дагуу дадлагын ажил хийдэг. Энэ нь оюутны анги танхимд сурч мэдсэнээ амьдралын жинхэнэ бодит байдалд туршин үзэж, мэдлэгээ улам төгс болгоход зориулагдсан юм. Мөн сонгосон мэргэжлийнхээ дагуу ирээдүйд ажиллах салбараа зөв сонгосон эсэхийг таньж мэдэхэд оюутанд өөрт нь тус болдог.

Ихэнхи тохиолдолд сурч буй мэргэжлийнх нь дагуу оюутнуудыг компани, бизнесийн байгууллагуудад дадлага хийлгэдэг. Дадлагад кредит цаг тооцогдох тохиолдолд оюутан нь дадлагын хажуугаар ангийн хурал, уулзалтанд тогтмол оролцож дадлагын ажлынхаа талаар харилцан санал бодлоо солилцох шаардлагыг тавьдаг. Дадлага нь цалинтай байж болох хэдий ч ихэнхи тохиолдолд дадлагын ажлыг цалингүйгээр хийдэг эсвэл хамгийн багаар тооцсон санхүүгийн нөхөн олговор авдаг. Зарим салбарт, жишээ нь инженерчлэлийн хувьд үйлдвэрийн дадлагыг зуны амралтын цагаар хийхийг санал болгодог. Зуны дадлагын ажилд коллежийн кредит тооцогддоггүй.

Сургалтын өөр нэг сайн арга хэлбэр нь сургалтын хөтөлбөрт нийгэмд үйлчлэх хичээлийг суулгаж өгөх буюу оюутнуудаар сургалтын хөтөлбөрийн дагуу нийгэмд тустай хөдөлмөр хийлгэхэд оршино. Энд нийгмийн аль нэг онцлог хэсэгт амьдарч буй хүмүүсийн дунд үүсэн бий болсон бэрхшээл,



Зураг авсан Вейд Братон, Хойд Каролинагийн их сургуулийн гэрэл зураг

Шарлотт хотод байдаг Хойд Каролинагийн их сургуулийн том танхимд бизнесийн ангийн оюутнууд лекц сонсож байна. АНУ-ын сургуулиудын ихэнхи нь ийм дугуйрсан хэлбэртэй том танхимуудтай.

эдрээтэй асуудал маргааныг таслан шийдвэрлэх, тэдгээр хүмүүст тус хүргэхийн тулд анги танхимд сурч мэдсэнээ амьдралд хэрэгжүүлэх сайхан боломж оюутнуудад гардаг. Нийгэмд тус хүргэхээс гадна ийнхүү ажиллах нь оюутнуудад иргэний үүргээ ухамсарлан мэдрэх, цаашилбал ардчилал, иргэншлийн тухай ойлголттой болоход нь тус болдог.

АНУ-ЫН КОЛЛЕЖИ, ИХ СУРГУУЛИУДЫН СУРГАЛТЫН ӨРТӨГ



Зураг авсан Линда А. Сисеро, Станфорд Ньюс Сервис агентлагийн гэрэл зураг Төгсөгч оюутнууд сургуулийн төгсөлтийн баяраар “Ээж, аав та хоёртоо баярласан шүү” гэж томоор бичсэн тууз барин алхаж байгаа нь хүүхдүүд нь ээж аавынхаа ач тус, буянд сургуулиа төгсч мэргэжилтэй болсоныг ойлгож ухамсарлаж байдагийг харуулж байна.

Ихэнх Америк оюутнуудын хувьд, олонхи нь хэд хэдэн эх үүсвэрээс хөрөнгө мөнгө цуглуулж байж сургалтын төлбөрөө төлдөг. Үүнд эцэг эхийн тусгайлан хуримтлуулсан хадгаламж, зээл, буцалтгүй тусламж, ажил хийж олох буюу олсон цалин зэрэг ордог. Гадаадын оюутнуудын хувьд энэ аргаар сургалтын төлбөрөө төлөх нь тэр бүр боломжгүй байдаг хэдий ч санхүүгийн дэмжлэг тусалцаа хаанаас хэрхэн авч болох талаархи санал зөвлөгөөг энэ өгүүлдэд тусгалаа

АНУ-д коллеж буюу их сургуульд суралцахад төлбөр маш өндөр байдаг. Нэр хүндтэй их сургуульд 4 жил суралцахад сургалтын төлбөр нь 50 мянга орчим ам.доллар байдаг ба үүнд байр, унаа, ойр зуурын бусад зардал ороогүй болно. Эдгээр их сургуулиудаас дутахгүй чанартай боловсрол олгодог боловч төлбөр арай багатай коллежиуд бас байдаг. Дөрвөн жилийн сургалттай коллежиудын нэлээд нь сургалтын жилийн төлбөрт хамгийн багаар тооцоход 10 мянган ам.доллар авдаг. Мөн коллежиудын ихэнх нь жилд 20-30 мянган ам.долларын төлбөртэй байдаг. Америк айл өрхийн хувьд хамгийн их зардал гаргадаг зүйл бол хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэх явдал юм.

Ихэнхи айл өрх хүүхдийнхээ сургалтын төлбөрийг хүүхэд төрсөн цагаас нь хуримтлуулж эхлэдэг ба зарим муж улсад иргэддээ хүүхдийнхээ сургалтын мөнгийг хуримтлуулахад нь дэмжлэг үзүүлсэн урамшуулалтын программ гаргаж тусалдаг.

Сургалтын төлбөр хичнээн өндөр байсан ч сургалттай холбогдон гарах бусад зардлыг бүхэлд нь агуулдаггүйг тэмдэглэх нь зүйтэй. Байр, ашиглах тоног төхөөрөмж, багш нарын цалингийн фонд зэрэг нь улам өндөр үнэтэй болж байгаагаар гадна сургуулиуд сүүлийн үеийн технологи ашигладаг болсноор лаборатори болон бусад нарийн мэргэжлийн сургалтын үнэ өртгийг улам өндөр болгодог. Их сургууль, коллежиуд нь төрөл бүрийн сан, корпораци, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс гадна орон нутаг, муж улс, холбооны засгийн газруудаас байнга дэмжлэг тусалцаа хүсч байдаг.

Тэглээ гээд ч ирээдүйтэй сайн оюутан хүртэл сургалтын төлбөрөө төлөх талаар бэрхшээлтэй

тулгардаг. Оюутан нь дунд сургууль буюу коллежид ажил хийж олсон мөнгөөрөө сургалтын бусад зардал буюу ном, унаа, байрны зардлыг төлж болно. Коллежиуд нь оюутнуудад амьдарч сурах зардлаа олохын тулд сургуулийнхаа хотхонд буюу тухайн дүүрэг районд ажил олоход нь тусалдаг. Дүүргийнхээ коллежиудад насанд хүрэгчдийг хичээлийн бус цагаар орой буюу долоо хоногийн эцсээр Бямба, Ням гарагуудад ихэвчлэн ажиллуулдаг нь тун тохиромжтой байдаг. Түүнчилэн бүтэн буюу хагас өдрөөр явагдах сургалтыг бүтэн өдрийн буюу цагийн ажилтай хослуулдаг нь сайн талтай. Дэлхийн II дайнаас хойш цэргийн алба хаасан америк залуучуудад дээд боловсрол эзэмшихэд нь санхүүгийн туслалцаа үзүүлж байх тухай хууль гарсан нь шинэлэг зүйл болсон. Урьд өмнө цэргийн алба хаасан ч цэргийн ахмад дайчид ийм боломж эдлэж чаддаггүй байсан ажээ.

Эцэг эх, гэр бүлийн хуримтлал, цуглуулсан мөнгөнөөс гадна сургалтын төлбөрийг төлөх өөр хоёр чухал арга байдаг нь нэгд банкны зээл авах, хоёрт “грант” буюу засгийн газар, сургууль, аль нэг байгууллагаас тэдний шалгуурыг давсан оюутанд суралцахад нь олгодог тэтгэлэг юм. Зээлийг эргүүлж төлдөг, чингэхдээ хүүтэйгээр эргүүлж өгнө. Оюутнуудын хувьд зээлийн хүү нь бусад төрлийн зээлтэй харьцуулахад бага байдаг. Сургуулиа төгсөөд ажиллахад эхний хэдэн жил энэхүү зээлийг чадан ядан төлөхөд зарцуулагдах нь нэгэн тогтсон жишиг болоод байна. Грант нь оюутны цалинг оролцуулдаг ба энэ нь нэг ёсондоо бэлэг хандив болгож өгсөн мөнгө байдаг тул эргүүлэн төлөх шаардлагагүй байдаг. Ийнхүү грант авахын тулд оюутан нь тухайн байгууллагуудаас тавих шаардлагыг хангасан байх учиртай. Жишээ нь онцсайн сурдаг, дундаж дүнгээрээ дээгүүр түвшинд байх, эсвэл ар гэрийн гачигдалтай гэдгээ нотлосон байх. Оюутны цалин гэж оюутан нь хичээлийн хажуугаар ажил хийж олсон мөнгө буюу онцсайн сурдаг, биеийн тамирын аль нэг төрлөөр амжилт гаргасан, мөн иргэний үүргээ онцсайн биелүүлсэн буюу ар гэрийн гачигдалтай гэдгээ нотлож чадсан оюутанд олгодог мөнгийг хэлнэ. Ийнхүү грант олж авах нь тийм ч амар зүйл биш юм. Нэн ялангуяа тийм мөнгийг хаанаас хэрхэн олж авахыг мэдэж

хайх, грант өгөх бололцоотой тийм байгууллагуудад хандаж олон төрлийн анкет бөглөх ёстой байдаг нь зарим үед оюутан болон ар гэрийнхнийг нь зүрх алдахад хүргэдэг. Коллеж, дунд сургуулиуд ба зарим байгууллагууд нь оюутан сурагчдад ийнхүү санхүүгийн эх үүсвэр хайж олоход нь туслалцаа үзүүлдэг.

Энэ бүхэн АНУ-д суралцахыг хүсч буй гадаад оюутны хувьд бүр ч аймшигтай юм шиг санагдах нь гайхаад байх зүйл бишээ. Гадаадын зарим оронд дээд боловсролыг бага зардлаар буюу үнэгүй эзэмшиж болдог. Сургалтын төлбөр нь өндөр байлаа гэхэд ямарчиг л байсан АНУ-ынхаас хамаагүй бага байдаг. Дунд сургуульд байх цагаасаа эхлэн дээд боловсрол эзэмших мөнгөө хуримтуулж аваагүй боловч АНУ-ын коллежид суралцахыг хүсч буй гадаадын оюутанд ямар арга зам байж болох вэ?

“АНУ-д уулзъя” нэртэй Э-сэтгүүл, 2005 оны есдүгээр сар.

[<http://usinfo.state.gov/journals/itsp/0905/ijpe/ijpe0905.htm>] гэсэн хаяг бүхий энэ э-сэтгүүлд АНУ-д зорчих оюутнуудад холбогдох олон асуудлаар хариу өгсөн байдаг. Нэн ялангуяа оюутны визийн талаар тайлбарласан байдаг. Нанси В.Кетекү нь Гана улсын Аккра хотод Төрийн департаментад Африкийн орнуудын иргэдэд боловсролын асуудлаар зөвлөлтөө өгөх зохицуулагчаар ажилладаг ба “АНУ дахь дээд боловсрол, санхүүгийн асуудлууд” гарчигтай өгүүлэл бичсэнийг та бүхэн уншиж танилцахыг бид санал болгож байна. Ер нь энэ э-сэтгүүлийг бүхэлд нь уншиж танилцаарай. Дээрхи өгүүлэлийн гол гол хэсгүүдээс дурдахад:

Та АНУ-д коллежид суралцахыг хүсч байна уу? Америкт дээд боловсрол эзэмших нь засгийн газар нь боловсролын системээ төвлөрсөн аргаар хянаж

байдаг зарим оронтой харьцуулахад асар өндөр өртөгтэй байдгийг та магадгүй анзаарсан байх. Нөгөө талаас, АНУ-д олсон дээд боловсрол нь сургалтын төлбөрт төлсөн мөнгө, тэр их хөрөнгө оруулалтын ач тусыг маш өндрөөр хариулдаг тул эцсийн бүлэгт дүндээ дүн болдогийг та бас анзаарсан байх гэж найдаж байна.

АНУ-д дээд боловсрол эзэмшихэд тань төлбөр санхүүгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох талаар зарим нэгэн санааг хэлэхэд:

- EducationUSA centers буюу АНУ-ын боловсролын төвүүд АНУ-ын Төрийн Департаментын дэмжлэгтэй ажилладаг бөгөөд танд шаардлагатай албан ёсны мэдээллийг өгөх газар юм. Таны оршин суугаа газарт газарзүйн хувьд хамгийн ойр байгаа АНУ-ын боловсролын төвийг та <http://www.educationUSA.state.gov/centers.htm> сайтаас олж болно.
- Зөвлөлгөө өгдөг энэхүү төвөөс та “Коллежиудын гадаадын оюутнуудын гарын авлага” ба Петерсоны бичсэн “АНУ-ын коллеж, их сургуулиудад элсэх тухай” гэсэн хоёр товхимолыг олж уншаарай.
- АНУ-ын Засгийн газрын мэдээллийг харахад АНУ-ын засгийн газрын ихэнхи хөтөлбөрүүд нь Бакалавраас дээгүүр зэрэгт буюу дипломын дараахь сургалтанд хамрагдахыг хүсэгчдэд анхаарлаа илүү хандуулсан байдаг. АНУ-ын ЭСЯ-ны Олон Нийттэй Харьцах Хэсэг буюу Public Affairs Section (PAS) ба АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг буюу US Agency for International Development (USAID) нь засгийн

газар хоорондын хоёр талын гэрээг үндэс болгон энэ асуудлыг зохион байгуулдаг.

- Scholarship agencies буюу сургалтын төлбөр, оюутны сургалтын тэтгэлгийн мөнгө олоход тусладаг олон агентлагуудаас болгоомжлох нь зүйтэй! Хуурамч агентлагууд маш олон шүү. Сургалтын төлбөрийг төлөхөд хаанаас ямар тусламж авах талаар бодит мэдээлэл өгч чадна гээд хүмүүсийг итгэл төрүүлэхүйц гоё сайхнаар ятгаж, үйлчилгээндээ төлбөр нэхдэг энэхүү хуурамч агентлагуудаас туйлаас болгоомжлох хэрэгтэй.


СУРГАЛТЫН ТӨЛБӨР, ЗАРДАЛ БА КОЛЛЕЖИЙН НИЙТ ӨРТӨГ ХОЁРЫН ХООРОНДОХ УЯЛДАА

Сургалтын төлбөр нь АНУ-д боловсрол эзэмшихэд шаардлагатай санхүүгийн хөрөнгө оруулалтын дөнгөж эхлэл нь юм. Коллежийн нийт өртөгт сургалтын төлбөр ордог – зарим сургууль сургалтын төлбөрийг оюутан бүрээс хичээлийн жил тутам төлөхийг шаарддаг бол зарим төлбөрийг үзэж буй хичээл бүрээр төлүүлдэг. Сургалтын төлбөрөөс гадна оюутан нь байр, ном, хичээлийн бусад материал, хоол, эрүүл мэндийн даатгал, эмч, сувиллагчийн үйлчилгээ, өдөр тутмын унааны зардал, машины зогсоолын төлбөр, утас холбоо, интернет ашигласны мөнгө зэргийг өөрөө хариуцан төлөх болдог. Үүнээс гадна гадаад оюутан нь тогтсон жишгийн дагуу тухайн сурч амьдарч буй муж улсын иргэн биш учраас илүү өндөр татварыг нийтийн боловсролын байгууллагуудад төлөх шаардлагатай болдог.

Цаг хугацааны хөрөнгө оруулалт нь харгалзан үзэх зүйлсийн нэг яах аргагүй мөн. Суралцах хугацаанд оюутан хүн орлогын хэмжээ эрс багасдаг. Ажил олдсон ч долоо хоногт цөөхөн цагаар хийдэг учир авдаг цалин мөнгө нь ажлын бүтэн өдрөөр ажиллагсдаас бага байдаг. Дараагийн хуудаснаас оюутнууд ба ар гэрийнхэн нь сургалтын нийт өртөгийн талаар бүрэн ойлголт авах болно.

КОЛЛЕЖИД СУРАЛЦАХ ОЮУТНЫ ЗАГВАРЧИЛСАН ТӨСӨВ

Зардлын нэр	Үнэ	Хичээлийн улирлын тоо	БҮГД
Сургуульд бүртгүүлэхэд			
Элсэлтийн шалгалтын үнэ			
Сургалтын төлбөр			
Оройтож бүртгүүлсний төлбөр			
Байрны зардал			
Хоолны зардал			
Ном, бусад материал			
Машины зогсоол			
Машины даатгал			
Машины бусад зардал			
Хотын тээвэрт зарах мөнгө			
Байрнаас сургууль хүртэл явахад тээврийн зардал			
Оюутны үнэмлэх авахад			
Оюутны үнэмлэхийг дахин шинээр авахад			
Биеийн тамирын төвийн төлбөр			
Бичгийн ажлын төлбөр			
Номын сангийн хураамж			
Канон хэрэглэсний төлбөр			
Микрофльм хэрэглэсний төлбөр			
Чөлөөт цагаа өнгөрүүлэхэд гарах зардал			
БҮГД			



САНХҮҮГИЙН ТУСЛАМЖ АВАХ ЗАРИМ БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭРҮҮД

Мартина Шульц

Мартина Шульц нь Германы Гамбург хотод АНУ-ын Ерөнхий Консулын газарт соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн ба Гамбург хотын Америкийн төвийн зөвлөх зохицуулагчаар ажилладаг бөгөөд энэхүү өгүүлэлдээ гадаадын оюутнууд, нэн ялангуяа бакалавраас дээш зэрэг эзэмшихээр суралцахыг хүсэгчдэд санхүүгийн дэмжлэгийн талаар хаана хандаж болох тухай зөвлөлтөгөө өгсөн байна.

Жил бүр 500 мянган гадаадын оюутан АНУ-ын коллеж, их сургуулиудад элсэн суралцах хүсэлтээ гарган амжилтанд хүрдэг. Олон улсын боловсролын институтын үзэж байгаагаар тэдгээрийн 67% нь Америкт суралцах зардлаар гэрийнхнээрээ төлүүлэхээр болдог. Мөн олон оюутны хувьд санхүүгийн дэмжлэг олох асуудал нь АНУ-д суралцах эсэхийг нь шийдвэрлэх гол хүчин зүйл болдог. Гадаадын оюутан АНУ-д нэг хичээлийн жилийн хугацаанд амьдарч сурахад дундажаар 16-46.5 мянган ам.доллар зарцуулах ёстой болдог.

ГАДААДЫН ОЮУТАН НЬ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙГ ХААНААС АВДАГ ВЭ?

Оюутны өөрөө хариуцах төлбөрийн мөнгөн дээр нэмэрлэж санхүүгийн дэмжлэг авах гол эх үүсвэрүүд нь АНУ-ын коллеж, их сургуулиуд нь байдаг. Тэд оюутандаа сургалтын төлбөрийн 23 хувийг чөлөөлж тусламж үзүүлдэг бол мөн тухайн орон нутгийн засгийн газар буюу их сургуулиуд төлбөрийн 2,4%-ийн хөнгөлтийг олгодог. Бакалаврын зэрэгтэй боловсрол эзэмших ба магистр, докторын сургалтанд хамрагдах хоёрыг харьцуулвал төлбөрийн хувь тэс өөр байдаг. Бакалаврын зэргээр суралцагч гадаадын оюутнуудын зөвхөн 10 хувь нь тухайн коллежоос санхүүгийн туслалцаа авдаг байхад магистр, докторын зэрэгт суралцагсдын 41 хувь нь суралцаж буй их сургуулиасаа дэмжлэг авсан байдаг. Тэдгээр суралцагсдаас олон хүн докторын болон эрдэм шинжилгээний институтад эрдэм шинжилгээний туслах ажилтан, туслах багшаар ажилладаг. Түүнээс гадна магистрын сургалттай харьцуулвал Доктор буюу PhD-гийн сургалтанд хөрөнгө мөнгийг

хамаагүй илүү хувиар төлөвлөсөн байдаг. Нийгмийн болон хүмүүнлэгийн ухааны сургалтанд зориулсан төсвөөс илүүтэйгээр шинжлэх ухааны нарийн мэргэжлийн сургалтанд хөрөнгө мөнгийг илүү төлөвлөсөн байх жишээтэй. Түүнчилэн онолын буюу судалгааны чиглэлээр суралцахад төлөвлөсөн хөрөнгө мөнгө нь дан мэргэжил эзэмшихэд зориулсан төсвөөс илүү байдаг. Дашрамд тэмдэглэхэд, сурч буй сургуулиасаа санхүүгийн тусламж авах боломж нь хоёрдахь жилээсээ нэмэгддэг.

АНУ-ААС ЯМАР ТӨРЛИЙН САНХҮҮГИЙН ТУСЛАМЖ АВЧ БОЛОХ ВЭ?

Бакалаврын зэргээр суралцах гадаадын оюутнууд сургалтын төлбөрийн оюутны цалингийн нэг хэсгийг даалгуулах талаар хувийн коллеж, их сургуулиудад хандаж болно. Мөн гадаадын оюутнууд биеийн тамир, спортын аль нэг төрлийг гарамгай эзэмшсэн бол сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөхөөс гадна оюутны зээл авах эрхтэй байдаг. Бакалавраас дээш зэргээр суралцах оюутнууд багшлах, судалгааны болон захиргааны туслах ажилтнаар ажиллах хүсэлт гаргаж болно. Түүнчилэн хувийн болоод улсын их сургуулиудаас мэргэжил дээшлүүлэх зардал болон оюутны тэтгэлэг авах талаар хандаж болно. Мөн эдгээр оюутнууд нь оюутны хөнгөлөлттэй зээл авах талаар хүсэлт гаргах боломжтой байдаг.

САНХҮҮГИЙН ТУСЛАМЖ АВАХ ТАЛААР ХЭРХЭН АМЖИЛТТАЙ ХӨӨЦӨЛДӨХ ВЭ?

Санхүүгийн тэтгэлэг буюу тусламж авах талаар болж өгвөл хичээл эхлэхээс 15-18 сарын өмнө эрт хөөцөлдөж эхлэх нь зүйтэй. Өөрийн орны засгийн газар, их сургуулиудаас олгодог сургалтын тэтгэлэгийн талаар судлаж эртхэн өргөдлөө өгөх хэрэгтэй.

Судалгаа хийхдээ EducationUSA зөвлөх төвийн Вэб сайтаар зочлон санхүүгийн тусламж олгох боломж нь хэр их байдаг тухай АНУ-ын коллеж, их сургуулиудын талаар бичигдсэн мэдээлэл бүхий тусгай материалуудыг олж, тэдгээртэй танилцах нь зүйтэй. Түүнчилэн интернэтэд орж, 4-6 сургуулиудыг сонгож, тэдгээрийн талаар аль болох тодорхой мэдээлэл олж авахыг хичээ. Хэрэв та бакалавраас дээш зэргээр суралцах гэж байгаа бол Google-ын тусламжтайгаар суралцах сургуулийнхаа багш профессоруудын тухай тус сургуульд өргөдөл өгч хандахаасаа өмнө уншиж урьдчилан танилц. Багш нар шинэ оюутан ассистентийг элсүүлэх асуудлыг шийдвэрлэдэг тул таны элсэлтийн материалыг уншиж танилцахаас өмнө танаас захиа авч таны тухай урьдаас сонсож мэдсэн байх нь давуу талтай.

Санхүүгийн тэтгэлэг гуйхаас бүү ичиж зов. Санхүүгийн дэмжлэг хүсэх тухай таны анхны захидалд татгалзсан хариу ирсэн ч хоёрдахь захиагаа бичиж явуулаарай, чингэхдээ түүнийгээ онол судалгааны тэнхим буюу элсэлтийн асуудал эрхэлсэн албаны тодорхой хүний нэрийг зааж хаяглаарай. Хэрэв таны хүсэлтэд татгалзсан хариу өгсөн бол учир шалтгааныг нь лавлаж утасдаарай. Ингээд дараа жил нь дахин хүсэлтээ гаргахдаа санхүүгийн дэмжлэг хүсэх шаардлагатай байгаагаа улам тодорхой тайлбарлаж, илүү үндэс суурьтай өргөдөл бичиж хандаарай.

Гадаадын оюутнуудад олгох санхүүгийн тэтгэлгийн сан нь хязгаарлагдмал байдаг тул түүнийг олж авахад маш их өрсөлдөөнтэй байдаг. Тиймээс өрсөлдөөнд ялахын тулд юуны өмнө та өөрийгөө

сурлагаар онцсайн оюутан гэдгээ харуулж TOEFL, SAT, GMAT шалгалтанд аль болох өндөр оноо авахыг хичээж бэлдээрэй. Мөн өөрийгөө санхүүгийн хувьд огт хоосонгүй гэдгээ харуулж, нэмэлт санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай гэдгээ сайтар нотлож өгөх хэрэгтэй. Энэ байдлаа тал бүрээс нь тайлбарласан, судалсан, эмх цэгцтэй, бүрэн гүйцэд бичигдсэн элсэлтийн материал, өргөдөлөө илгээгээрэй.

Энэ өгүүлэлд тусгагдсан санал, дүгнэлт нь АНУ-ын засгийн газрын байр суурь, бодлогыг илэрхийлэхийг зориогүй болно.

АНУ НЬ ГАДААД ОЮУТНУУДЫГ ОРОН НУТГИЙН КОЛЛЕЖУУДАД СУРАЛЦАХЫГ УРЬЖ БАЙНА.

Женнифер Буркам

(Анхлан Community College Times сэтгүүлд нийтлэгдэж байсан)

Олон улсын багш нарын холбоо /хуучнаар NAFSA – National association for Foreign Student Affairs буюу Гадаад оюутны асуудал эрхэлсэн үндэсний холбоо/-ны 2005 онд болсон 57-р ээлжит бага хурал дээр Төрийн Департаментын визийн албаны дэд туслах нарийн бичгийн дарга хатагтай Жанис Жакобс хэлэхдээ, “АНУ нь Америкт суралцахыг хүсч буй оюутныг “Мориллогтун” хэмээн урьж байна, хилийн чанадад суугаа АНУ-ын дипломат төлөөлөгчийн газрууд нь оюутан ба солилцооны хөтөлбөрийн дагуу зорчих хүмүүст илүү анхаарал тавьж байх тухай удирдамж авсан” хэмээжээ. Тэр цааш нь хэлэхдээ, 2001 оны 9-р сарын 11-ний өдрийн террорист үйл ажиллагаанаас улбаалж Төрийн Департаментас визийн талаар баримтлах бодлогод зарим нэгэн өөрчлөлт гарсан хэдий ч зарим хүмүүсийн ташаа ойлгож байгаагаар АНУ-д суралцах, зорчиход визийн асуудал нь тэгтлээ давж баршгүй том даваа болоогүй билээ гэжээ. “Виз олголтонд орсон өөрчлөлтүүдийн тухай хүмүүсийн хуучинсаг ойлголт нь бодит байдлаас тэс хөндий байна”, “Гадаад оюутнуудыг олноор сургах, эрдэмдэд, бизнесийн салбарын хүмүүс, ердийн зорчигчдын харилцан солилцоог нэмэгдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх талаар Төрийн Департамент шаргуу ажиллаж байна...” хэмээн хатагтай Ж. Жакобс тэмдэглэжээ. Бага хурал дээр тавьсан “АНУ-ын орон нутгийн анхан шатны коллежуудад гадаадын оюутнуудыг суралцахыг уриалах нь Төрийн Департаментын үүрэг” гэсэн сэдэвтэй илтгэлдээ хатагтай Жакобс олон улсын боловсролд гүйцэтгэх АНУ-ын орон нутгийн коллежийн системийн үүрэг ролийн тухай ярьжээ.

Хоёр жилийн дээд боловсролын сургалттай эдгээр сургуулиудын албаны хүмүүсээс тухайн боловсролын байгууллагуудад хоёр жилээр суралцах хүсэлт гаргасан гадаад оюутнуудад виз олгохоос татгалзах нь цөөнгүй байгаа тухай асуухад хатагтай Жакобс хариуд нь Төрийн Департамент нь консулын албаны хүмүүстээ төрөл төрлийн боловсролын байгууллагуудад суралцах хүсэлтээ гаргасан бусад олон оюутнуудын хэрэгцээ шаардлагууд нь өөр өөр байдаг бөгөөд тэдгээрийг хангаж ажиллаж байх талаар анхааруулсныг дурджээ. Консулын албаны хүмүүс нь АНУ-д боловсрол эзэмших өргөн боломж байгааг санаж, оюутан бүрийн асуудлыг тус бүрт нь

авч үзэж байх тухай удирдамж авсаныг тэрээр мөн тодруулж хэлсэн байна.

Хатагтай Жакобс цааш нь хэлэхдээ, гадаад оюутнуудын визийн асуудлыг зохицуулах ажлыг шуурхай болгохын тулд 2001 оны 9-р сараас эхлэн консулын албаны орон тоог 350-аар нэмсэн бөгөөд дахин 121 орон тоо нэмүүлэх хүсэлт гаргахад хангалттай хөрөнгө мөнгийг өнөөгийн төсөвт оруулаад байна гэсэн юм.

Виз хүссэн өргөдлийн бараг бүгдийг буюу 97 хувийг- хоёр өдрийн дотор авч судлан визийг олгож байгаа. Аюулгүй байдлыг хангах үүднээс визийн өргөдлийн 2.5 нарийн шалгуураар оруулах талаар оновчтой систем нэвтрүүлсэн гэж тэрээр хэлэв. “Виз хүсэгчдийн 2,5 хувийг үндэсний аюулгүй байдлын улмаас тусгай шалгалт хяналтаар оруулах ёстой болдог ба энэхүү ажиллагааг бид нэгдсэн жигд дамжлагаар оруулдаг болсон тул эдгээр цөөн тооны хүмүүст хариуг бусдын адил нэг их удаалгүй өгөх боломжтой болсон. Жилийн өмнө эдгээр тохиолдлуудыг нарийн технологи ашиглан судлаж хянахад 74 хоног шаардлагатай байсан бол одоо үүнд дунджаар 14 хоног зарцуулж байна. Цаашид бид энэхүү үйл ажиллагааг улам боловсронгуй болгож цаг хугацаа хэмнэх болно” гэж хатагтай Жакобс хэлсэн байна.

Ж.Жакобсын тэмдэглэснээр 2003-2004 оны хичээлийн жилд америкийн коллеж, их сургуулиудад 572 мянга гаруй гадаадын оюутан элсэж орсон тухай АНУ-ын Олон улсын боловсролын институтын мэдээллийн санд бүртгэгдсэн байгаа ажээ. АНУ-ын коллежид хамгийн олноор элсэн орсон нь Энэтхэг ба Хятад оюутнууд байна. Хэдийгээр АНУ-д суралцах гадаад оюутны тоо буурсан боловч бусад улс оронтой харьцуулахад АНУ нь хамгийн их олон гадаадын оюутан суралцуулдаг улс хэвээр байна.

“Бидний хамгаас их эрмэлзэж буй зүйл бол гадаадын бусад оронд АНУ-ын тухай гадаад оюутнуудыг хүлээж авах дургүй байна гэсэн худал хуурмаг ойлголтыг няцаахад оршино. Энэ бол үнэнд огт нийцэхгүй зүйл. Мускатаас эхлээд Мумбай хүртэлх гадаадын бүх оюутнууд, АНУ-д суралцахыг хүсч байгаа бол манай хаалга үүд хаалга тэдэнд хэзээд нээлттэй гэдгийг мэддэг байх ёстой” гэж тэр хэлжээ.

ГАДААД ОЮУТНЫ ЗӨВЛӨХ БАГШ ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ?



Зургийн тайлбарууд:

1. Виржиния дахь Зүүн Меннонит их сургуулийн гадаад оюутан зөвлөх багшаасаа зөвлөлгөө авч буй
2. Нигерийн түүхч Тажудин Гбадамоси нь Теннесси дэхь ЛөМуйан-Овен коллежид Фуллбрайтны цалинтай резидент-эрдэм шинжилгээний ажилтны хувиар нэг жилийн хугацаар суралцан ажиллаж байна. Тэрээр Уламжлалт Харуудын Коллежид лалын шашинтны түүх, соёл, иргэншлийн тухай яриа хийж, оюутан сурагчидтай санал солилцож байгааг тус сургуулийнхан маш таатай хүлээн авч байна.
3. Өмнөд Солонгосоос ирсэн оюутнууд Миссиссипи-гийн их сургууль дээр гадаад оюутнуудад чиглэл өгөх зөвлөлгөөнд оролцож байна. Бүтэн өдөр үргэлжлэх энэхүү арга хэмжээний үеэр гадаад оюутнуудыг бүртгэж, их сургуулийн амьдрал, орчин тойронтой танилцуулдаг юм.



Өмнө нь Гадаад оюутны зөвлөх багш нарын үндэсний холбоо гэсэн нэртэй байсан Гадаад оюутны зөвлөх багш нарын холбоо нь гадаад оюутнуудыг АНУ-д суралцах явдлыг сурталчлан дэмждэг. Энэхүү холбоо нь 2000 онд хэвлүүлэн гаргасан гарын авлагадаа Гадаад оюутны зөвлөх багшийн үүргийн тухай ийнхүү өгүүлжээ. Үүнд:

Гадаад оюутны зөвлөх багш нь АНУ-д суралцахаар ирсэн дэлхийн бүх орны оюутан сурагч, эрдмийн зэрэг эрэлхийлэгч нарт аль болох ихийг сурч мэдэхэд шаардагдах бүх мэдээллийг өгөх, зохих хөтөлбөр, үйлчилгээтэй танилцуулах зэргээр хамтарч ажиллана. Гадаад оюутнуудад тухайн сургуулийн багш, бусад ажилтантай уулзаж ярилцах бүрийд гадаад оюутны эрх ашиг, сонирхлыг хамгаална.

Гадаад оюутны зөвлөх багш нь гагцхүү гадаад оюутнуудтай ажиллаад зогсохгүй мөн өөрийн орны иргэн оюутнууд болон сургуулийн багш, ажилтан нартай хамтран ажиллана. Мөн тухайн орон нутгийн иргэд, оршин суугчид, АНУ-ын албаны хүмүүс, гадаадын засгийн газрын

агентлагууд болон АНУ-д суралцах оюутан, эрдмийн зэрэг эрэлхийлэгч эрдэм шинжилгээний ажилтан нарын сургалтын зардлыг ивээн тэтгэх олон төрлийн байгууллагуудтай хамтран ажиллана. Зөвлөх багш нар гадаадын оюутнуудыг америкийн хүлээн авагч байгууллага, хүмүүстэй холбож өгөхөд үр дүн бүхий үйл ажиллагаа явуулна.

Гадаад оюутны зөвлөх багш нь гадаад оюутны солилцооноос гарах эерэг сайн талуудыг дээдлэн, гадаад оюутан солилцон сургах явдал нь тухайн сургуулийн хамт олон, орон нутгийн оршин суургчид болон дэлхийн нийт орнуудад ашигтайгаар тусгах зорилгоор ажиллана. Зөвлөх багш нар орон орны хүмүүсийн хоорондын харилцан ойлголцох явдлыг дэмжиж ажилласнаар эрх чөлөөт ертөнцийн иргэдэд бусдыг ойлгох, бусдад нээлтэй байх ухамсраар хүмүүжин төлөвшихэд тус хүргэх болно.

Нэмэлт мэдээлэл олж уншихыг хүсвэл <http://www.nafsa.org>. вебээр зочлоно уу.

АШИГЛАСАН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

АНУ дахь их, дээд сургууль, коллежийн тухай нийтлэгдсэн зарим уншвал зохилтой материалууд

АНУ-ын Төрийн Департамент. Боловсрол ба Соёлын Хэргийн Яам/Хороо. “Хэрэв Та АНУ-д Сурахыг Хүсвэл” Цуврал, Вашингтон ДС, 2002-2003. <http://www.educationusa.state.gov/pubs.htm>

Энэхүү дэлгэрэнгүй цувралын эхний гурван товхимолыг араб, хятад, англи, франц, орос ба испани хэл дээр авч уншиж болно. Нэгдүгээр товхимолд Бакалаврын зэргийн сургалтын тухай, хоёрдугаар товхимолд Бакалавраас дээш зэргийн ба мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын тухай, гуравдугаар товхимолд Богино хугацааны сургалт, Англи хэлний сургалт, Зайн сургалт ба Коллеж, сургуулиудыг хүлээн зөвшөөрөх тухай бичсэн байгаа. Дөрөвдүгээр товхимолд “Оюутан болж явахад бэлтгэлээ хэрхэн хангах тухай буюу АНУ-д сурч амьдрахад шаардлагатай ашигтай мэдээлэл” -ийн талаар уншиж танилцаж болно. Сүүлийн товхимол хятад, англи, орос хэл дээр гарсан. <http://www.educationusa.state.gov/life/pubs.htm>

Линда Дандис Эндрюс, Коллежид эзэмших мэргэжлийг хэрхэн сонгох тухай, Нью-Йорк: МакГро-Хилл Компани, 2006 онд хэвлэгдэн гарна.

Двейн ба Вильямс Эшли, Хуан, Би нэг арга олно эс тэгвээс шинээр нэгийг олж бүтээн: Хар арьстнуудын түүхэн коллеж ба их сургуулиудад хүндэтгэл үзүүлсэн тухай, Нью-Йорк, Харпер Трейд, 2004.

Коллежуудын удирдах зөвлөл, Гадаад оюутны 2006 оны гарын авлага, Нью Йорк, хэвлэсэн газар The College Board, 2005.

Коллежуудын удирдах зөвлөл, Коллежуудын үнэ өртөгийн чиг хандлагууд, 2005. Нью-Йорк, хэвлэсэн газар The College Board, 2005. http://www.collegeboard.com/prod_downloads/press/cost05/trends_college_pricing_05.pdf

Коллежуудын удирдах зөвлөл, Оюутны тэтгэлэг тусламжийн чиг хандлагууд, 2005, Нью-Йорк, хэвлэсэн газар The College Board, 2005.

http://www.collegeboard.com/prod_downloads/press/cost05/trends_aid_05.pdf

Коллежуудын удирдах зөвлөл, “Эзэмшиж болох бүх мэргэжлийн тухай Коллежуудын удирдах зөвлөлийн гарын авлага”, Нью-Йорк, хэвлэсэн газар The College Board, 2004.

Олон улсын боловсролын аялалын стандартын зөвлөл, Олон улсын боловсролын аялал ба оюутан солилцооны хөтөлбөрийг санал болгосон жагсаалт, Александриа ВА, хэвлэсэн газар CSJET, 2005. <http://www.csiet.org/mc/page.do?sitePageId=748>

Лани Денслоу, Мэри Тинкхам ба Пэтришиа Виллер, АНУ-ын соёл иргэншлийн тухай цуврал: Америкийн амьдралын тухай танлцуулга, Вашингтон ДС, хэвлэсэн газар Олон улсын багш нарын холбоо, 2004. http://www.nafsa.org/publication_sec/international_students/u.s_culture_series

Жеймс Ж.Ф. Форест ба Филип Г. Олтбак, Дээд боловсролын тухай гарын авлага, Нью-Йорк, хэвлэсэн газар Springer, 2005. <http://www.higher-ed.org/handbook/TOC.pdf>

Жеймс Ж.Ф. Форест ба Кевин Кинсер, АНУ дахь дээд боловсролын нэвтэрхий толь, Нью-Йорк, хэвлэсэн газар, ABC-CLIO Publishers, 2002.

Бен Гесе, Орон нутгийн коллежиуд, тусгай дугаар, Дээд боловсролын түүх судар, 52-р боть, дугаар 10, 2005.10.28, хуудасны дугаар B1-B44.

Маделен Грин ба Барбара Төөрлингтон, АНУ-ын дээд боловсролын тухай товч танилцуулга, Вашингтон ДС, хэвлэсэн газар American Council on Education, 2001. http://www.acenet.edu/bookstore/pdf/2001_bref_guide.pdf

Ховард Грине, Улсын нэр хүнд бүхий анхны их сургуулиуд /The Public Ivies/, Нью-Йорк, хэвлэсэн газар Харпер Трейд, 2001.

Хар арьстнуудын түүхэн коллеж, их сургуулиуд, тусгай хэсэг, Эбони, 60-р боть, дугар 11, 2005 оны 9-р сар, хуудасны дугаар 73-130.

Бие даасан коллеж, их сургуулиуд - улсын танилцуулга, Вашингтон ДС, хэвлэсэн газар Бие даасан коллежи ба их сургуулиудын үндэсний холбоо /NAICU/, 2004. <http://www.naicu.edu/pubs/2004Profile.pdf>

Бие даасан коллежи ба их сургуулиудын үндэсний холбоо /NAICU/ болон Бие даасан дээд боловсролын сангийн хамтын ивээн тэтгэлгээр хэвлэгдсэн энэхүү товхимол нь оюутан, багш нарын талаар тоо баримт, танилцуулга агуулсан юм.

Олон улсын боловсролын институт, Америк дахь боловсролын санхүүжилтийн тухай цуврал: Америк дахь боловсролын санхүүжилт: Европын орны иргэдэд сургалтын тэтгэлэг олгох тухай лавлах, Нью-Йорк ИЕ, 2004. <http://www.iiebooks.org/funforunstat.html>

Олон улсын боловсролын институт, Америк дахь боловсролын санхүүжилтийн асуудлын тухай цуврал: Америк дахь боловсролын санхүүжилт: Латин Америкийн орны иргэдэд Магистр, Докторын зэрэг эзэмших боломжийн тухай, Нью-Йорк ИЕ, 2004. <http://www.iiebooks.org/funforunstat.html>

Жорж Калмар, Америкийн дунд сургууль, коллежи, их сургуулиудад суралцах оюутны лавлах, Санта-Моника, Калифорни, Олон улсын боловсролын алба [205]. <http://www.ies-ed.com/>

Алисон Реймонд Ланье, АНУ-д амьдрах нөхцөлийн тухай 6 дахь хэвлэл, Yarmouth, ME: хэвлэсэн газар Intercultural Press, 2004.

Жон Латимер, АНУ-ын Коллеж, их сургуулиудад хэрхэн элсэх тухай, 1998: Гадаад оюутанд зориулсан гарын авлага, Лоренсвилл, Нью-Жерси, хэвлэсэн газар Peterson's, 1997.

Сара Липка, Фуллбрайттын сан Лалын ертөнцтэй холбоо тогтоож буй тухай Дээд боловсролын он цагийн бичлэг, 52-р боть, дугаар 11 2005.11.04, хуудасны дугаар А47-А49.

Энэ жилийн Фуллбрайттын шагналтан 3 хүний тухай танилцуулга ба хүснэгтүүдийг оруулсан.

Нээлттэй үүд хаалга: Гадаад оюутны хөдөлгөөний талаарх тоо баримт /Open Doors: Statistics on International Student Mobility/ Нью-Йорк, хэвлэсэн газар Олон улсын боловсролын институт, 2005.

Зарим хүснэгтийг дараах сайтаас харж болно.

Нээлттэй үүд хаалга: Олон улсын боловсролын харилцан солилцооны талаарх тайлан <http://opendoors.iienetwork.org/>

Наоми Шафер Рили, Бурханы тухай коллежид: Шашны коллежууд ба миссионеруудын үе Америк улсыг хэрхэн өөрчилж буй, Нью-Йорк, хэвлэсэн газар St. Martin's Press, 2005.

Шелдон Ротблатт, Орчин цагийн хүмүүнлэгийн ухаан: Либерал боловсрол дахь харьцуулсан ба түүхэн тусгал, Вашингтон ДС, хэвлэсэн газар Америкийн Коллеж, их сургуулиудын холбоо, 2003.

Майкл Смити, Сидни Л. Гринблатт ба Алиса Эланд, АНУ-ын соёлын цуврал: Америкийн анги танхим дахь соёл, Вашингтон ДС, хэвлэсэн газар NAFSA: Association of International Educators, 2004. http://www.nafsa.org/publication_sec/international_students/u.s._culture_series_1

Америкийн хувийн коллеж, их сургуулиудын талаар сонин хачин 12 тоо баримт, Вашингтон ДС, хэвлэсэн газар Бие даасан коллеж ба их сургуулиудын үндэсний холбоо /NAICU/, 2003. <http://www.naicu.edu/pubs/NAICU12FactsNew.pdf>

АНУ-ын Төрийн Департамент, Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн хороо, АНУ дахь орон нутгийн коллежууд, Америкийн нийгэм ба үнэт зүйлс АНУ-ын электрон сэтгүүл, 7-р боть, дугаар 10, 2002 оны 6-р сар, хуудас 26. <http://www.usinfo.state.gov/journals/itsv/0602/ijse/ijse0602.htm>

АНУ-ын Төрийн Департамент, Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн хороо, “АНУ-д уулзъя” АНУ-ын электрон сэтгүүл, Гадаад бодлогын хэлэлцэх асуудал, 10-р боть, дугаар 2, 2005 оны 9-р сар, хуудас 52. <http://www.usinfo.state.gov/journals/itsv/0905/ijpe/gough.htm>

АНУ-ын Төрийн Департамент, Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн хороо. “АНУ 2005 онд: Бид өнөөдөр ямар хүмүүс болоод байна” Америкийн нийгэм ба үнэт зүйлс АНУ-ын электрон сэтгүүл, 9-р боть, дугаар 2, 2004 оны 12-р сар, хуудас 48. <http://www.usinfo.state.gov/journals/itsv/1204/ijse/ijse1204.htm>

Америкийн дээд боловсрол ба АНУ-д суралцах тухай нэмэлт материалыг дараах online хэвлэлээс “Хэрэв та АНУ-д суралцахыг хүсч байгаа бол” гэсэн цуврал /Вашингтон ДС, 2003-2004/-аас харна уу.

- Магистр, докторын сургалт / Graduate Study: <http://www.educationusa.state.gov/graduate/biblio.htm>

- АНУ-д амьдрах нь / Living in the U.S.: <http://www.educationusa.state.gov/life.htm>

- Эрдэмтэн, ШУА нарт мэргэжил, эрдэм шинжилгээний ажлын талаар ахих боломжийн тухай / Opportunities-for-Scholars: <http://www.educationusa.state.gov/scholars/biblio.htm>

- Замд гарахын өмнөх мэдээлэл / Predeparture-Information: <http://www.educationusa.state.gov/predeparture/biblio.htm>

- Нарийн мэргэжлийн сургалт / Specialized-Professional-Study: <http://www.educationusa.state.gov/professional/biblio.htm>

- Богино хугацааны сургалт / Short-Term Study: <http://www.educationusa.state.gov/study/biblio.htm>

- Бакалаврын зэргийн сургалт / Undergraduate-Study: <http://www.educationusa.state.gov/undergrad/biblio.htm>

ИНТЕРНЭТИЙН ЭХ СУРВАЛЖУУД

АНУ-ын дахь их, дээд сургууль, коллежийн тухай мэдээлэл бүхий сонирхолтой веб сайтууд

АНУ-ын Төрийн Департамент

Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн хороо

АНУ дахь боловсрол /Education USA/ сайт.

<http://www.educationusa.state.gov/>

“АНУ дахь дээд боловсролын тухай таны гарын авлага” нэртэй EducationUSA сайт нь гадаадын оюутнуудад АНУ-д суралцах коллежоо эрж хайхад бүх үе шатны мэдээлэл, үйлчилгээний тухай арвин мэдээлэл олгодог. Зөвлөлгөө, мэдээлэл өгөх 450 гаруй төвүүдээс бүрдсэн том сүлжээ нь [<http://www.educationusa.state.gov/centers.htm>] 170 оронд байгуулагдаж, АНУ-д дээд боловсрол эзэмшихийг уриалж байна. АНУ-д боловсрол эзэмших боломжийн тухай хамгийн сүүлийн үеийн бүрэн дүүрэн оновчтой үнэн зөв мэдээллийг дэлхий даяар түгээж, мэргэшсэн хувь хүмүүст энэхүү боломжийг хэрхэн зөв ашиглах тухай заавар зөвлөмж өгч байна.

Вэб сайтын тодорхой хэсгүүдээс боловсролын магадлан итгэмжлэл, суралцах сургуулиа хэрхэн олох, визийн мэдээлэл, санхүүгийн тусламж, Фуллбрайтын нэрэмжит сургалтын цалин ба Төрийн Департаментын Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн хорооны хөтөлбөрүүдийн тухай мэдээлэл авч болно.

Олон улсын боловсролын долоо хоног, 2005. <http://iew.stte.gov/>

Олон улсын боловсрол ба харилцан солилцоог сурталчлах, алдаршуулах талаар АНУ-ын Төрийн Департамент ба АНУ-ын Боловсролын Департаментын хамтын идэвхи санаачлагын тухай

Олон улсын мэдээллийн хөтөлбөр

АНУ-д суралцана уу

http://usinfo.state.gov/scv/life_and_culture/education/study_in_the_us.html

Консулын газрууд – визийн тухай

http://travel.state.gov/visa/visa_1750.html

АНУ-д суралцах нь – Виз

<http://www.unitedstatesvisas.gov/studying.html>

АНУ-ын Боловсролын департамент

Боловсролын тухай мэдээллийн сүлжээ - USNEI: U.S. Network for Education Information

<http://www.ed.gov/about/offices/list/ous/international/usnei/edliteindex.html>

Гадаад солилцооны хөтөлбөрт хамрагдсан оюутнуудад америкийн боловсролын системийн талаар мэдээлэл өгөх суурь эх сурвалж

A basic resource on the U.S. educational system created to inform international exchange students.

Холбооны /засгийн газрын/ оюутны тэтгэлэг - гадаад оюутнууд

Federal Student Aid: International Students

<http://studentaid.ed.gov/PORTALSWebApp/students/english/intl.jsp>

Коллежийг интернегээр хайж олох сайт - IPEDS College Opportunities Online

<http://nces.ed.gov/ipeds/cool/index.asp>

Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудаас явуулж буй бүрэн дунд боловсролын дараах сургалтын мэдээллийн сангийн алба

Office of Postsecondary Education Database of Accredited Institutions

<http://ope.ed.gov/accreditation/>

Америкийн иргэншил ба цагаачлалын алба

АНУ-д хэрхэн дээд сургуулийн оюутан болох тухай

How Do I Become an Academic Student in the United States?

<http://uscis.gov/graphics/howdoi/academic.htm>

Америкийн дуу хоолой

Америкийн коллежийн дэлхийг хамарсан форум

America's Global College Forum

http://www.voanews.com/english/AmericanLife/global_college_forum.cfm

Долоо хоног бүрийн энэхүү радио цуврал нь Америкийн коллеж, их сургуульд суралцаж буй гадаад оюутан нэг хүнийг сонсогчиддоо танилцуулдаг

Цагаан ордон

Испани хэлтэн америк иргэдийн боловсролыг чанаржуулах тухай санаачлага

Initiative on Educational Excellence for Hispanic Americans

<http://www.yic.gov>

Хар арьстнуудын түүхэн коллеж ба их сургуулиудын талаарх санаачлага

Initiative on Historically Black Colleges and Universities

<http://www.ed.gov/about/inits/list/whhbcu/edlite-index.html>

Омгийн коллеж, их сургуулиудын талаарх санаачлага

Initiative on Tribal Colleges and Universities

<http://www.ed.gov/about/inits/list/whhc/edlite-index.html>

Бусад эх сурвалж

Америкийн орон нутгийн коллежийн холбоо

<http://www.aacc.nche.edu/>

Америкийн боловсролын зөвлөл – АБЗ / American Council on Education -ACE

<http://www.acenet.edu/AM/Template.cfm?Section=Home>

Дээд боловсролын үндэсний байгууллагуудыг зохион байгуулагч АБЗ нь олон улсын шинэ санаачлагыг ивээн тэтгэдэг.

<http://www.acenet.edu/AM/Template.cfm?Section=International>

Америкийн индианчуудын дээд боловсролын консорциум

<http://www.aihec.org/>

Америк – Дундад дорно бүсийн боловсрол сургалтын алба AMIDEAST, America-Mideast Educational and Training Services, Inc.

<http://www.amideast.org/>

Америкийн коллеж, их сургуулиудын холбоо

<http://www.aacu-edu.org/>

Сургуулийн хотхон кампусын гэрээ / Campus Compact

<http://www.compact.org>

Нийгэд тустай хөдөлмөр эрхлэх, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарлах ба дээд сургуульд суралцахын хажуугаар олон нийтийн төлөө ажил эрхлэхийг сурталчилж дэмжиж байдаг Коллеж, их сургуулиудын ерөнхийлэгч нарын үндэсний эвсэлийн сайт

Дээд боловсролын магадлан итгэмжлэх зөвлөл / CHEA: Council for Higher Education Accreditation

<http://www.chea.org/>

Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага, хөтөлбөрүүдийн мэдээллийн сан / Database of accredited institutions and programs:

<http://www.chea.org/search/default.asp>

Дээд боловсролын он дарааллын бичиг / The Chronicle of Higher Education

<http://chronicle.com/>

Захиалгаар түгээдэг, үнэгүй материал ховор олддог:

<http://chronicle.com/free/>

Коллежиудын асуудал эрхэлсэн хороо / College Board

<http://www.collegeboard.com/splash>

АНУ-ын орон нутгийн коллежууд / Community Colleges USA

<http://www.cc-usa.org/>

Бие даасан коллежуудын зөвлөл / Council of Independent Colleges

<http://www.cic.org/>

Олон улсын оюутан солилцооны зөвлөл / Council on International Educational Exchange (CIEE)

<http://www.ciee.org/>

Боловсролын паспорт / eduPASS!

<http://www.edupass.org/>

Дээд боловсролын нөөцийн төв / Higher Education Resource Hub

<http://www.higher-ed.org/>

Испани хэлтний коллеж, их сургуулиудын холбоо / Hispanic Association of Colleges and Universities

<http://www.hacu.net/>

Олон улсын боловсролын институт / Institute of International Education

<http://www.iie.org/>

Дээд боловсролд тэгш эрх эдлэхийн төлөө үндэсний эвсэл

NAFEO: National Association for Equal Opportunity in Higher Education

<http://www.nafeo.org/about.htm>

Олон улсын багш нарын холбоо / NAFSA: Association of International Educators

<http://www.nafsa.org/>

Улсын их сургууль ба улсаас олгосон газар бүхий коллежуудын үндэсний холбоо / National Association of State Universities and Land-Grant Colleges

<http://www.nasulgc.org/>




Austin Web U.S. Higher Education сайтаас Техасын их сургуулийн тухай танилцаж болно

<http://www.utexas.edu/world/univ/>




Стив Хелбер, AP/WWWP

Виржиниагийн Политехникийн дээд сургууль ба Улсын Их сургуулийн хоорондын тэмцээнийг үзэж, дэмжих гэсэн хүмүүс цэнгэлдэх хүрээлэнд олноор цугларсан байдал нь коллеж сургуулиудын биеийн тамирын арга хэмжээ, тэмцээнүүдийг олон нийт маш их сонирхдогийг харуулж байна.



**A
NEW JOURNAL
APPEARS EACH
MONTH
IN DIFFERENT
LANGUAGE
VERSIONS**



**REVIEW THE FULL LISTING OF TITLES AT
<http://usinfo.state.gov/journals/journals.htm>**



<http://usinfo.state.gov/journals.htm>

АНУ-ын Төрийн Департамент / Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн товчоо